

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2014 ОНЫ I УЛИРЛЫН
ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ**

2014 он

АГУУЛГА

| № | Тогтоолын тэргүү | Огноо, дугаар | Хуудасны дугаар |
|----|---|-------------------|-----------------|
| 1 | Улсын Сайн малчинд тодорхойлох тухай | 2014.01.02, №01 | 4 |
| 2 | Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай | 2014.01.15, №04 | 5 |
| 3 | Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны төлбөр тогтоох тухай | 2014.02.07, № 10 | 6 |
| 4 | Журам батлах тухай | 2014.02.07, № 12 | 7 |
| 5 | Нөхөн сонгууль зарлах тухай | 2014.02.22, № 20 | 11 |
| 6 | Журам батлах тухай | 2014.02.22, № 21 | 12 |
| 7 | Дүрэм батлах тухай | 2014.02.22, № 22 | 15 |
| 8 | Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай | 2014.02.22, № 25 | 18 |
| 9 | Иргэний зөвлөлийг томилох тухай | 2014.02.22, № 28 | 19 |
| 10 | Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлах тухай | 2014.02.22, № 31 | 21 |
| 11 | Тайлангийн тухай | 2014.02.22, № 32 | 87 |
| 12 | Малчдын бүлэг ажиллуулах журам батлах тухай | 2014.02.22, № 33 | 88 |
| 13 | Төлөвлөгөө батлах тухай | 2014.02.22, № 36 | 92 |
| 14 | Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай | 2014.03.19, № 37 | 101 |
| 15 | Эрүүл мэндийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай | 2014.03.19, № 43 | 103 |
| | Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай | 2014.03.17, № 8/1 | 107 |
| | Төсөвт тодотгол хийх тухай | 2014.03.17, № 8/2 | 108 |
| | Концессын зүйлийн жагсаалт батлах тухай | 2014.03.17, № 8/3 | 111 |
| | Журам батлах тухай | 2014.03.17, № 8/4 | 113 |
| | | | |





**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.01.02

№01

Номгон

Улсын Сайн малчинд тодорхойлох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, “Улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч” шалгаруулах журмын 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын сайн малчны болзол хангасан Жинст сумын Уу-булан 1 дүгээр багийн малчин Жамбалдорж овогтой Баатарсүрэн, Бөмбөгөр сумын Хөх толгой 2 дугаар багийн малчин Галсанпунцаг овогтой Тогтохбаяр, Гурванбулаг сумын Хөвийн ам 4 дүгээр багийн малчин Сосор овогтой Баттөр нарыг Монгол Улсын “Сайн малчин” цолоор, Баянхонгор сумын тариаланч Чулуун овогтой Мөнхбаатарыг “Улсын тэргүүний тариаланч”-аар шагнуулахаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд уламжилсугай.

Хоёр. Нэр бүхий хүмүүсийн материалыг холбогдох байгууллагад хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.01.15

№04

Номгон

Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Баянхонгор аймгийн Есөнбулаг багийн нутаг дэвсгэрт 150 хүүхдийн орон тоо бүхий 11 дүгээр цэцэрлэгийг үүсгэн байгуулсугай.

Хоёр. Шинээр байгуулагдаж буй 11 дүгээр цэцэрлэгт хавсралтад заагдсан хөрөнгийг эзэмшүүлсүгэй.

Гурав. Цаашид тус цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангахад анхаарч, хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

Дөрөв. Эзэмшүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн цахим санд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.07

№ 10

Номгон

**Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны
төлбөр тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг түр саатуулах журам”-ын 22 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны хоногийн хураамжийг бүх төрлийн тээврийн хэрэгсэлд 4000 /дөрвөн мянган/ төгрөг, мотоцикльд 2000 /хоёр мянган/ төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны хураамжийг байрны үйлчилгээ, ахуйн нөхцөлийг сайжруулах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчийн орон тоог гарган цалинжуулахад зарцуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Оюутболд/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.07

№ 12

Номгон

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дах заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 4D эхо оношилгооны кабинетийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. 4D эхо оношилгооны кабинетийг батлагдсан журмын дагуу ажиллуулахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга /Д.Бямбасүрэн/-д даалгасугай.

Гурав. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

4D эхо оношилгооны кабинетийн ажиллах журам

Зорилго: Аймгийн нэгдсэн эмнэлгийн оношилгоо эмчилгээнд сүүлийн үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлснээр орон нутгийн үйлчлүүлэгчдийг өндөр хүчин чадалтай ЭХО оношилгооны үзлэг шинжилгээнд хамруулж нотолгоонд суурилсан, оношилгоо эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэн, чирэгдлийг бууруулахад оршино.

Зорилт: - Үйлчлүүлэгчийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, 3 дахь шатлалд илгээж оношилгоо хийлгэх явдлыг бууруулах, иргэдэд учирч байгаа чирэгдэл хүлээгдлийг багасгах

-Тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлж, эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах

Үзлэг хийх дэс дараалал:

Үзлэгийг ЭХО оношилгооны мэргэжлийн эмч нар батлагдсан журмын хавсралтанд заасны дагуу явуулна.

Онцгой шаардлагатай өвчтөнд эмч нарын ажиллах хуваарийн дагуу үзлэгт хамруулна.

Төлбөртэй үзлэгт өвчтөн тус бүрт стандарт хугацааг баримталж хийх болон тухайн өвчтөний үзлэгийн талаар Эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх цаг хугацаа хангалттай байхаар үзлэг явагдана. Нэг өвчтөнд үзлэг хийх хугацаа 15-20 минут байна.

Анхаарах зүйл:

Эмч нар батлагдсан хуваарийн дагуу үзлэг хийнэ.

Оношилгооны Medison3 A30 аппаратыг техникийн ажиллагааг үзлэг хийж буй 1 их эмч, тоног төхөөрөмжийн инженертэй хамтран хариуцан ажиллаж хүлээлцэнэ.

Стандартын дагуу үзлэг хийнэ.

A30 аппаратны талаар үйлдлийн алдаа гарахад тухайн нийлүүлсэн компаний техникийн инженертэй байнга холбоотой ажиллах, арга зүйн зөвлөмж авч байх

Үзүүлэлт өндөртэй тухайн оношилгооны аппаратын хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглахын тулд эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшлийн болон техник үйл ажиллагааны сургалтанд, инженер техникийн ажилтныг мөн тасралтгүй сургалтанд хамруулж мэргэшүүлж байх

Үзлэгт шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тасралтгүй ханган ажиллахыг аж ахуйн дарга хариуцна.

Батлагдсан журамд заагдсанаас бусад цагт эмч нар төлбөртэй болон бусад үзлэг хийхийг хориглоно. Үзлэг хийсэн тохиолдолд хариуцлага тооцно.

Төлбөртэй үйлчилгээ:

Батлагдсан журмын дагуу тарифаар үйлчилнэ.

Төлбөрийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулна.

Төлбөртэй үйлчилгээний 30 хувийг тухайн оношилгооны үзлэгийн хэрэглэгдэхүүн, кабинетын стандарт хэвийн үйл ажиллагаа, мөн оношилгоо хийж буй эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн давтан сургалтанд зарцуулна, 70 хувийг дараагийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж худалдан авахад хуримтлуулна.

Хөнгөлөлттэй оношлуулах нөхцөл:

Эрүүл мэндийн төвүүдэд 2 жилээс дээш хугацаагаар идэвхи, санаачлагатай ажиллаж байгаа “Сайн санааны идэвхтэн”-үүд жилд 1 удаа үнэ төлбөргүй оношлуулах. (Тухайн жил бүр ЭМГ-с эрхийн бичгийг ЭМТ-ийн тодорхойлолтыг үндэслэн олгоно. Хөнгөлөлтийг зөвхөн хүчин төгөлдөр үнэмлэх, эрхийн бичгийн хамт эдлэх боломжтой)

60-аас дээш настай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр үйлчилнэ. /Өрхийн эмчийн тодорхойлолттой байна./

Дэлхийн Зөн Баянхонгор 1 болон 2 хөтөлбөрүүдэд бүртгэлтэй хүүхэд, түүний асран хамгаалагчид нь зайлшгүй шаардлагаар үзүүлэх бол жилд 1 удаа 50 хувийн хөнгөлөлттэй оношлуулах (Хөнгөлөлтийн бичгийн ДЗ салбараас хүүхдийн системд орсон мэдээллийг үндэслэн олгоно. Хөнгөлөлтийг зөвхөн хүчин төгөлдөр 3 өнгийн Карт, эрхийн бичгийн хамт эдлэх боломжтой)

Хяналт:

Кабинетын эмч, чанарын менежер, тасгийн эрхлэгч үйл ажиллагааг хянана.

.....оОо.....

ҮЗЛЭГИЙН ХУВААРЬ, ОНОШИЛГООНЫ ТАРИФ

| № | Үзлэг хийх мэргэжилтэн | Хийгдэх оношилгоо | Хийгдэх хуваарь | Төлбөр |
|---|--|---|---|------------|
| 1 | Эх барих эмэгтэйчүүдийн их эмч | Ургийн гажгийн үзлэг оношилгоо /18-21 долоо хоногтойд/ | Мягмар гариг 14 ⁰⁰ -16 ⁰⁰ | 20,000 төг |
| | | Жирэмсэн эхчүүдийн үзлэг | Даваа, Пүрэв гариг 13 ⁰⁰ -16 ⁰⁰ | 20,000 төг |
| | | Эмэгтэйчүүдийн үзлэг | Баасан, Бямба гариг 14 ⁰⁰ -16 ⁰⁰ | 15,000 төг |
| 2 | Эх барих эмэгтэйчүүдийн их эмч, ЭХО оношилгооны их эмч | Давтан үзлэг /Бүх төрлийн/ | Хуваарийн дагуу | 10,000 төг |
| 3 | ЭХО оношилгооны их эмч | Хэвлийн хөндийн эрхтний оношилгоо /доплертой/ | Даваа,Мягмар, Лхагва, Баасан гариг 08 ⁰⁰ -12 ⁰⁰ | 20,000 төг |
| | | Бамбай булчирхайн оношилгоо /доплертой/ | Лхагва гариг 13 ⁰⁰ -17 ⁰⁰ | 10,000 төг |
| | | Хүүхдийн зулайн ЭХО оношилгоо | Пүрэв гариг 08 ⁰⁰ -10 ⁰⁰ | 10,000 төг |
| | | Хөхний оношилгоо /доплертой/ | Пүрэв гариг 10 ⁰⁰ -12 ⁰⁰ | 15,000 төг |
| | | Судасны оношилгоо 1.Мэдрэлийн эмгэгүүд цус харвалтууд 2.Зүрх судасны эмгэгүүд / флебитүүд, тромбоз/ | | 20,000 төг |
| | | Хэвлийн хөндийн хурц үрэвслүүдийн оношилгоо /мухар олгой, түгжрэл, буглаа г.м./ | | 20,000 төг |
| | | Цуллаг эрхтний буглаа, киста, бэтэг зэрэгт гуурс тавих | | 30,000 төг |
| | | Зүрхний ЭХО оношилгоо | | 30,000 төг |

.....оОо.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 20

Номгон

Нөхөн сонгууль зарлах тухай

Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг Баянбулаг суманд 2014 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Ням гаригт явуулсугай.

Хоёр. Нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Гурав. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуульд нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 10 00000 /арван сая/ төгрөгөөр тогтоосугай.

Дөрөв. Нөхөн сонгуулийг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж ажиллахыг аймгийн Сонгуулийн хорооны дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

Тав. Нөхөн сонгууль явуулах зардлыг Орон нутгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 21

Номгон

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Элсэлтийн ерөнхий шалгалтанд сурагчдыг амжилттай бэлтгэж оролцуулсан багшийг шалгаруулах болзол журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Амжилттай бэлтгэж оролцуулсан багшийг болзол, шалгуур журмын дагуу шагнаж урамшуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

Гурав. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАНД СУРАГЧДЫГ АМЖИЛТТАЙ БЭЛТГЭЖ ОРОЛЦУУЛСАН БАГШИЙГ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ ЖУРАМ

Зорилго: Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх ажлын чанарыг сайжруулж, түвшинг ахиулах, амжилт гаргасан багшийг дэмжиж, урамшуулахад оршино.

Болзол нь: Багш заадаг хичээлээрээ болон сургуулийн захиргааны зохион байгуулснаар Элсэлтийн ерөнхий шалгалтанд сурагчдыг бэлтгэж, оролцуулан дараах болзлыг хангасан байна. Үүнд:

1. Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэсэн хүүхдүүд нь багшийн өөрийнх нь сургуулийн сурагч байх /өөр сургуулийн болон өмнө нь төгссөн хүүхэд бэлтгэхийг хориогүй ч энэхүү болзолд хамаарахгүй/
2. Элсэлтийн ерөнхий шалгалтанд тухайн хичээлээр шалгалт өгөхөөр бүртгүүлсэн 20-иос доошгүй сурагчийг бэлтгэж оролцуулах
3. Бэлтгэсэн хүүхэд бүр нь 400-аас дээш /400 орохгүй/ оноо авсан байх
4. Бэлтгэсэн хүүхдүүдийн 20-иос доошгүй хувь нь 700-аас дээш оноо авсан байх
5. Бэлтгэсэн хүүхдүүдийн Элсэлтийн ерөнхий шалгалтанд авсан онооны дундаж нь тухайн хичээлийн улсын дунджаас 50-иас доошгүй оноогоор илүү байх
6. Хичээл заадаг багшийн хувьд хүүхэд өөр багш сонгож бэлтгэл хийсэнтэй холбогдуулж түүнд ямар нэг дарамт шахалт учруулаагүй байх

Болзол хангасан багш нараас дээд амжилт тогтоосон 1 багшийг шалгаруулах бөгөөд ингэхдээ болзол хангалтын оноон дээр өөрөө 11 дүгээр ангид мэргэжлийн хичээлээ заадаггүй бол 50 оноо, 20-иос илүү гарсан хүүхэд бүрийн тоогоор тус бүр 2 оноо нэмж, байр эзлүүлнэ.

Болзлыг дүгнэх, шалгаруулах бэлтгэл үйл ажиллагаа

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлийн дагуу сурагчдын бэлтгэлийг хангах, энэхүү болзлыг хангасан багшийг шалгаруулахтай холбогдсон дараах үйл ажиллагааг сургуулийн захиргаа зохион байгуулна.

- Тухайн хичээлээр Элсэлтийн ерөнхий шалгалтанд орох бүх хүүхдийг шалгалтад бэлтгэх ажлыг хичээл заадаг болон мэргэжлийн бусад багшийн оролцоотой зохион байгуулах
- Тухайн хичээлээр Элсэлтийн ерөнхий шалгалтанд орох хүүхэд, тэдгээрийг бэлтгэх багшийг нэрээр нь гаргаж, багш сурагчийн гарын үсгээр баталгаажуулан 5 дугаар сарын 1-ний дотор аймгийн Боловсролын газарт

ирүүлэх. /Ингэхдээ бэлтгэх багш нь хичээл заадаг байхыг чухалчлах ёстой боловч хүүхэд өөр багш сонгож бэлтгэж байгаа бол тэр багшид нь хариуцуулж, 1 хүүхдийг 1 багш бэлтгэхээр зохицуулах хэрэгтэй./

- Болзолд сургалтын төвийн багш хамаарахгүй.

Болзлыг дүгнэх үйл ажиллагаа

1. Болзол хангасан багш нарыг сургуулийн захиргаа дараах байдлаар оноо өгч шалгаруулан тодорхойлно.
 - Бэлтгэсэн хүүхдийн тоо /өөрийн сургуулийнхаа/ 20 бол 20 оноо, 20-иос дээш гарсан хүүхэд бүрд нэмж тус бүр 2 оноо
 - Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дунджийг оноо болгох /нэг ч хүүхэд 400-аас доош оноо аваагүй, тухайн хичээлийн элсэлтийн шалгалтын улсын дунджаас 50-иас доошгүй оноогоор дээгүүр байх/
 - 700-аас дээш оноо авсан хүүхдийн эзлэх хувь 20 хувиас дээш бол 5 хувь тутамд нь 40 оноо нэмж өгөх
 - Элсэлтийн ерөнхий шалгалтанд орохдоо өөр багшийг сонгож хичээллэсэн хүүхдэд ямар нэг дарамт шахалт үзүүлсэн эсэхийг тогтоож /яаж тогтоосноо нотлохоор байх/

Дарамт шахалт үзүүлсэн бол багшаас 100 оноо хасах, үзүүлээгүй бол 50 оноо нэмж өгөх

2. Аймгийн Боловсролын газар нь:

- Сургуулийн захиргааны шалгаруулсан тодорхойлолт, болзол хангалтыг нотлох
- Болзол хангаж байгаа багш нарыг шалгаруулах
- Болзол хангасан багш нарыг байр эзлүүлж, дээд амжилт үзүүлсэн багшийг шалгаруулах

Шагнал, урамшуулал:

- Энэхүү болзлыг хангасан багш бүрт 2 сая төгрөг
- Болзлыг хангасан багш нараас тэргүүн байр эзэлсэн багшийг 5 сая төгрөгөөр шагнаж урамшуулна.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 22

Номгон

Дүрэм батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ламын Гэгээний Гон Гандан Дэдлин хийдийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
22 дугаар тогтоолын хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хийд нь Монгол Улсын хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төр сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

1.2 Үүсгэн байгуулагчаас шашны байгууллагыг байгуулах тухай шийдвэр гаргаж дүрмийг баталснаар байгуулагдсанд тооцно.

Хоёр. Оноосон нэр, байршил хаяг

2.1 Оноосон нэр: Ламын Гэгээний Гон Гандан Дэдлин хийд. Монголоор Итгэл төгс баясгалант хийд

2.2 Хаяг: Баянхонгор аймаг, Баянхонгор сум 6 дугаар баг

Э-майл хаяг: gongandantedlin@yahoo.com

Харилцах утас: 70440545, 99180664

2.3 Үүсгэн байгуулсан он, сар, өдөр: 2014.02.22

Гурав. Үйл ажиллагааны зорилго, чиглэл

3.1 Хийд нь ашгийн бус, нийгэмд үйлчлэх, шарын шашны зан үйлийн ёс жаяг, дэгийг өвлүүлэх, хүүхэд залуучууд, нийт сүсэгтний дунд бурхны шашны номыг түгээн дэлгэрүүлэхийг эрхэм болгоно.

3.2 Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ дараахь үйл ажиллагааг явуулна.

3.2.1 Уламжлалт шашны зан үйл болон ёс жаягийг өвлүүлэх зорилгоор лам санваартан сургаж шавилуулах

3.2.2 Аливаа үйл ажиллагааг сүсэгтэн олны тусын тулд явуулах

3.2.3 Бурхны номд суралцах ба судлах сонирхолтой хүүхэд залуучуудад туслах зорилгоор сургалт зохион байгуулах болон бусад олон талт арга хэмжээг зохион явуулах

3.2.4 Ард иргэдийн шашны мэдлэгийг тэлэх болон суралцагчдын сургалтанд зориулж гарын авлага, товхимол, ном бүтээлийг судалгаанд үндэслэн хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах

Дөрөв. Хийдийн бүтэц, хяналтын тогтолцоо

4.1 Хийдийн эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна.

4.2 Удирдах зөвлөлийн гишүүнийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр сонгож батлах ба тэргүүн лам, гэсгүй, да лам гэсэн 3 гишүүнээс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн дарга нь тэргүүн лам байна.

4.3 Удирдах зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.3.1 Хийдийн тэргүүн ламыг сонгох

4.3.2 Хийдийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

4.3.3 Хийдийг өөрчлөн байгуулах

4.3.4 Хийдийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар шийдвэр гаргах

4.3.5 Хийдийн бүтэц зохион байгуулалт, түүний төсвийг батлах

4.3.6 Хийдийн хурлын үйл ажиллагаа ба санхүүгийн зарцуулалтанд хяналт тавих

4.4 Тэргүүн лам хийдийг гадаад дотоодод төлөөлөх, удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах болон хууль гэрээнд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.5 Удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс сайн дураар чөлөөлөгдөх хүсэлтээ удирдах зөвлөлийн хуралд оруулж гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4.6 Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дараахь үндэслэлээр чөлөөлнө.

- Нас барсан

- Зөвлөлийн гишүүнийхээ үүргийг зохих ёсоор биелүүлээгүй

- Монгол Улсын хууль тогтоомж, хийдийн дүрмийг удаа дараа болон ноцтой зөрчсөн

4.7 Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах бөгөөд бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.

4.8 Удирдах зөвлөлийн хурлыг удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр буюу удирдах зөвлөлийн 2-оос доошгүй гишүүний хүсэлтээр зарлан хуралдуулна.

4.9 Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 хувь хуралд оролцсоноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.

4.10 Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байх ба тогтоолд удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.11 Удирдах зөвлөлийн хурал хийсэн тухай бүр хурлын тэмдэглэл хөтөлнө.

4.12 Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсаргана.

4.13 Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.

Тав. Хийдийг өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл

5.1 Хийдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу өөрчлөн байгуулж болно.

5.2 Хийдийг татан буулгасан тохиолдолд хийдийн эд хөрөнгө болон шашны эд зүйлийг ижил төрлийн байгууллага болон шашны төвд өргөнө.

5.3 Хийдийг дараах үндэслэлээр татан буулгана.

- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр
- Хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан

Зургаа. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл, журам

6.1 Хийдийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.2 Хийд нь дүрэмдээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг аймгийн ИТХ-д тухай бүр албан ёсоор мэдэгдэнэ.

Долоо. Хийдийн санхүүжилт

7.1 Хийдийг сүсэгтний хандив тусалцаагаар бүтээн босгосон бөгөөд өвлүүлэх, хувь эзэмших, ашиг харах зэргээр өөрсдийн амьдралд ашиглаж зарцуулахгүй цэвэр шашны өмч болно.

7.2 Хийдийн орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

- Сүсэгтэн олон, аж ахуйн нэг байгууллагын хандив
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого
- Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв болон бусад байгууллагаас олгосон хөрөнгө

7.3 Ашгийн бус үйл ажиллагаанаас хуримтлагдсан мөнгө хөрөнгөөс лам, ажилчдыг цалинжуулах хөдөлмөрийн хөлс, шагнал урамшил олгох, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд лам санваартанг сайн дурын үндсэн дээр хамруулна.

7.4 Хийд нь өөрийн өмчлөлд байгаа эд хөрөнгөөр үүрэг хүлээнэ.

7.5 Санхүүгийн бүртгэл, тайлан тооцоог Монгол Улсын хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан бусад актуудын дагуу хөтөлнө.

.....оОо.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 25

Номгон

Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Монголын бурхны шашны зул, Хамба Номун хан Эрдэнэбандид хутагт Ламын гэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний наймдугаар дүр Данзанжамбалчойжинэнд бат оршил өргөх, говийн бүсийн их хурд наадмыг 2014 оны 07 дугаар сарын 22-26-ны билэгт сайн өдрүүдэд Баянхонгор сумд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

Хоёр. Аймгийн ИТХ-ын дарга, ой зохион байгуулах аймгийн комиссын дарга /Д. Ширмэн/-д даалгах нь:

1. Ойн бэлтгэл ажлыг эртнээс сайтар зохион байгуулж ажилласугай.
2. Ойн бэлтгэл, зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөг 2014 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд, ой зохион байгуулсан ажлын тайланг мөн оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлсүгэй.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 28

Номгон

Иргэний зөвлөлийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасныг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Иргэний зөвлөл нь бүрэн эрхийнхээ хүрээнд Цагдаагийн газрын төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонсох, цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилд хяналт тавих, тэдгээртэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд улирал бүр танилцуулж ажиллахыг “Иргэний зөвлөл”-ийн даргад үүрэг болгосугай.

Гурав. Орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийн төсөв, гишүүдэд олгох урамшууллыг жил бүрийн төсвөөс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог нэр | Ажиллах хугацаа |
|----------|-----------------------------|------------------------|
| 1 | Батболдын Лхамноржин | 1 жил |
| 2 | Жамцын Ихбаяр | 2 жил |
| 3 | Баасанжаргалын Булганбаатар | 2 жил |
| 4 | Өөдөсийн Амаржаргал | 3 жил |
| 5 | Пунцагийн Пүрэв | 3 жил |

.....оОо.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 31

Номгон

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аялал жуулчлалын тухай хуулийн 18-р зүйлийн 18.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 4 дэх заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.7 дугаар заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Баянхонгор аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн жил жилийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

**БАЯНХОНГОР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ
2013 – 2020 ОН**



| | |
|--|----|
| Товч танилцуулга | 8 |
| I. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого ба стратеги | 10 |
| 1.1 Аялал жуулчлалын хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зарчим | 10 |
| 1.2 Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага | 11 |
| 1.3 Баянхонгор аймгийн хөгжлийн бодлого ба аялал жуулчлалын хөгжлийн асуудал | 15 |
| II. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдал | 22 |
| 2.1 Аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал | 22 |
| 2.2 Аялал жуулчлалын орчны давуу болон сул тал, аялал жуулчлал хөгжүүлэх боломж болон аюул занал | 28 |
| 2.3 Аймгийн аялал жуулчлалын хөгжлийн гол бэрхшээл, үндсэн асуудлууд | 31 |
| III. Аялал жуулчлалын хөгжлийн ирээдүй | 34 |
| 3.1 Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ, зах зээл | 34 |
| 3.2 Аялал жуулчлалын өсөлтийн хувилбарууд | 36 |
| IV. Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөө төслүүд | 39 |
| 4.1 Аялал жуулчлалын хөгжлийн зорилго, зорилтууд | 39 |
| 4.2 Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепц | 40 |
| 4.3 Тэргүүлэх төслүүд | 46 |
| 4.4 Үйл ажиллагааны төлөвлөгөө | 47 |
| V. Хэрэгжүүлэлтийн үндсэн зөвлөмжүүд | 54 |
| 5.1 АЖ-ын хөгжлийн зөвлөлийг байгуулах | 54 |
| 5.2 Аймагт аялагч, жуулчин байршуулах төрлүүдийг хөгжүүлэх | 55 |
| 5.3 Судалгаа ба сургалт | 58 |
| 5.4 Маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх | 59 |
| 5.5 Аялал жуулчлалын хүчин чадлын даацыг тодорхойлох | 66 |
| 5.6 Аялал жуулчлалын бүс нутаг дахь зам, аяллын гол үзмэрүүдийг тэмдэгжүүлэх | 68 |
| 5.7 Хамтын ажиллагаа | 71 |
| 5.8 Хяналт, үнэлгээ | 76 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------|--|
| АИТХ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| АЖ | Аялал жуулчлал |
| АЖБССТ | Аялал Жуулчлалын Боловсрол Сургалт, Судалгааны Төв |
| АЖҮТ | Аялал Жуулчлалын Үндэсний Төв |
| АЖХЧ | Аялал Жуулчлалын хүчин чадал |
| АЗДТГ | Аймгийн Засаг Даргын Тамгын Газар |
| АССАЖГ | Аймгийн Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Газар |
| БОГ | Байгаль Орчны Газар |
| БЦГ | Байгалийн Цогцолбор Газар |
| ДЦГ | Дархан Цаазаат Газар |
| МАЖХ | Монголын Аялал Жуулчлалын Холбоо |
| НИТАЖ | Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Аялал Жуулчлал |
| ОУ | Олон улс |
| ССАЖЯ | Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яам |
| УЦУГ | Ус Цаг Уурын Газар |
| UNWTO | НҮБ-ын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага |
| WEF | Дэлхийн Эдийн Засгийн Форум |

ЗУРАГ, ХҮСНЭГТ

| | |
|------------|--|
| Зураг 1 | Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний ерөнхий бүтэц |
| Зураг 2 | Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зарчим |
| Зураг 3 | ДНБ-д салбарын эзлэх хувь |
| Зураг 4 | Хөрөнгө оруулалт /сая.төгрөг/ |
| Зураг 5 | Малын тоо, төрөл тус бүрээр /мян.толгой/ |
| Зураг 6 | Аймгийн хэмжээнд хураасан ургацын хэмжээ |
| Зураг 7 | АЖ-ын бүсчилсэн хөгжлийн концепц |
| Зураг 8 | Рашаан сувилал, амралтын бүс |
| Зураг 9 | Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүс |
| Зураг 10 | Экологи, аялал жуулчлалын бүс |
| Зураг 11 | АЖ-ын хөгжлийн зөвлөлийн бүтэц |
| Зураг 12 | Шинээр барих зочид буудлын загвар |
| Зураг 13 | Шинээр байгуулах жуулчны баазын загвар |
| Зураг 14 | Жуулчны түр отоглох байрны загвар |
| Зураг 15 | Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд анхаарах асуудал |
| Зураг 16 | Аймгийн АЖ-ын веб хуудсын бүтэц |
| Зураг 17 | Аймгийн АЖ-ын харилцаанд оролцогч талууд |
| Хүснэгт 1 | Монгол улсад ирсэн нийт гадаадын иргэд |
| Хүснэгт 2 | Жуулчдын байршуулах хэрэгслийн өнөөгийн байдал |
| Хүснэгт 3 | Баянхонгор аймгийн сумдын болон багийн тоо |
| Хүснэгт 4 | Аймгийн хүн ам зүйн үзүүлэлт |
| Хүснэгт 5 | Аймгийн эдийн засгийн үзүүлэлт |
| Хүснэгт 6 | Малын тоо, төрөл тус бүрээр |
| Хүснэгт 7 | Малчдын тоо |
| Хүснэгт 8 | Аймгийн хэмжээнд хураасан ургацын хэмжээ, /тн/ |
| Хүснэгт 9 | Жуулчдын тоо, /сүүлийн 5 жилийн байдлаар/ |
| Хүснэгт 10 | Баянхонгор аймгийн нутаг дахь түүх соёлын гол дурсгалууд |
| Хүснэгт 11 | Баянхонгор аймгийн нутаг дахь байгалийн дурсгалт газар |

| | |
|------------|---|
| Хүснэгт 12 | Баянхонгор аймгийн нутаг дахь рашаан, ус |
| Хүснэгт 13 | Салбарын менежмент |
| Хүснэгт 14 | Байгаль, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт |
| Хүснэгт 15 | Хүний нөөцийн хөгжил |
| Хүснэгт 16 | Дэд бүтэц |
| Хүснэгт 17 | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ |
| Хүснэгт 18 | Маркетинг, мэдээлэл сурталчилгаа |
| Хүснэгт 19 | Өрсөлдөх чадварын шинжилгээ |
| Хүснэгт 20 | Жуулчдын өсөлтийн хувилбарууд |
| Хүснэгт 21 | АЖ-ын бүсүүдийн гол онцлог шинжүүд |
| Хүснэгт 22 | АЖ-ын тэргүүлэх ач холбогдолтой төслүүд |
| Хүснэгт 23 | Үйл ажиллагааны төлөвлөгөө |
| Хүснэгт 24 | Санал болгох сургалтын төрлүүд |
| Хүснэгт 25 | Зорин очих газрын даацын үнэлгээ |
| Хүснэгт 26 | Замын тэмдэг, тэмдэглэгээний байршил |
| Хүснэгт 27 | АЖ-ын харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа |

ХАВСРАЛТ

| | |
|-------------|--|
| Хавсралт 1 | Аялал жуулчлалын гол үзмэр, нөөцүүд |
| Хавсралт 2 | Баянхонгор аймгийн төвийн зочид буудлууд |
| Хавсралт 3 | Жуулчны бааз, амралтын газрууд |
| Хавсралт 4 | Аймгийн төвийн томоохон зоогийн газрууд |
| Хавсралт 5 | Аймгийн музейнууд |
| Хавсралт 6 | Баянхонгор аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлаар судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын тур оператор компаниудын жагсаалт |
| Хавсралт 7 | Баянхонгор аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлаар тур операторуудын дунд явуулсан судалгааны ерөнхий дүгнэлт |
| Хавсралт 8 | Аяллын жишиг хөтөлбөр “Буурал түүхийн жимээр” |
| Хавсралт 9 | Аяллын жишиг хөтөлбөр “Хонгор нутгийн гайхамшиг” |
| Хавсралт 10 | Аяллын жишиг хөтөлбөр “Хангайн нутгаар” |
| Хавсралт 11 | Аяллын жишиг хөтөлбөр “Аймгийн төвтэй танилцах” |
| Хавсралт 12 | Замын тэмдэг, тэмдэглэгээний загвар |
| Хавсралт 13 | Аяллын мэдээллийн самбарын загвар |
| Хавсралт 14 | Танилцуулга, мэдээллийн самбарын загвар |
| Хавсралт 15 | Анхааруулах мэдээллийн самбарын загвар |
| Хавсралт 16 | Зочид буудлын жишиг үнэлгээ |
| Хавсралт 17 | Гэр буудлын жишиг үнэлгээ |

ӨМНӨХ ҮГ

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг Аялал Жуулчлалын Боловсрол, Сургалт, Судалгааны Төв (ТББ)-с профессор, доктор Д.Гансүхийн удирдлагаар хийж гүйцэтгэв. Энэхүү төлөвлөгөөг орчин үеийн аялал жуулчлалын судалгаа, төлөвлөгөө боловсруулах арга зүйд үндэслэн Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн Газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэсэн болно.

Мастер төлөвлөгөөг олон улсын болон Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, статистик тоо баримтанд тулгуурлан Баянхонгор аймгийн хөгжлийн стратеги, бодлогод тулгуурлан боловсруулсан болно. Судалгааны үр дүнд Улаанбаатар хотод байрладаг тур операторууд, Баянхонгор аймгийн төр, хувийн хэвшлийн оролцогч талуудын санал, бодлуудыг тусгаж, Баянхонгор аймгийн нутгаар 1500 гаруй километр аялсан хээрийн судалгааны дүнг ашигласан юм.

Энэхүү мастер төлөвлөгөөг боловсруулахад бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Баянхонгор аймгийн засаг дарга Д.Жаргалсайхан болон Соёл, спорт аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Д.Содномсамдан, судалгааны явцад мэдээлэл, саналаа харамгүй ирүүлсэн нутгийн удирдлага, иргэд, Улаанбаатар хотын тур оператор компанийн нийт хүмүүст гүн талархлаа илэрхийлье.

Хонгор нутаг гадаад, дотоодын жуулчдын хүсэн зорих газар нутаг байхын элзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан боловсруулсан бөгөөд зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн болно.

Монгол улсын болон Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн үе шатанд аялал жуулчлалын хөгжлийн байдал, цаашдын бодлого, стратегийг тоймлон үзэх;

Аймгийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийн, өрсөлдөх чадварыг тодорхойлох;

АЖ-ын харилцаанд оролцогч талуудаас авсан судалгаа, аялал жуулчлалын өсөлтийн өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан аялал жуулчлалын хэтийн төлөвийн талаар хувилбар тооцоо боловсруулах;

Аялал жуулчлалын хөгжлийн бүсчилсэн хөгжлийн концепцийг тодорхойлох;

Аймгийн аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлж, аялал жуулчлалын хөгжлийн стратегийг боловсруулах;


Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тэргүүлэх төслүүдийг тодорхойлох;

Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих маркетингийн бодлогыг тодорхойлох;

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн асуудлууд, хэрэгжүүлэх хугацаа, арга замын талаар зөвлөмж боловсруулах;

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг “Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого”, “Баянхонгор аймгийн 2007 – 2015 онд баримтлах эдийн засгийн хөгжлийн стратеги”, “Баянхонгор аймгийн 2012 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон бусад эрх зүйн актуудад нийцүүлэн боловсруулсан болно. Төлөвлөгөө нь нийт 5 бүлгээс бүрдэнэ. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц болон онцлогийг зураг 1 – ээс харж болно.

Зураг 1. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний ерөнхий бүтэц



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ

Аялал жуулчлалын хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зарчим

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх олон улсын туршлага болон олон улсын холбогдох байгууллагуудаас өгч буй нийтлэг зөвлөмжид үндэслэн Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулахдаа эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах тогтвортой хөгжлийн зарчмыг баримталсан болно.

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө нь тогтвортой хөгжлийн дараах зорилтууд ба шалгуур үзүүлэлтийг хангахуйцаар боловсруулагдсан болно. Үүнд:

| |
|--|
| Эдийн засгийн зорилтууд ба шалгуур үзүүлэлтүүд |
| Эдийн засгийн нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болгон тодорхойлох Орон нутгийнхан аялал жуулчлалын үйл ажиллагаанд өргөнөөр оролцож, хамгийн түрүүн ашиг тусыг хүртэх зарчмыг хангах Бүтээгдэхүүний хөгжил ба маркетинг |
| Нийгмийн зорилтууд ба шалгуур үзүүлэлтүүд |
| Орон нутгийнхны оролцоог төлөвлөлт ба шийдвэр гаргахад хангах Нийгмийн нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болгон тодорхойлох Нийгэм-соёлын олон талт, төрөлжилтийг хадгалж, хөгжүүлэх Орон нутгийн соёлд мэдрэмжтэй байх |
| Хүрээлэн буй орчны зорилтууд ба шалгуурууд |
| Хүрээлэн буй орчны нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болгон тодорхойлох Байгалийн нөөцийг тогтвортой хөгжлийн зарчмаар ашиглаж, хог хаягдлыг багасгах, бууруу хэрэглээнээс урьдчилан сэргийлж таслан зогсоох |

Аялал жуулчлал бол дэлхийн хэмжээнд хамгийн хурдацтай өсч буй салбар юм.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “UNWTO World tourism barometer-2011” судалгаанаас үзвэл, 2010 онд Зүүн Ази, Номхон бүс нутгийн жуулчны тооны өсөлт нь дэлхийн дунджаас 2 дахин их байжээ. Үүн дотроо Зүүн Хойд Азийн бүс нутагт жуулчны тоо 2010 онд дунджаар 14 хувиар өссөн бөгөөд орон тус бүрээр харвал, Хятад 9.4 хувь, Япон 27 хувь, Өмнөд Солонгос 13 хувь тус тус нэмэгджээ. Жуулчдын зорин очих газрын ерөнхий төлвийг тодорхойлбол, чиглэлийн хувьд баруун Европоос Зүүн Хойд Азийг чиглэж буй дүр төрх ажиглагдаж байгаа бөгөөд аяллын төрлөөр авч үзвэл, эко аялал, тусгай сонирхлын аялал, түүх, соёлын болон эмчилгээний аялал есөн нэмэгдэх хандлагатай байгаа нь Монголын аялал жуулчлалын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ¹.

Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага

Өнөөдөр аялал жуулчлалын салбар нь дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 10 хувь, худалдаа үйлчилгээний 30 хувь, хөрөнгө оруулалтын 7 хувь, хэрэглээний зардлын 11 хувь, татварын орлогын 5 хувь, экспортын 10 хувийг эзэлж, хөгжлийн хурдцаараа нефть, автомашины үйлдвэрлэлийн дараа гуравдугаарт орж байна[12]. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл дэлхийн эдийн засаг, мөнгөний эргэлтийг хөдөлгөгч нийгмийн хөдөлгүүр нь аялал жуулчлал болж байна. Нөгөөтэйгүүр аялал жуулчлал нь “утгагүй үйлдвэрлэл”, “үл үзэгдэгч экспорт” гэдэг сонгодог утгаараа дэлхий дахинд эрчимтэй хөгжиж байгаа юм.

Хүснэгт 1. Монгол улсад ирсэн нийт гадаадын иргэд

| Нийт гадаадын иргэд | 2009 он | 2010 он | 2011 он | 2012 он |
|---------------------|---------|---------|---------|---------|
| Нийт зорчигч | 464850 | 557414 | 626 993 | 623 838 |
| Үүнээс: Жуулчин | 411640 | 456303 | 457 514 | 475 917 |
| АЗИ НОМХОН ДАЛАЙ | 239704 | 265613 | 277958 | 349439 |
| ЕВРОП | 152783 | 172981 | 157817 | 141842 |
| АМЕРИК | 14179 | 16486 | 19877 | 20590 |
| ОЙРХИ ДОРНОД | 4492 | 618 | 740 | 1010 |
| АФРИК | 482 | 594 | 1113 | 918 |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлалын яамны статистик мэдээ, 2013 он

Статистик мэдээнээс харахад 2010 онд өмнөх онтой харьцуулахад нийт зорчигчийн тоо 19.9%, жуулчдын тоо 10.8%-иар нэмэгдсэн, 2011 оны хувьд 2010 оноос нийт жуулчдын тоо 12.4%, жуулчдын тоо 0.2%-иар нэмэгдсэн бөгөөд 2012 онд өмнөх онтой харьцуулахад нийт жуулчдын тоо-0,5% буюу буурсан боловч жуулчдын тоо нь 4.0%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Жуулчдыг голлох зах зээлийн орноор авч үзвэл жил бүр эхний 5-д дараах орнууд орсон байна. Үүнд: 1-д БНХАУ, 2-т ОХУ, 3-д БНСУ, 4,5-д АНУ, Япон улс орж байна. Түүнчлэн аялал жуулчлалын салбарын орлого жил бүр өсдөг бөгөөд 2012 онд 286,5 сая ам.доллар болжээ.

Хүснэгт 2. Чөлөөт цагаараа аялагчдын аялсан газрыг харуулсан байдал /2002, 2005, 2012 он / (%)

| Аялсан газар | 2002 | 2005 | 2012 |
|--------------|------|------|------|
| Улаанбаатар | М/Б | М/Б | 94,8 |
| Тэрэлж | 39 | 19 | 37 |

БАЯНХОНГОР АЙМАГ

| | | | |
|--------------------------|-----|-----|------|
| Алтай Таван Богд | 8 | 10 | 9,5 |
| Тэрхийн цагаан нуур | 23 | 21 | 11,2 |
| Чингисийн төрсөн нутаг | 8 | 5 | 9,7 |
| Хөвсгөл нуур | 23 | 20 | 22 |
| Хархорин Эрдэнэзуу | 45 | 33 | 38,2 |
| Говь | 40 | 29 | 37 |
| Хөгнөхаан, Баянговь | М/Б | М/Б | 9,2 |
| Амарбаясгалант | М/Б | М/Б | 7 |
| Дорнодын тал | М/Б | 3 | 7,9 |
| Бусад | М/Б | М/Б | 18,6 |
| Аялсан газрын дундаж тоо | 1,8 | 1,4 | 1,2 |

Эх сурвалж: Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгааны тайлан

Чөлөөт цагаараа Монгол оронд аялахаар ирсэн жуулчдын хамгийн их очих дуртай газар нь 2002 онд Тэрэлж (39 %), Хархорин (45 %), харин 2005 онд Хархорин (45%), байсан бол 2012 оны судалгаагаар чөлөөт цагаараа ирсэн жуулчид Хархорин хот, Эрдэнэзуу хийд (38,2%), Говь (37 %), аялах дуртай болжээ.

Хүснэгт 3. Аялагчдын аялсан газруудыг аяллын зорилгоор нь ангилан харуулсан байдал

| Аялсан газар | Амрах | Бизнес зорилгоор | Найз нөхөд, хамаатан садан | Сурах | Ажил | Бусад |
|------------------------|-------|------------------|----------------------------|-------|------|-------|
| Улаанбаатар | 94,8 | 83,6 | 94,3 | 93 | 79,9 | 91 |
| Тэрэлж | 37 | 23,3 | 46,6 | 28 | 27,3 | 42,6 |
| Алтай Таван Богд | 9,5 | 2,1 | 5,7 | 6 | 5 | 5,8 |
| Тэрхийн цагаан нуур | 11,2 | 3,9 | 6 | 8 | 4,3 | 4 |
| Чингисийн төрсөн нутаг | 9,7 | 6 | 9,4 | 5 | 10,1 | 7,2 |
| Хөвсгөл нуур | 22 | 5,2 | 17,1 | 15 | 8,6 | 12,1 |
| Хархорин Эрдэнэзуу | 38,2 | 6,2 | 19,8 | 19 | 8,6 | 16,1 |
| Говь | 37 | 19 | 15,4 | 19 | 49,6 | 23,8 |
| Хөгнөхаан, Баянговь | 9,2 | 2,8 | 3 | 3 | 2,2 | 2,2 |
| Амарбаясгалант | 7 | 1,5 | 2,7 | 5,7 | 2,4 | 2,2 |
| Дорнодын тал | 7,9 | 4,5 | 7 | 3 | 7,2 | 5,4 |
| Бусад | 18,6 | 11,6 | 22,5 | 38 | 15,1 | 2,7 |

Эх сурвалж: Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгааны тайлан

Жуулчдыг байршуулах хэрэгсэл болох зочид буудал, жуулчны баазуудын хүчин чадлын байдлыг хүснэгт 4-т харууллаа.

Хүснэгт 4. Жуулчдын байршуулах хэрэгслийн өнөөгийн байдал / 2011 оны байдлаар/

| Байрны төрөл | Байрны төрлийн тоо | Үүнээс: зэрэглэлтэй | Хүчин чадал /Орны тоо/ | Хүчин чадал /өрөө, гэрийн тоо/ | Нийт ажилчдын тоо |
|--------------|--------------------|---------------------|------------------------|--------------------------------|-------------------|
| Зочид буудал | 375 | 63 | 17406 | 6650 | 9975 |
| Жуулчны бааз | 390 | 82 | 14400 | 3200 | 6500 |

Эх сурвалж: Монголын газарзүй, аялал жуулчлалын холбоо, 2012 он

2011 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 375 зочид буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 63 нь 1-5 одны зэрэглэлтэй, 390 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж

байгаагаас 82 нь зэрэглэлтэй ажээ. Мөн бүртгэлтэй 650 тур оператор үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 84 нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байна. 2011 оны байдлаар аялал жуулчлалын салбар тогтмол болон улирлын шинжтэй нийт 25 мянган ажлын байрыг бий болгожээ. Үүнээс зочид буудлын ажлын байрны тоо 9975, жуулчны баазын ажилчдын тоо 6500, тур операторын ажлын байрны тоо 1950 байсан.

Гадаадаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улс дэлхийд томоохонд тооцогддог аялал жуулчлалын үзэсгэлэн арга хэмжээнд оролцдог. Тухайлбал, Монгол улс Берлиний ITB үзэсгэлэнд 1999 оноос хойш албан ёсоор оролцож байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 204 тоот тогтоолоор 2011 оны үзэсгэлэнд Соёлын түнш орноор амжилттай оролцсон. Үүнээс гадна, Лондон хотноо жил бүрийн 11 дүгээр сард болдог WTM олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, 9 дүгээр сард Япон Улсад зохион байгуулагддаг JATA аялал жуулчлалын үзэсгэлэнд байнга оролцдог.

Монгол Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.2.1.5-д аялал жуулчлалыг 2007-2021 он хүртэл хөгжүүлэх бодлогыг томъёолсон байдаг. Энэ бодлогын хүрээнд, аялал жуулчлалд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэн, аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж, аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх замаар 2015 он гэхэд гадаадын жуулчдын тоог 1 саяд хүргэхээр заасан билээ[1]. Улмаар 2016-2021 оны хооронд аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэн сайжруулах замаар Монголд ирэх жуулчдын тоог хүн амын тоотой тэнцэхүйц болгох зорилгыг дэвшүүлсэн юм.

Мөн Шинэчлэлийн Засгийн Газраас Монгол улсад цаашид “ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ” хөгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна [3].

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО

- Аялал жуулчлалын салбарын бодлогыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх;
- Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг тухайн нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалтаар барьж байгуулахыг дэмжих;
- Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулах;
- Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлэх;


| | | | | | | | |
|---|------|------|------|------|------|------|------|
| Аймгийн төв болон хөдөөгийн хүн амын эзлэх хувь | | 39,4 | 60,6 | 33,6 | 66,4 | 34,9 | 65,1 |
| Өрхийн тоо | 23,0 | 23,2 | | 23,3 | | 23,7 | |

Хүснэгт 7. Аймгийн эдийн засгийн үзүүлэлт

| | | | | |
|-----------------------------|----------|----------|-----------|-----------|
| Үзүүлэлт | 2009 | 2010 | 2011 | 2012 |
| Ажилгүйдлийн түвшин | 0,3 | 3,6 | 5,0 | 3,6 |
| ДНБ /сая.төгрөг/ | 89,333,8 | 80.459.9 | 113.369.4 | 159.720.9 |
| Төсвийн орлого /сая.төгрөг/ | 4.228.6 | 5.379.8 | 7.499.3 | 10.522.6 |


Баянхонгор аймгийн ажилгүйдлийн түвшин нь сүүлийн 4 жилд дунджаар 3,1 % байсан бол энэ нь Монгол улсын дундажаас 6,25 %-иар хангайн бүсийн дундажаас 7,0 %-иар бага байна. Тус аймаг нь ажилгүйдлийнхээ түвшингээр улсын хэмжээнд хамгийн бага түвшинтэй аймаг юм.

Зураг 3. ДНБ-д салбарын эзлэх хувь




Хөрөнгө оруулалт 2009 – 2011 оны хувьд харьцангуй тогтвортой байсан бол, 2012 онд 3.3 дахин нэмэгдсэн бөгөөд аялал жуулчлалын салбарт мөн багагүй хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Зураг 4. Хөрөнгө оруулалт (сая. төг)



Зураг 5. Малын тоо /төрөл тус бүрээр/ (мян. толгой)



Хүснэгт 8. Малын тоо /төрөл тус бүрээр/

| | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|-------|--------|--------|--------|--------|
| Адуу | 127.2 | 101.5 | 110.9 | 127.9 |
| Үхэр | 89.6 | 74.4 | 82.1 | 93.5 |
| Тэмээ | 29.7 | 301. | 30.3 | 34.5 |
| Хонь | 724.8 | 543.8 | 617.6 | 788.6 |
| Ямаа | 1713.3 | 1213.3 | 1397.0 | 1596.3 |

Баянхонгор аймаг нь тэмээн сүргийнхээ тоо толгойгоор улсын хэмжээнд Өмнөговь аймгийн дараа хоёрдугаарт ордог бол ямаан сүргийнхээ тоогоор улсад тэргүүлдэг бөгөөд мал сүргийн бүтцийн хувьд ямааны эзлэх хувь хамгийн өндөр байдаг байна.


Хүснэгт 9. Малчдын тоо (мян)

| | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|-------------|-------|-------|-------|-------|
| Малчдын тоо | 23681 | 22340 | 21547 | 20917 |

Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд малчин өрх болон малчдын тоо жилээс жилд тогтмол буурч байгаа бөгөөд 2009 оноос хойш 2012 он хүртэл даруй 1140 малчин өрх төв суурин газар шилжсэн байна. Энэ нь жилд дундажаар 280 орчим өрх айл амьдралын хэв маяг болон аж ахуй зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж байна гэсэн үг.

Хэдийгээр 2009 оны зуднаас хойш малын тоо толгой төрөл тус бүр дээрээ өсөж байгаа боловч энэ нь нийт малчдын хувьд жигд бус байгаа нь харагдаж байна. Малчин өрхийн тоо жил ирэх тусам багасаж байгаа нь нэг талаар амьжиргааны гол эх үүсвэр болох мал нь тэдний хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц байж чадахгүйгээс төв суурин газар бараадах, нөгөө талаар аймгийн малчин иргэдийн тодорхой хэсэг нь Улаанбаатар луу зах зээлдээ ойртох гэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой юм. Аймгийн эдийн засгийн бүтцэд чухал байр суурь эзлэх өөр нэг салбар бол газар тариалан бөгөөд аймгийн хэмжээнд бэлтгэгдэж буй ургацын хэмжээг зураг 6-д үзүүлсэн болно [7].

Зураг 6. Аймгийн хэмжээнд хураасан ургацын хэмжээ



Хүснэгт 10. Аймгийн хэмжээнд хураасан ургацын хэмжээ (тн)

| | 2009 | 2010 | 2011 | 2012 |
|---------------|--------|--------|--------|--------|
| Үр тариа | 7.5 | 11.7 | 10.9 | 7.6 |
| Төмс | 2494.6 | 2418.6 | 3108.6 | 2645.2 |
| Хүнсний ногоо | 1040.6 | 1218.9 | 1390.1 | 1275.2 |

| | | | | |
|-------------------|-------|-------|-------|-------|
| Тэжээлийн ургамал | 206.0 | 359.0 | 601.0 | 510.0 |
|-------------------|-------|-------|-------|-------|

Аймгийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор мал аж ахуй, газар тариалангаас гадна үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, тэр дундаа аялал жуулчлалыг төрөөс баримталж буй бодлогын хүрээнд хөгжүүлэхийг чухалчилж, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн индексстэй уялдсан хөгжлийн хөтөлбөр, аймгийн 15 жилийн хөгжлийн хөтөлбөр, сонгуульд нэр дэвшсэн намуудын хөтөлбөрийг үндэслэн аймгийн аялал жуулчлал, үйлчилгээний бизнесийг дэмжих бодлогыг тодорхойлсон байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

- 1.3.1. Тээврийн үйлчилгээний авто вокзалыг иж бүрэн цогцолбор болгон өргөтгөж, зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг дулаан гараж, засвар үйлчилгээний газартай болгоно.
- 1.3.2. Баянхонгор сумын нийтийн тээвэр үйлчилгээний сүлжээг бий болгож, иргэдэд бага болон дунд оврын автобусаар тогтмол үйлчилдэг болно.
- 1.3.3. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч, ачаа тээврийн үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд боловсронгуй болгож, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зорчигчийн ая тухыг хангахад онцгой анхаарна.
- 1.3.4. Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн төвийг ашиглалтанд оруулж, бизнесийг бойжуулах, сургалт явуулах, зөвлөгөө өгөх, нэг цэгийн үйлчилгээг бий болгож, үйлдвэрлэл эрхлэх орчныг сайжруулан, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.3.5. Бүх сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулна.
- 1.3.6. Соёл урлагийн үнэт зүйлийн хуулбараар брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдаанд гаргана.
- 1.3.7. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг өнөөгийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж ажиллана.
- 1.3.8. Өвөрхангай аймгийн “Төвхөний хийд-Шаргалжуут рашаан сувилал” маршрутыг нээж, хүрэх замыг сайжруулан жуулчдын урсгалыг орон нутагтаа татна.
- 1.3.9. Жуулчдын сонирхлыг татахуйц гар урлал, бэлэг дурсгал, уран зураг, фото зургийн үйлдвэрлэл, үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 1.3.10. Баянлиг суманд нисэх онгоцны буудал барих асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлнэ.
- 1.3.11. “БАЯНХОНГОР-ЭРЭЭН ХОТ” чиглэлийн олон улсын нислэгийг нээж, агаарын тээврийн “Транзит-Баянхонгор” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.12. Амралт аялал жуулчлалын “Гурван бүс цогцолбор”-ын хүндэтгэлийн хэсэг болох “Эрдэнэмандал хайрхан, хүүхэд залуучуудын парк”-ийг иж бүрэн тохижуулж, амралт чөлөөт цагийн шинэ орчинг бүрдүүлнэ.
- 1.3.13. Аймагт гадаад, дотоодын жуулчдыг татах тур оператор байгуулахыг дэмжиж, бусад тур операторуудтай хамтран ажиллаж жуулчдыг хүлээн авч үйлчлэх материаллаг баазын чанарыг сайжруулж хөгжүүлнэ.
- 1.3.14. Монгол Улсын аялал жуулчлалын сүлжээнд холбогдож, аймгийн аялал жуулчлалын Вэб сайт нээн ажиллуулна.
- 1.3.15. Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын маршрутаар танилцуулга бэлтгэн хэвлүүлж, баримтат кино, аяллын нэвтрүүлэг, клип хийнэ.
- 1.3.16. Шаргалжуутын рашаан сувиллыг түшиглэн амралт аялал жуулчлалын

- цогцолбор байгуулж, үйлчилгээний хүрээг өргөтгөнө
- 1.3.17. Орон нутгийн аяллын маршрутуудыг гарган, хүүхэд, залуучуудыг аялуулж, төрсөн нутаг орноороо бахархах үзлээр төлөвшүүлнэ.
- 1.3.18. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.3.19. Иргэд бүлэг, нөхөрлөл, хоршоо байгуулан, орон нутагтаа байгаа байгалийн үзэсгэлэнт газар, аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ сэргээн тохижуулан, хамгаалж жуулчид хүлээн авч үйлчлэх бизнес хийх боломжийг бүрдүүлнэ.

БАЯНХОНГОР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал

“Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г 2007 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж, энэхүү төлөвлөгөөг үндэслэн дотоод, гадаадын жуулчдыг татах, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор засаг даргын мөрийн хөтөлбөр, жил бүрийн аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, сумдын засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд тодорхой ажлууд тусган хэрэгжүүлээд байна. Аялал жуулчлалын бодлогыг аймгийн түвшинд хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор сум, Эрдэнэцогт, Баян-Овоо, Хүрээмарал, Богд, Өлзийт, Жинст, Бууцагаан, Баацагаан, Галуут, Баянлиг, Жаргалант, Баянцагаан зэрэг сумдууд АЖ-ын хөтөлбөрөө боловсруулж батлуулснаас гадна нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх үзэл баримтлалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсан байна. Аймгийн аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилах, аялал жуулчлалын компаниудтай холбоо харилцаа тогтоох зорилгоор “Mongolia ITF- 2009, 2010, 2011, 2012” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил болгон оролцож сурталчилгааны ажлыг явуулан, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын үйлчилгээний ажилчин, менежерүүдийн мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор “Аймгийн жуулчны үйлчилгээний байгууллагуудын боловсон хүчнийг чадваржуулах”, “Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх” зэрэг зөвлөгөөн, сургалтуудыг жил болгон зохион байгуулж хэвшээд байна². Мөн Баянхонгор хотын амралт аялал жуулчлалын бүсэд “Динозаврын парк, Усан оргилуурын цогцолборууд үйл ажиллагаагаа явуулж байна³”.

Аймгийн аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Баянхонгор аймгийн Аяллын маршрутуудыг шинэчлэн баталгаажуулж, мөн “Баянхонгор аймаг, аялалын хөтөч” гарын авлага ном гарган хэвлүүлсэн бөгөөд хүүхэд, залуучууд орон нутгийн иргэдэд тусгай аяллын хөтөлбөрийг санал болгож багагүй ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Аймгийн аялал жуулчлалын дэд бүтцийн өнөөгийн байдал

Улаанбаатараас Баянхонгор хүртэлх 630 километр замыг бүхэлд нь хатуу хучилттай зам болгох зорилтыг 2013 оны 8 сард багтаан Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж чадсан нь стратегийн хөгжлийн чухал ач холбогдолтой. Баянхонгор Улаанбаатар хотын чиглэлд дотоод Hunnu Airlines компани долоо хоногийн 2 өдөр нислэг хийдэг. Мөн Баянхонгор - Алтай, Алтай – Баянхонгор чиглэлд тус компани нислэг хийдэг.

Дотоод гадаадын жуулчид хүссэн газраасаа интернэтэд холбогддог бөгөөд Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Хүрээмарал, Богд, Бууцагаан зэрэг сумууд шилэн кабельтай холбогдсон учир аялагч, жуулчид нь дэлхийтэй харьцах бололцоотой болж байна.

Дунджаар авч үзвэл, сүүлийн 5 жилд нэг жилд дунджаар 1090 гаруй гадаадын, 9500

² Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө 2007

³ Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөөний явцын биелэлт

гаруй дотоодын жуулчид аялсан байна. Гэхдээ дээрхи статистик дүн мэдээний “бусад” гэсэн хэсгийн тоог гаргасан эх үүсвэр, аргачлал тодорхой бус байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 11. Жуулчдын тоо /сүүлийн 5 жилийн байдлаар/

| № | Жуулчны үйлчилгээний газрууд | 2008 | | 2009 | | 2010 | | 2011 | | 2012 | |
|---|--|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| | | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад |
| 1 | “Мандухай” жуулчны бааз | 250 | 150 | 300 | 100 | 230 | 200 | 356 | 300 | 450 | 350 |
| 2 | “Говийн тэмээ” жуулчны бааз | 65 | 325 | 30 | 225 | | 250 | | 452 | 54 | 210 |
| 3 | “Өхэг” амралтын газар | | | 200 | | 250 | | 520 | | 750 | |
| 4 | “Шаргалжуут” амралт рашаан сувилалын газар | 3200 | 20 | 2500 | | 3200 | | 3456 | 44 | 3950 | 15 |
| 5 | “Өвгөнжаргалант хүүхдийн зуслан | 500 | | 400 | | 460 | | 849 | | 500 | |
| 6 | Бусад | 1200 | 560 | 7000 | 800 | 1600 | 650 | 18346 | 500 | 1500 | 850 |
| | Нийт жуулчдын тоо | 5250 | 1055 | 10430 | 1125 | 5740 | 1100 | 23527 | 1296 | 7204 | 1425 |
| | БҮГД | 6305 | | 11555 | | 6840 | | 24823 | | 8629 | |

Баянхонгор хотод нийтдээ 170 гаруй ор бүхий 11 зочид буудал, 50-100 хүний суудалтай зоогийн газар 20 шахам байна(Хавсралт 2,4).Аймгийн төвийн зочид буудлууд нь нэг ээлжиндээ 284 нь зочин хүлээн авах хүчин чадалтай. Уг зочид буудлууд нь үндсэндээ 2000 оноос хойш байгуулагдсан, тухайлбал сүүлийн дөрвөн жилд Тэргэл, Ньюстарс, Баянхонгор, Жаргалант, Баянбулаг гэсэн 5 буудал ашиглалтанд орж нийт 11 буудал Баянхонгор суманд үйл ажиллагаагаа явуулж байна. Баянхонгор аймгийн хэмжээнд аялал жуулчлалын салбар болон жуулчны үйлчилгээний чиглэлээр 230 хүн ажиллаж байна. Мөн Баянхонгор аймгийн аялал жуулчлалын нөөц газруудыг түшиглэсэн 2 жуулчны бааз, 3 амралт сувилалын газар үйл ажиллагаа явуулж байна (Хавсралт 3). “Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөө” 2007 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж энэхүү ажлын хүрээнд Амралт аялал жуулчлалын Гурван бүс цогцолборын “Динозаврын парк”, “Гавшгайчдын цэцэрлэгт хүрээлэнд баригдсан Усан оргилуур”, аймгийн Түүх угсаатан зүйн музей, байгалийн музей зэрэг газруудад дотоод, гадаадын жуулчид, аймгийн ард иргэд чөлөөт цагаа өнгөрүүлж байна.

Түүх соёл, байгалийн өвүүд болон рашаан үс

Тус аймгийн нутаг нь эртний хүн амьдарч байсан хүн төрөлхтөний өлгий нутгуудын нэг бөгөөд энд эртний түүхэнд холбогдох түүх соёлын дурсгал олон байдаг (товч тайлбарыг 1-р хавсралтанд үзнэ үү).

Хүснэгт 12. Баянхонгор аймгийн нутаг дахь түүх, соёлын гол дурсгалууд

| № | Түүх соёлын дурсгал | Байршил | Хамгаалалтын төрөл |
|---|-----------------------------|---------------------------------|------------------------------|
| 1 | Цагаан агуй | Баянлиг сум, Цахирт уул | Дэлхийн өв, улсын хамгаалалт |
| 2 | Бичигтийн амны хадны зураг | Баянлиг сум, Их баян уул | Улсын хамгаалалт |
| 3 | Бумбатын амны хадны зураг | Заг сум | Улсын хамгаалалт |
| 4 | Гурван мандалын хадны зураг | Бууцагаан сум, Гурванмандал уул | Улсын хамгаалалт |

| | | | |
|----|---|----------------|--------------------|
| 5 | Бугатын хадны зураг | Жаргалант сум | Улсын хамгаалалт |
| 6 | Саалтын агуйн хадны зураг | Баян-Өндөр сум | Улсын хамгаалалт |
| 7 | Гурван мандалын түрэг бичээс | Бууцагаан сум | Улсын хамгаалалт |
| 8 | Шатар чулууны дурсгал | Эрдэнэцогт сум | Улсын хамгаалалт |
| 9 | Шатар чулууны буган хөшөө бүхий дурсгал | Эрдэнэцогт сум | Улсын хамгаалалт |
| 10 | Хачин ламын сүм | Эрдэнэцогт сум | Улсын хамгаалалт |
| 11 | Уран хайрхан уулын чулуун зэвсгийн суурин | Өлзийт сум | Улсын хамгаалалт |
| 12 | Амарбуянтын хийд | Шинэжинэст сум | Аймгийн хамгаалалт |
| 13 | Баянхонгор аймгийн музей | Аймгийн төв | Аймгийн хамгаалалт |
| 14 | Мандалын хийд | Эрдэнэцогт сум | Аймгийн хамгаалалт |
| 15 | Чихэн агуйн чулуун зэвсгийн дурсгал | Баян-Өндөр сум | Аймгийн хамгаалалт |

Хүснэгт 13. Баянхонгор аймгийн нутаг дахь байгалийн томоохон дурсгалт газрууд

| № | Байгалийн дурсгал | Байршил | Хамгаалалтын төрөл |
|---|-------------------|--|--------------------|
| 1 | Бүгийн цав | Шинэжинэст, Баянговь сумдын нутаг | Улсын хамгаалалт |
| 2 | Эхийн гол | Шинэжинэст сум | Улсын хамгаалалт |
| 3 | Цагаан бургас | Баян-Өндөр сум | Улсын хамгаалалт |
| 4 | Их богд уул | Богд, Жинэст, Баянговь, Баянлиг сумдын нутаг | Улсын хамгаалалт |
| 5 | Орог нуур | Богд сум | Аймгийн |
| 6 | Бөөн цагаан нуур | Баацагаан сум | Аймгийн |
| 7 | Галуутын хавцал | Галуут сумын нутаг | Аймгийн |

Тайлбар: Дээрх байгалийн дурсгалт газрууд нь гадаадын болон дотоодын орон нутгийн аялагч амрагч нарын зорин очих боломжтой гол гол газрууд юм.




Бүгийн цав нь Говь гурван сайхны байгалийн цогцолбор газрын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Баянхонгор, Өмнөговь аймгийн нутгийн заагт орших үзэсгэлэнт байгаль бүхий газар юм. Уг газар нь говийн бүс нутгийн онцлогийг илэрхийлэх хэрмэн цав заган ой болон ховор ургамал, ан амьтан бүхий газар

юм.

Эхийн гол нь Говийн их дархан газрын А бүсийн зүүн захад хамаарах монгол орны өмнөд хэсэгт орших байгалийн газар юм. Энэхүү газар нь говь цөлийн хэв шинжийг хадгалсан заган ой, баянбүрд, говийн ховор ан амьтад ялангуяа мазаалай амьдардаг гол бүс нутгийн нэг юм.

Цагаан бургас нь Говийн их дархан газарт хамаарах газар бөгөөд байгалийн хэв шинжийн хувьд Эхийн голтой төстэй газар юм. Иймээс гадаад дотоодын аялагч жуулчдын хувьд Эхийн гол нь үндсэн маршрут чиглэлд илүү ойр газар нутаг юм.



Их богд уул нь Говь-Алтайн нурууны ноён оргил бөгөөд далайн түвшинээс дээш 3957 метр байгалийн цогцолбор газар юм. Уг уул нь байгалийн өвөрмөц тогтоц ховор ан амьтдаар баялагын зэрэгцээ бусад байгалийн үзэсгэлэнт газруудтай хил залган оршдог нь жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг.



Орог нуур нь Их богд уулын хойд талд орших давстай нуур юм.

Бөөн цагаан нуур нь Баянхонгор аймгийн нутаг дахь хамгийн том хэмжээтэй давстай нуур бөгөөд хавар болон намрын улиралд нүүдлийн шувууд олноор цугладаг газар болно.

Галуутын хавцал нь 500 орчим метр үргэлжлэх голын хавцал бөгөөд зуны улиралд дотоодын амрагч нар ойр орчимд нь амарч саатдаг газар юм.

Хүснэгт 14. Баянхонгор аймгийн нутаг дахь рашаан ус

| № | Рашаан ус | Байршил | Ач холбогдол |
|---|--------------------------|----------------|--|
| 1 | Их шаргалжуутын рашаан | Эрдэнэцогт сум | Улсын шинж чанартай сувилалын газар үйл ажиллагаа явуулдаг нэг ээлжиндээ 140-150 хүн хүлээн авах хүчин чадалтай халуун, хүйтэн рашаантай |
| 2 | Бага шаргалжуутын рашаан | Эрдэнэцогт сум | Орон нутгийн шинж чанартай сувилалын газар үйл ажиллагаа явуулдаг нэг ээлжиндээ 50-60 хүн хүлээн авах хүчин чадалтай халуун хүйтэн рашаантай |
| 3 | Холбоож нуур | Богд сум | Өвөрхангай аймгийн Нарийнтээл нутаг дахь рашаанд орсон хүмүүс холбоож нууранд орж гам хийдэг орон нутгийн шинж чанартай амралт сувилал байхгүй |
| 4 | Өхэгийн рашаан | Галуут сум | Орон нутгийн шинж чанартай амралт сувилалын газар одоохондоо байхгүй, байгалийн үзэсгэлэнт газар байрлана |
| 5 | Давст нуур | Баян-овоо | Ерхөөгийн рашаанд орсон хүмүүс ирж гам хийдэг орон нутгийн шинж чанартай рашаан |
| 6 | Өргөөтийн рашаан | Галуут сум | Орон нутгийн шинж чанартай зуны улиралд өдөртөө 40-50 хүн рашаанд тогтмол ордог хувиараа гэрт байршуулах үйлчилгээг рашааны орчимд хүмүүс үзүүлдэг |

2.2. Аялал жуулчлалын орчны давуу болон сул тал, аялал жуулчлал хөгжүүлэх боломж болон аюул занал

Баянхонгор аймгийн хувьд одоогийн нөхцөл байдлын SWOT шинжилгээний тодорхой үзүүлэлтүүд нь Монголын болон Хангайн бүсийн аймгуудын хувьд нийтлэг зүйлүүд олон байгаа болно [10].

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын одоогийн байдлын “SWOT” шинжилгээг:

Салбарын менежмент

Байгаль, соёлын өвийн хадгалалт хамгаалал

Орон нутгийн ба хүний нөөцийн хөгжил

Дэд бүтэц

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн

Маркетинг, сурталчилгаа гэсэн зургаан хэсэгт төрөлжүүлэн 13-18 дугаар хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 15. Салбарын менежмент

| Салбарын менежмент | |
|--|--|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөтэй</p> <p>Аялал жуулчлалын хөгжлийн асуудлыг 15 жилийн бодлогын хөтөлбөрт оруулсан</p> <p>Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний ажилчдаар хангагдах бүрэн боломжтой.</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Аймгийн аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх механизм дутагдалтай</p> <p>Зочид буудал, жуулчны бааз, ресторан, хоолны газруудын мэргэжлийн удирдлага дутагдаж байгаа</p> <p>Аялал жуулчлалын статистик судалгааг явуулах хөрөнгө, хүч хангалтгүй</p> |

Хүснэгт 16. Байгаль, соёлын өвийн хадгалалт хамгаалал

| Байгаль, соёлын өвийн хадгалалт хамгаалал | |
|--|--|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>одоогоос 100-200 сая жилийн тэртээ амьдарч байсан аварга биет диназаворын чулуужсан яс бүхий Бүгийн цав</p> <p>энэ дэлхий дээрх хамгийн эртний хүмүүс амьдарч байсныг нотолсон Цагаан агуй, өөр гариг ертөнцийн оюун ухаантнуудын бүтээл байж болох юм гэж зарим судлаачид тодорхойлдог Цагаан булагийн хадны дүрс зургууд, эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох Бичигтийн хөндийн хадны сүг зургууд бүхий байгалийн галерей</p> <p>энэ дэлхий дээр анх Монгол нутагт шатар үүссэнийг гэрчлэх Шатар чулууны хөшөө дурсгал</p> <p>байгалийн өвөрмөц сонин тогтоцтой, анагаах эдгээх чадвараараа хосгүй 96 хэмийн халуун Шаргалжуутын халуун рашаан</p> <p>дэлхий дээр зөвхөн Баянхонгорын нутагт цөөн тооны байдаг говийн баавгай хэмээх "Мазаалай"</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Байгаль, соёлын өвүүдэд хүрч очиход хүндрэлтэй</p> <p>Байгаль орчин эмзэг экосистемтэй, сүүлийн үед цөлжилт идэвхитэй явагдаж байгаа</p> <p>Өвүүдийн тайлбар мэдээлэл</p> <p>Хамгаалалт муу байгаа тул өвүүд сэргээх ажил хийгддэггүй, харин ч улам муудаж үнэ цэнээ алдах магадлалтай</p> <p>Орон нутгийн тайлбарлагч байхгүй</p> <p>Байгаль, түүхийн өвийг хамгаалах талаар орон нутгийн төр, хувийн хэвшил, малчдын хамтын ажиллагаа хөгжөөгүй</p> |

Хүснэгт 17. Хүний нөөцийн хөгжил

| Хүний нөөцийн хөгжил | |
|---|---|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>Найрсаг зочломтгой, хөдөлмөрч нутгийн ард түмэн</p> <p>Монгол улсын 2 жишиг сум байгуулагдаж байгаа</p> <p>Хот руу шилжих хөдөлгөөн цаашид багасах хандлагатай</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Сумдын ажлын төлөвлөгөөнд аялал жуулчлал, амралт, сувиллын ажлууд хангалтгүй тусгагдсан</p> <p>Үйлчилгээний салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчин уул уурхай, бусад салбарт шилжиж байгаа</p> <p>Аймагт мэргэжлийн хөтөч, жолооч нарын сургалт байхгүй</p> |

Хүснэгт 18. Дэд бүтэц

| Дэд бүтэц | |
|--|---|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>Улаанбаатар хоттой хатуу хучилттай автозамаар холбогдсон</p> <p>Долоо хоногт хоёр удаа агаарын тээврийн нислэгтэй</p> <p>Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ сайжирсан</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Аймаг дотор орон нутгийн зам муу, байгаль цаг уурын байдлаас хамааралтай</p> <p>Замын тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй</p> <p>Гүүр, гармуудыг сайжруулах тэмдэгжүүлэх шаардлагатай</p> |

Хүснэгт 19. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

| Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ | |
|---|---|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>Цаашид стратегийн ач холбогдолтой байгаль, түүхийн өвүүдтэй</p> <p>Байгаль, түүх, соёлын аяллын олон төрлийг хөгжүүлэх нөөц бололцоо их</p> <p>Аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх газруудыг шинээр буюу дахин төлөвлөх бололцоотой</p> <p>Тусгай сонирхлын ба рашаан сувиллын нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн аяллын бүтээгдэхүүнээр баялаг</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Аялал жуулчлалын улирлын хугацаа богино</p> <p>Гэр бааз, түр отоглох цэгүүд хөгжөөгүй</p> <p>Зочид буудал, зоогийн газрууд үйлчилгээний чанар хангалтгүй</p> <p>Сумдын буудлуудыг цоо шинээр зэрэглэж, бүтээгдэхүүн үнийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай</p> <p>Өрсөлдөх чадвараа хөрш зэргэлдээ аймгуудад алдах магадлалтай</p> |

Хүснэгт 20. Маркетинг, мэдээлэл сурталчилгаа

| Маркетинг, мэдээлэл сурталчилгаа | |
|--|---|
| <p><i>Давуу тал ба бололцоо</i></p> <p>Аймгийн аялал жуулчлалын брэндийг гаргахаар ажиллаж байгаа</p> <p>Аймгийн аялал жуулчлалын цахим хуудас боловсруулагдаж байгаа</p> <p>Дотоодын үзэсгэлэн, яармагуудад тогтмол оролцдог болсон</p> | <p><i>Сул тал ба аюул занал</i></p> <p>Төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол мэдээлэл байхгүй</p> <p>Томоохон тур операторууд, аяллын мэдээллийн хэрэгслүүдийг аймагт татах арга хэмжээнүүд явагдаагүй</p> <p>Нутгийн зөвлөлөөс гадаад, дотоодод аймгийг сурталчлах ажлууд хангалтгүй</p> |

2.3. Аймгийн аялал жуулчлалын хөгжлийн гол бэрхшээл, үндсэн асуудлууд

Баянхонгор аймгийн нутгаар аялал зохион байгуулж байсан буюу аяллыг зохион байгуулах боломжтой гэж үзэж байгаа Улаанбаатар хотод байршилтай 25 голлох тур операторуудаас авсан судалгаагаар доорхи дөрвөн гол бэрхшээл, асуудлуудыг нэрлэсэн байна (Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 6-7 үзнэ үү). Үүнд:

Дэд бүтцийн асуудал

Аяллын мэдээллийн хангамж

Орон нутгийн үйлчилгээний чанар

Аймагт хамтран ажиллах байгууллага байхгүй байгаа явдал гэж тодорхойлсон байна.

Эдгээр бүлэг асуудлууд болон судлаачдын тодорхойлсон бусад бэрхшээл, хүчин зүйлүүдийн үнэлгээнүүдээс үзэхэд Баянхонгор аймгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадвар нь хөрш зэргэлдээ Өвөрхангай, Өмнөговь аймгуудаас доогуур байгаа (хүснэгт 19) тул аймгийн аялал жуулчлалын энэхүү мастер төлөвлөгөөнд заагдсан зөвлөмжүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 21. Өрсөлдөх чадварын шинжилгээ

| | Шалгуур үзүүлэлтүүд | Монгол улс, 2013 | Баянхонгор | Өмнөговь | Өвөрхангай |
|--|---|------------------|------------|----------|------------|
| | Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын нэгдсэн индекс | 3.6 | 2.6 | 3.3 | 3.2 |
| | Эрх зүйн зохицуулалт ба хэрэгжилт | 4.3 | 2.9 | 3.4 | 3.4 |
| | Стратеги, бодлогын баримт бичиг, зохицуулалт | 4.4 | 4.0 | 4.2 | 4.3 |
| | Өмчийн болон газрын харилцаа | 3.4 | 3.0 | 3.0 | 3.0 |
| | Хөрөнгө оруулалтын орчин | 4.4 | 3.0 | 3.5 | 3.0 |
| | Хөрөнгө оруулалтын төслүүд, хэрэгжилтийн байдал | 4.0 | 4.0 | 4.5 | 3.5 |

БАЯНХОНГОР АЙМАГ

| | | | | |
|---|-----|-----|-----|-----|
| Байгаль, орчны хууль, тогтоомжийн хэрэгжилт | 2.2 | 2.0 | 1.5 | 1.7 |
| Нийгмийн аюулгүй байдал | 4.9 | 4.5 | 4.5 | 4.5 |
| Эрүүл мэнд, эрүүл ахуй | 4.8 | 4.5 | 4.5 | 4.5 |
| Аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих бодлого | 3.9 | 3.0 | 3.5 | 3.7 |
| Аялал жуулчлалын салбарын санхүүжилт | 4.1 | 2.0 | 2.5 | 3.0 |
| Жуулчдад зориулсан маркетинг, сурталчилгааны үр өгөөж | 3.1 | 1.5 | 3.0 | 3.0 |
| Аялал жуулчлалын статистик мэдээллийн байдал | 3.4 | 1.0 | 2.5 | 3.0 |
| Бизнесийн орчин, дэд бүтэц | 3.0 | 2.5 | 2.8 | 1.5 |
| Агаарын тээврийн байдал | 2.9 | 3.1 | 3.5 | 0.5 |
| Агаарын тээврийн нислэгийн тоо | 2.7 | 2.0 | 2.5 | 1.0 |
| Нисэх онгоцны буудал, үйлчилгээ | 5.4 | 4.2 | 4.5 | 0 |
| Автотөмөр замын байдал | 2.4 | 2.0 | 2.5 | 2.5 |
| Төмөр зам | 2.5 | 0 | 2.3 | 0 |
| УБ-тай холбосон автозамын чанар | 5.0 | 5.0 | 2.5 | 4 |
| Жуулчны замналын дагуух автозамын сүлжээний чанар | 3.3 | 2.0 | 2.5 | 2.8 |
| Орон нутгийн унааны олноц | | 3.0 | 3.5 | 3.5 |
| Орон нутгийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ | | 0 | 1.5 | 2.0 |
| Аялал жуулчлалын дэд бүтэц | 2.0 | 1.5 | 2.2 | 2.8 |
| Зочид буудлын тоо | 0.2 | 0.2 | 0.2 | 0.2 |
| Зочид буудлын өрөөний тоо | | 1.0 | 3.0 | 2.8 |
| Зочид буудлын орхонгогийн үнэ | | 1.5 | 3.0 | 3.0 |
| Гэр баазын тоо | | 1.0 | 4.0 | 4.0 |
| Гэр баазын гэр ба орны хүрэлцээ | | 1.0 | 4.0 | 3.5 |
| Гэр баазын үнэ | | 1.5 | 3.5 | 3.3 |
| Амралт, рашааны байрны тоо | | 3.0 | 0 | 3.0 |
| Амралт, рашааны байрны чанар | | 3.0 | 0 | 3.0 |
| Мэдээллийн технологи, интернет, Wi-Fi | 2.6 | 2.0 | 2.5 | 2.5 |
| Аялал жуулчлалын үйлчилгээний үнийн өрсөлдөх чадвар | 4.9 | 4.0 | 5.0 | 5.5 |
| Аялал жуулчлалын хүний нөөц болон байгаль, соёлын өвүүд | 3.7 | 2.7 | 3.1 | 3.4 |
| Хүний нөөц | 4.7 | 1.3 | 2.3 | 2.5 |
| Ерөнхий боловсролын чанар | 2.4 | 2.4 | 2.4 | 2.5 |
| Аялал жуулчлалын сургалтын байгууллага | 2.5 | 1.0 | 1.5 | 1.5 |
| Мэргэжлийн боловсон хүчний хангамж, олноц | | 1.5 | 3.0 | 3.5 |
| Аялал жуулчлалыг татах чадвар | 4.3 | 4.2 | 5.5 | 5.2 |
| Гадны хүмүүст орон нутгийнхний хандах хандлага | 5.5 | 5.5 | 6.0 | 6.0 |
| Жуулчдын буцаж ирэх магадлал | 5.2 | 3.0 | 5.0 | 4.5 |
| Байгалийн өв | 3.3 | 3.3 | 3.5 | 3.5 |
| Тусгай хамгаалалттай газар, үзмэр | | 3.5 | 3.5 | 3.5 |
| Байгаль орчны байдал | 3.2 | 3.0 | 3.5 | 3.5 |
| Түүх, соёлын өв | 2.5 | 2.0 | 1.0 | 2.5 |
| Хамгаалалтанд авсан түүх, соёлын өвийн тоо | | | | |
| Жуулчны улирал | | 2.5 | 3.5 | 3.6 |

Тайлбар: Дээрх хүснэгтийг Монгол гэсэн баганын үзүүлэлтийг Дэлхийн Эдийн Засгийн Форумас гаргадаг "Дэлхий Аялал Жуулчлалын Өрсөлдөх Чадварын Тайлан-2013" эмхэтгэлээс авсан болно[13].

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ

3.1. Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ, зах зээл

Баянхонгор аймагт аялах жуулчдын нийт зах зээлийг гадаадын ба дотоодын хэмээн хэсэгчлэн тодорхойлж, тэдгээрийн онцлог, аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ ямар болохыг тусгайлан авч үзье.

Гадаадын жуулчид

Гадаадын жуулчид Монголоор аялдаг тухай ерөнхий судалгаа

Одоогоор Монголд аялсан олон улсын жуулчдын талаархи хамгийн сүүлийн иж бүрэн судалгаа нь АЖҮТ-өөс явуулсан “Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдын дунд явуулсан судалгааны тайлан” юм [9]. Уг судалгааны гол үр дүнгээс үзэхэд:

Монголд амралтаараа багц аяллаар ирэх жуулчдын дийлэнхи хувь нь Итали, Франц, Хойд Америк, Европын бусад орнуудаас иржээ.

Амралтаараа аялагчид Монголыг сонирхож сонгох болсон гол шалтгаан нь байгалийн үзэсгэлэнт байдал, нүүдлийн соёл, ахуй зан заншил гэж хариулжээ. 1998, 2002, 2004, 2012 онуудад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд, гадаадын жуулчдын хамгийн бага тоогоор аялсан газрын тоонд Баянхонгор аймаг орж байгаа нь тухайн үед уг аймагт зам харилцаа муу байсан болон аялал жуулчлалын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээ сайжирч хөгжөөгүй байсантай холбоотой.

Баянхонгороор аялж яваа олон улсын жуулчин дунджаар 2-3 хоног аялсан нь Монголд аялдаг жуулчдын аяллын дундаж хоногоос бага байгаа юм.

Дамжин өнгөрөх зорилгоор Баянхонгорыг зорьдог жуулчид

Нүүдэлчин Монголын амьдрал, Говь Хангайн байгалийг үзэх сонирхолтой жуулчид тодорхой нэмэгдэж байгаагаас тойрон аялал, спорт аялал, шувуу ажиглах зэрэг тусгай сонирхлын аяллын жуулчид Баянхонгороор аялах нь илүү байна. Аяллын хөтөлбөр нь Баянхонгор аймгийн говийн хэсэгт байршилтай Цагаан агуй, Бичигт Хад, Орог нуур, Цагаан Булгийг багтааж цааш Өвөрхангай буюу Говь-Алтай аймаг руу үргэлжилсэн аяллууд зонхилж байна.

Тусгай сонирхлын жуулчид

Тусгай сонирхлоор аялагчдын дотор спортын аяллаар, түүний дотор шувуу ажиглахаар ирдэг жуулчдын тоо тогтмол буюу цаашид буурахгүй байх магадлалтай байна. Одоогийн байдлаар АНУ, Англи, Европын Холбооны улсын жуулчид тусгай сонирхлын аяллаар Баянхонгорыг зорих нь бусад орнуудын жуулчдаас олон байна. Мөн зэрлэг амьтдыг үзэх, ажиглаж зураг авах болон явган аяллаар Итали, Францын жуулчид, авто мото аяллагаар Япон, Өмнөд Солонгосын аялагчид ирдэг байна.

Бие даан аялагчид

Говь-Алтай, Завхан зэрэг баруун аймгуудаас Улаанбаатар хот руу болон Улаанбаатар хотоос баруун аймгуудыг зорьсон олон улсын бие даан аялагчид автомашин, мотоцикль, унадаг дугуйгаар аялдаг бөгөөд тэдгээр бие даасан жуулчдын тоо цаашид мөн өсөх хандлагатай байгаа юм.

Дотоодын амрагчид

Улаанбаатар, бусад аймгийн тойрон аялагчид, залуучууд Их Богд ууланд авирах, Бөөнцагаан болон Орог зэрэг нуур орчимд амрах, Хачин ламын хийдэд мөргөх, Баянхонгор нутагтай танилцах зорилгоор аялах бөгөөд ихэвчлэн өөрсдийн майханд хоноглон аялдаг. Түүнчлэн тус аймгийн нутгаар дайран өнгөрөх замдаа дээр дурьдсан

түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцаад явах аялагчид мөн багагүй хувийг эзлэдэг. Мөн Баянхонгор аймгийн нутагт байрладаг Шаргалжуутын рашаан болон Холбоолж нуур, Өргөөт, Тээл, Халиут зэрэг орон нутгийн алдартай рашаан сувиллыг Улаанбаатар, бусад аймгуудаас төдийгүй Баянхонгор аймгийн сумдаас зоригсдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Зөвхөн Шаргалжуутын рашаанд эмчлүүлэхээр жилдээ дунджаар 5000 гаруй иргэд ирдэг мэдээг тухайн рашаан сувиллынхан өгч байсан болно.

Монгол улсын дотоодын аялал жуулчлалын талаар 2004 онд явуулсан судалгааны дүнгийн тайлангаас үзэхэд [8]:

Зуны улиралд хөдөөд аялагчдын дийлэнхи нь найз нөхөд, хамаатан садныдаа зочлогосод ба амралтаараа аялагчид байдаг.

Судалгаанд хамрагдагсдын 63% нь жилд нэгээс хоёр удаа хөдөө явдаг гэж хариулсан ба ихэнхи нь ахмад настай хүмүүс юм.

Хөдөөд амралтаараа аялахаар зорьсон үндсэн шалтгаанууд нь байгаль, үзэсгэлэнт газрууд ба цагаан идээ хэрэглэх гэжээ.

Аялах газруудаа сонгосон мэдээллийн үндсэн эх сурвалжууд нь найз нөхөд, хамаатан садны зөвлөгөө ба урьд өмнө нь аялсан мэдлэг туршлага байна.

Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан хүмүүсийн тал илүү хувь нь гэр бүлээрээ хөдөөд амрахыг хүсдэг байна.

Хөдөөд нэгээс хоёр долоо хонох нь нийтлэг түгээмэл хугацаа болно.

Аялсан газруудаас Баянхонгорыг зорьсон аялагчид дундаж ба ахмад насныхан байгаа нь рашаан сувиллын амралттай холбоотой гэж үзэх үндэстэй.

Орон нутагт аялагч жуулчдын гол хэрэгцээнүүд нь:

Боломжийн үнэ бүхий хоноглох байр

Энгийн бөгөөд амттай бэлтгэсэн хоол, унд

Байгалийн үзэсгэлэнт газрууд

Үзэх зүйлүүд, үзмэрүүд

Орон нутгийн түүх соёлын өв

Жуулчдын идэвхи, санаачлага, оролцоо шаардсан үйл ажиллагаа

Бэлэг дурсгалын зүйлс худалдан авах бололцоо

Язгуур урлагийн тоглолт, соёлын үзвэрүүд

Аяллын хугацаан дахь жуулчдын аюулгүй байдал

Нутгийн хүмүүсийн найрсаг, зочломтгой зан чанар зэрэг болно.

3.2. Аялал жуулчлалын өсөлтийн хувилбарууд

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын өсөлтийг бага, дунд, өндөр өсөлт гэсэн гурван хувилбараар тооцсоныг хүснэгт 20 –д үзүүлээ. Өсөлтийн хувийг тооцохдоо тухайн аймгийг зорин очих гадаадын болон дотоодын жуулчдын тооны өсөлт, Монголыг зорин ирэх жуулчдын тооны өсөлтийг үндэс болгосноос гадна бага өсөлтийн хувьд жилийн дундаж өсөлтийг 2.0 – 2.5%, дунд өсөлтийн хувьд 5.0%, өндөр өсөлтийг 10.0% - аар тооцсон болно.

Хүснэгт 22. Жуулчдын өсөлтийн хувилбарууд

| Хувилбарууд | 2013 | 2015 | 2020 |
|--------------------------------------|------|------|------|
| Бага өсөлт | | | |
| Жуулчдын тоо: | | | |
| Говь-Хангайн багц аяллын жуулчид | 427 | 444 | 505 |
| Тусгай сонирхлын | 425 | 445 | 507 |
| Алтай, Баруун Монголоос ирэх жуулчид | 427 | 444 | 505 |
| Шууд ирээд буцах жуулчид | 143 | 149 | 169 |


| | | | |
|--|------|------|-------|
| Дотоодын жуулчид | 7204 | 7495 | 8521 |
| Зочид буудлын ор-хоног | 356 | 370 | 421 |
| 30-40 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 63 | 66 | 75 |
| 50 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 62 | 65 | 78 |
| Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэлт | 230 | 239 | 257 |
| Жуулчны баазууд | 5 | 5 | 7 |
| Дунд зэргийн өсөлт | | | |
| Жуулчдын тоо: | | | |
| Говь-Хангайн багц аяллын жуулчид | 427 | 471 | 601 |
| Тусгай сонирхлын | 425 | 469 | 599 |
| Алтай, Баруун Монголоос ирэх жуулчид | 427 | 471 | 601 |
| Шууд ирээд буцах жуулчид | 143 | 157 | 200 |
| Дотоодын жуулчид | 7204 | 7942 | 10136 |
| | | | |
| Зочид буудлын ор-хоног | 356 | 392 | 500 |
| 30-40 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 63 | 69 | 88 |
| 50 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 62 | 69 | 90 |
| Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэлт | 230 | 254 | 324 |
| Жуулчны баазууд | 5 | 6 | 8 |
| Өндөр өсөлт | | | |
| Жуулчдын тоо: | | | |
| Говь-Хангайн багц аяллын жуулчид | 427 | 517 | 833 |
| Тусгай сонирхлын | 425 | 514 | 828 |
| Алтай, Баруун Монголоос ирэх жуулчид | 427 | 517 | 833 |
| Шууд ирээд буцах жуулчид | 143 | 173 | 279 |
| Дотоодын жуулчид | 7204 | 8716 | 14037 |
| | | | |
| Зочид буудлын ор-хоног | 356 | 431 | 694 |
| 30-40 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 63 | 76 | 122 |
| 50 хувийн дүүргэлттэй ерөөний тоо | 62 | 74 | 120 |
| Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэлт | 230 | 278 | 447 |
| Жуулчны баазууд | 5 | 6 | 9 |

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСЛҮҮД

4.1. Аялал жуулчлалын хөгжлийн зорилго, зорилтууд

БАЯНХОНГОРЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯЗГУУР ҮНЭ ЦЭНЭ НЬ:

- Эртний хүн амьдарч байсан өлгий болох түүхэн газрууд
- Аяллын гол дурсамж, сэтгэгдэл болж үлдэх Говь-Хангайн байгаль (ой мод, ус, биологийн олон төрөл зүйлүүд), ховор ан амьтан, ургамал нь нутгийн иргэдийн зан заншил, ахуй амьдралын зохицолдоо бөгөөд,
- Малчин ардын, соёл, ахуй амьдрал нь жуулчдын биечлэн оролцож мэдрэх хинхэнэ нүүдэлчин ахуй юм.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ:

А. Эхний шат (2013-2016 он)

Аялал жуулчлалын үйлчилгээний баазыг бэхжүүлэх үйлчилгээний чанар стандартыг сайжруулах

Б. Хоёрдугаар шат (2017-2020 он)

Монгол улсын аялал жуулчлалын топ таван аймагт багтах

4.2. Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепц

Хөгжлийн концепц:

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын нөөц, зах зээлийн эрэлт хэрэгцээ чиг хандлага болон зам тээврийн хөгжил, энэхүү мастер төлөвлөгөөг боловсруулах явцад хийгдсэн судалгааны дүнг үндэслэн аялал жуулчлалын дараахь гурван бүсчлэлийг санал болгож байна (Зураг 7).

Зураг 7. Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепц



Бүсүүдийн хил, хязгаар нь нарийн тогтсон биш бөгөөд ерөнхийдөө сумдын хил, зам болон газар зүйн томоохон уул, усаар хязгаарлагдах боломжтой юм.

Хүснэгт 23. АЖ-ын бүсүүдийн гол онцлог, шинжүүд

| Аялал жуулчлалын үндсэн бүсүүд | Гол онцлог, шинж чанарууд |
|---------------------------------------|--|
| Тусгай Сонирхлын Аялал Жуулчлалын Бүс | Баянхонгор аймагт аялан ирэх, буцах газрууд Ерөнхий амралт, чөлөөт цагийн арга хэмжээнүүд (түүх, соёлын, нүүдэлчин зан заншил зэрэг) Адал явалт аяллууд (морин, тэмээн, явган, уулын зэрэг) Спорт, уралдаан (автомашин, мотоцикль, дугуйн) Шувуу ажиглах Нууранд амрах, усан аялал(амралт, загасчлах, завь) |
| Рашаан Сувилал, Амралтын Бүс | Рашаан сувилал Эмчилгээ |
| Экологи, Аялал Жуулчлалын Бүс | Говийн байгаль, экологи Динозаврын мөрөөр Мазаалай хамгаалал |


Аялал жуулчлалын бүс бүр аялал жуулчлалын үйл ажиллагааны төлөвлөгөө

гарган, жил бүр аймгийн буюу эсвэл сумын ИТХ-аар батлуулж ажиллах шаардлагатай. Аялал жуулчлалын бүсийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь тодорхой нэг сумын буюу мөн хоёр ба хэд хэдэн сумдын хамтын үйл ажиллагаагаар хэрэгжих ёстой.

- Төлөвлөгөөний нийтлэг зорилгууд нь:
- Аялал жуулчлалын гол нөөц, байгаль, соёлын үзмэрүүдийг хадгалан хамгаалах
- Байгаль орчин, нутгийн соёл заншлыг хэвээр хадгалах
- Гадаад, дотоодын аялагч, амрагчдын ерөнхий сэтгэгдлийг улам сайжруулах
- Орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ.

Рашаан сувилал, амралтын бүс

Зураг 8. Рашаан сувилал, амралтын бүс




| | |
|-----------------------------|--|
| Хамрах сумууд | Баянхонгор, Баян-Овоо, Богд, Галуут, Жаргалант, Өлзийт, Эрдэнэцогт |
| Аялал жуулчлалын бүсийн төв | Баянхонгор |
| Бусад төвүүд | Шаргалжуут тосгон, Баян-Овоо сум |

| | |
|---|--|
| Нийтлэг ба төрөлжих бүтээгдэхүүн, үйлчилгээ | Рашаан сувилал Эрүүл мэндийн эмчилгээ Улаанбаатар хот, бусад аймгаас эмчлүүлэгчдэд зориулсан 1-2 хоногийн тойрон аяллууд |
| Шийдвэрлэх асуудлууд | Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны дахин төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах |
| | Рашааны орчны даацын хүчин чадлын тодорхойлох |
| | Баянхонгор хот-Шаргалжуут хоорондын автозамыг сайжруулах |
| | Их Шаргалжуут рашаан сувиллын менежементийн гэрээ, төлөвлөгөөг шинээр боловсруулах |
| | Рашааны эх ундрагыг хамгаалах, ашиглах журам боловсруулж мөрдөх |

Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүс


Зураг 9. Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүс



| | |
|---|--|
| Хамрах сумууд | Баацагаан, Баянхонгор, Баянбулаг, Баянцагаан, Богд, Бөмбөгөр, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Заг, Өлзийт, Хүрээмарал |
| Аялал жуулчлалын бүсийн төв | Баянхонгор |
| Бусад төвүүд | Баацагаан сум |
| Нийтлэг ба төрөлжих бүтээгдэхүүн, үйлчилгээ | Спортын аяллын бүх төрлүүд Автомашин, мотоциклийн аялал Нууран дээрх усны аялал, амралт Шулуу ажиглах аялал Түүх соёлын өвийн тойрон аяллууд “Адуучин” зэрэг баяр наадам зохион байгуулах |
| Шийдвэрлэх асуудлууд | Баянхонгор хотноо жуулчны мэдээлэл, үйлчилгээний төв байгуулах Бөөнцагаан нуурын дэргэд шинээр жуулчны бааз байгуулах |
| | Аймгийн нутаг, дэвсгэрт олон улс, улсын шинж чанартай аяллын уралдаан, тэмцээн зохион байгуулах нийтлэг журам боловсруулж хэрэгжүүлэх |

Экологи, аялал жуулчлалын бүс

Зураг 10. Экологи, аялал жуулчлалын бүс



| | |
|---|---|
| Хамрах сумууд | Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Шинэжинст |
| Аялал жуулчлалын бүсийн төв | Баянлиг |
| Бусад төвүүд | Шинэжинст |
| Нийтлэг ба төрөлжих бүтээгдэхүүн, үйлчилгээ | Говийн байгаль, түүхийн өвийн аялал Мазаалай хамгаалах, ажиглах аялал Их Говийн дархан цаазат газрын орчим бусад тойрон аяллууд |
| Шийдвэрлэх асуудлууд | Их Богдын ТХГН-ын захиргаатай хамтран аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах |
| | Замын тэмдэглэгээ, байгаль түүхийн үзмэрийн мэдээллийг бий болгох |
| | Мазаалай хамгаалах аяллыг хөгжүүлж, сурталчлах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах |
| | Сумдад болон аялал жуулчлалын гол нөөц бүхий газруудад хоол ундаа, бэлэг, дурсгал, мэдээллийн үйлчилгээг бий болгох |

4.3. Тэргүүлэх төслүүд

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын хөгжлийн стратеги, аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепт, бүсүүдэд нэн тэргүүн шийдвэрлэх асуудлуудыг үндэслэн аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг доорхи хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 24. АЖ-ын тэргүүлэх ач холбогдолтой төслүүд

| № | Төслийн нэр | Зорилго | Санал болгох хугацаа, байршил | Санхүүжилт, сая.төг |
|---|---|--|--|--|
| 1 | Баянхонгор суманд гурваас дээш одны зэрэглэлийн зочид буудлын цогцолбор байгуулах | Аймгийн байр сууцны стандарт, хүчин чадал, чанарыг сайжруулах | 2014-2015, Аймгийн төв | 16-р хавсралтанд үзүүлсэн жишиг төслөөр 1396 сая.төг |
| 2 | Бөөнцагаан нуурын дэргэд жуулчны гэр бааз байгуулах | Орон нутагт жуулчны байр сууцны загвар баазтай болох | 2014 оноос, Баацагаан сум, Бөөнцагаан нуурын зүүн урд эргээс 100 м зайд | Жишиг зураг, төсвийг 17-р хавсралтанд үзүүлэв |
| 3 | Сумд хооронд болон аялал жуулчлалын гол газруудад хүрэх замын тэмдэг байгуулах | Тойрон аяллыг дэмжих, жуулчдыг орон нутагт саатуулах мэдээллээр хангах | 2015-2016, Сумдад болон гол замын уулзвар, зангилаа, аялал жуулчлалын гол үзмэрүүдэд | Төсөл, төсвөөр тодорхойлно. |
| 4 | Аймгийн музейг шинэчлэн засварлах, үзмэрийг баяжуулан сэргээн засварлах | Жуулчдад үзүүлэх үйлчилгээ, олох орлогыг нэмэгдүүлэх | 2016-2017, Баянхонгор сум | |

4.4. Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 24. Үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Үйл ажиллагааны төрөл: Салбарын менежмент

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|----|--|--------------------|--------------|--------------|
| 1 | Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг Баянхонгор аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах | АССАЖГ | 2013. 10 сар | Маш чухал |
| 2 | Аймгийн аялал жуулчлалын хөгжлийн зөвлөлийг байгуулж ажиллуулах | АИТХ, АЗДТГ | 2013.11 сар | Чухал |
| 33 | Аймгийн зочид буудал, рестораны холбоог байгуулж ажиллах | АССАЖГ | 2013. 12 сар | Чухал |

БАЯНХОНГОР АЙМАГ

| | | | | |
|---|---|----------------------------------|--------------------|-------|
| 4 | Аялал жуулчлалын бүсүүдийн ажлын төлөвлөгөөг боловсруулан, сумдын хамтын ажлын уялдааг хангах | Аялал Жуулчлалын хөгжлийн зөвлөл | 2014 оноос | Чухал |
| 5 | Аймгийн болон сумдын аялал жуулчлалын статистик мэдээллийн эмхэтгэл гаргах | АССАЖГ, Статистикийн хэлтэс | 2014 оноос жил бүр | Чухал |
| 6 | Аймагт аялан ирсэн олон улсын ба дотоодын жуулчид, амрагчдын дунд санал асуулгын судалгаа явуулах | АССАЖГ | 2015 онд | Дунд |

Байгаль, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/ Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|---|---|--|-----------------|--------------|
| 1 | Аялал жуулчлалын гол үзэмэр, рашаан бүхий газруудын газар ашиглалтын судалгаа хийж, шинээр төлөвлөн гэрээ байгуулах | БОГ, АССАЖГ, холбогдох сумдын захиргаа | 2013 оны 10 сар | Чухал |
| 2 | Их Богдын ТХГН-ын захиргаатай хамтран аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах | Их Богдын ТХГН захиргаа, АССАЖГ | 2013 оны эцэст | Дунд зэрэг |
| 3 | Аялал жуулчлалын гол газрууд болон рашааны ундарга, нөөц газруудад даацын хүчин чадлыг тодорхойлох | БОГ, АССАЖГ | 2014-2015 | Маш чухал |
| 4 | Цагаан Агуй, Бичигт Хад, Цагаан Булаг зэрэг аяллын гол газруудын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | АССАЖГ, холбогдох Сумын захиргаад | | |

Орон нутгийн ба хүний нөөцийн хөгжил

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/ Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|---|---|---------------------------------|-----------------|--------------|
| 1 | Аялал жуулчлал, үйлчилгээний бизнес эрхлэгчдэд ЖДҮ-ийн нөхцөлөөр хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх | АЗДТГ, АССАЖГ | 2013 оны 10 сар | Чухал |
| 2 | Сумдын аялал жуулчлал, рашаан сувиллын зорилгоор газар ашиглалтын байдалд шалгалт хийж, дүгнэлт гаргах | АБОНХГ, АССАЖГ, Сумын захиргаа | 2014 | Маш чухал |
| 3 | "Баянхонгор аймгийн аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын чуулган" зохион байгуулах | АЗДТГ, АССАЖГ | 2014 | Чухал |
| 4 | Аймгийн брэнд бүтээгдэхүүн, гар урлал, бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хотноо зохион байгуулах | АЗДТГ | 2015 | Дунд |
| 5 | Зочлох үйлчилгээний ажилтнуудын сургалт | АССАЖГ | байнга | бага |
| 6 | Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний сургалтын жилийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | АССАЖГ, Аялал жуулчлалын зөвлөл | Жил бүр | Чухал |

Дэд бүтэц

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|---|---|--------------------|------------|--------------|
| 1 | Аялал жуулчлал, зочид буудлын болон гэр бааз, гар урлалын үйлдвэрлэлийг ЖДҮ-ийн зээл, тусламжийн бодлогод хамруулах, дэмжих | АЭЗГ | 2014 оноос | Чухал |
| 2 | Аялал жуулчлалын мэдээллийн төв | АЗДТГ, АССАЖГ | 2014 | Маш чухал |
| 3 | "Аймгийн нутаг дэвсгэрт автомашин, мотоциклийн уралдаан, тэмцээн, аялал зохион байгуулах журам" боловсруулж мөрдөх | АИТХ, АЗДТГ | 2014 оноос | Чухал |
| 4 | Аялал жуулчлалын үндсэн замналын дагуу замын хүндрэлийн зэрэглэл, нөхцөл байдлыг аймгийн цаг агаарын вэб хуудсаар мэдээлэх | УЦУГ | 2014 оноос | Дунд |

| | | | | |
|---|---|--------------------|-----------|-------|
| 5 | Аймгийн гол рашаан, аяллын үзмэр, нөөц бүхий газруудад нэгдсэн загварын жорлон, бохирын цэг байгуулах төслийн уралдаан дүгнэж хэрэгжүүлэх | АЗДТГ, БОГ, АССАЖГ | 2014-2015 | Чухал |
|---|---|--------------------|-----------|-------|

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|---|---|---|----------------|--------------|
| 1 | Аймгийн аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулан сонгож, цаашид гадаад дотоодын зах зээлд сурталчлан борлуулах | АЗДТГ, АССАЖГ, Аялал жуулчлалын хөгжлийн зөвлөл | 2014 | Маш чухал |
| 2 | Сумдын зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | АССАЖГ | 2014 оноос | Чухал |
| 3 | Их Шаргалжуут сувилалд Улаанбаатар хот, бусад аймгаас амрагчдад Баянхонгор сум, Хачин ламын хийд, Говийн аялалд явах хөтөлбөр, орон нутгийн унааны бололцоог дэмжин хэрэгжүүлэх | АССАЖГ, Шаргалжуут тосгон | 2014 оноос | Чухал |
| 4 | Аялал жуулчлалын гол үзмэрүүдийг мэдээллийн нэгдсэн самбартай болгож, тэмдэгжүүлэх | АССАЖГ, Сумдын захиргаа | 2014-2015 | Маш чухал |
| 5 | Аймгийн аялал жуулчлал, зочлох үйлчилгээний тэргүүний сум, байгууллага, ажилтан шалгаруулах уралдаан зарлаж дүгнэх | АССАЖГ, Аялал жуулчлалын зөвлөл | Жил бүр | Дунд |
| 6 | “Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх” сэдэвт олон улсын хурал зохион байгуулах | АССАЖГ, МАЖХ | 2014 оны эцэст | Дунд зэрэг |
| 7 | Аймгийн музейн үзмэрийг шинэчлэх, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | АССАЖГ | 2014-2015 | Чухал |
| 8 | “Рашаан сувиллын аялал” сэдэвт үзэсгэлэн яармаг зохион байгуулах | АССАЖГ | 2015 он | Дунд |
| 9 | Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үнийн нэгдсэн бодлого боловсруулах | Аялал жуулчлалын зөвлөл | Жил бүр | Дунд |

Маркетинг, сурталчилгаа

| № | Үйл ажиллагаа | Хариуцагч/Хамтрагч | Хугацаа | Ач холбогдол |
|---|--|--|--------------------|--------------|
| 1 | Аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулж ажиллуулах | АЗДТГ, АСАЖГ | 2014 оноос | Чухал |
| 2 | Аймгийн аялал жуулчлалын вэб хуудсыг идэвхитэй ажиллуулах | АССАЖГ | Байнга | Маш чухал |
| 3 | Аймагт болох соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цагалбар гаргах | АССАЖГ | Жил бүр | чухал |
| 4 | Баянхонгор сумын үйлчилгээний байгууллагуудын танилцуулга, материал хэвлэж түгээх | АЗДТГ, АССАЖГ | 2014 оноос жил бүр | Дунд |
| 5 | “Хонгор нутгаар аялцгаая” аймгийн аялал жуулчлалын маркетингийг Улаанбаатар хотын тур операторууд, хэвлэл мэдээллийнхэнд тодорхой сэдвээр зохион байгуулж хэвших | МАЖХ, АССАЖГ, Сумдын захиргаа, Тур оператор, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгуул-лагууд | 2 жилд нэг удаа | Дунд |
| 6 | Орон нутгийн телевизийн сувгаар “Хонгор нутгийн аяллын цаг” тогтмол хөтөлбөр бий болгох | АССАЖГ | Байнга | Чухал |

Дотоод жуулчдыг татахын тулд нэн түрүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Зохион байгуулалт |
|---|--|-------------------------|---|
| 1 | Дотоодод зохион байгуулагдаж буй аялал жуулчлалын үзэсгэлэн яармагуудад тогтмол оролцох | 2013-11 сар жил бүр | -Аймаг дангаараа талбай авч оролцох -Үзэсгэлэнгийн үеэр аймгийнхаа аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлвийн талаар тусгайлан цаг авч танилцуулга мэдээллийг хийж байх -Аймгийн зочид буудал үйлчилгээний салбарууд болон ЖДҮ, аялал жуулчлалын үзэмр, эвент арга хэмжээ бүхий танилцуулгыг жил бүр хэвлэж үзэсгэлэнд оролцогчдод танилцуулж байх - Оролцож буй үзэсгэлэн бүрт тодорхой сэдвийн хүрээнд оролцох |
| 2 | Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын төсвийн хөрөнгөөр зохион байгуулж буй аяллын аливаа арга хэмжээг 2014 онд зөвхөн орон нутгийн түүх соёлын дурсгалт газар болон байгалийн үзэсгэлэнт газруудаар зохион байгуулах | 2014 оны 3, 4-р улиралд | -Дээрх арга хэмжээний дагуу аймгийн засаг дарга захирамж гаргах - Аяллын маршрут чиглэлийг аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тусгагдсан маршрутыг санал болгохын зэрэгцээ шинэ маршрутыг зохиож өгөх ажлыг аймгийн ССАЖгазраас гаргаж өгөх -Зохион байгуулалтын үеэр орон нутгийн ЖДҮ бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах ажлыг зохион байгуулах |
| 3 | Аймгийн аялал жуулчлалын голлох үзэмрүүдийн чиглэлийг заасан замын тэмдэглэгээг хийж дуусгах | 2014 оны 2-р улиралд | -Эхний ээлжинд Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тусгагдсан гол гол үзэмрүүдийн чиглэлийг заасан тэмдэглэгээг хийж байршуулах -Тэмдэглэгээг хийж байршуулах зардлыг тухайн сумын орон нутгийн хөгжлийн сангаас гаргуулах - Тэмдэглэгээний загвар, хэмжээ болон байршлыг аймгийн ССАЖ газраас батлах |
| 4 | "Хүн төрөлхтөний өлгий нутгаар" адал явдалт спорт аяллын арга хэмжээг зохион байгуулах | 2014 оны 3-р улиралд | -Адал явдалт спорт аяллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран ажиллах -Аяллын бүрэлдэхүүнийг мэргэжлийн болон сонирхогчдоос бүрдсэн өргөн хүрээнд зохион байгуулах -Хэвлэл мэдээллийн салбарыг өргөн оролцуулах -Аяллыг зохион байгуулахтай холбоотой тодорхой зардлыг аймгийн төсөвт суулгах - Аяллын тухай ТВ-ын цуврал нэвтрүүлгийг аялалд оролцогч хэвлэл мэдээллийг байгууллагуудын ажилтнуудаар дамжуулан бэлтгэн нийтэд сурталчлах -Уг арга хэмжээг уламжлал болон зохион байгуулж байх |
| 5 | Уламжлал болон зохион байгуулагдсан арга хэмжээнүүдийг цаашид тогтмол зохион байгуулах | Жил бүр | -Гурван түмэн сарлагын баяр - Ардын урлагийн наадам зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулах - Арга хэмжээний талаархи мэдээллийг АЖ-ын үндэсний цагалбарт оруулах - Арга хэмжээг зөвхөн аймгийн хүрээнд бус хил залгаа бусад аймгийн хүрээнд бус нутгийн шинж чанартай болгох |

ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ҮНДСЭН ЗӨВЛӨМЖҮҮД

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор дараах үндсэн долоон практик зөвлөмжүүдийг гаргаж байна.

Үүнд:

- Аялал жуулчлалын хөгжлийн зөвлөлийг байгуулж ажиллуулах
- Аймагт аялагч, жуулчин байршуулах төрлүүдийг хөгжүүлэх
- Судалгаа ба сургалт
- Маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх
- Аялал жуулчлалын хүчин чадлыг тодорхойлох
- Аялал жуулчлалын бүс нутаг дахь зам, аяллын гол үзэмрүүдийг тэмдэгжүүлэх
- Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг сумдаас дэмжин хэрэгжүүлэх тус тус болно.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛАХ

Аймгийн АЖ-ын хөгжлийн зөвлөлийг байгуулах зорилго:

Баянхонгор аймгийн нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг нутгийн зон олон, тэдний ахуй амьдралд нийцүүлэн төлөвлөн хөгжүүлж, орон нутгийн удирдлага, зохицуулалтыг хангах.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД:

- 1 Баянхонгор аймагт аялал жуулчлалын хөгжлийн асуудал хариуцсан төр-хувийн хэвшлийн төлөөлөл бүхий ТББ байгуулах
- 2 АССАЖГ-ын үйл ажиллагааг бэхжүүлж, харьяанд нь мэдээллийн төв, зарим сумдын орлогч дарга нарт аялал жуулчлалын асуудлыг хариуцуулах
- 3 Хангайн бүсийн аялал жуулчлалын зөвлөлийн Баянхонгор аймгийн салбарыг байгуулж, чиг үүргийг тодорхойлох замаар ажил, үүргийг шилжүүлэх
Дээрх гурван бололцоонд тулгуурлан дараах бүтцийг санал болгож байна.

Зураг 8. АЖ-ын хөгжлийн зөвлөлийн бүтэц



Төр, засгийн байгууллагууд эдийн засгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүгийн орлого бүрдүүлэх, хилийн хяналт шалгалт хийх, орон зайн хуваарилалт, нөөцөө хамгаалах, аюулгүй байдлын тогтолцоог бий болгох, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, зах зээлд гарч болох алдааг багасгах зэрэг байдлаар аялал жуулчлалын хөгжилтөнд нөлөөлдөг.

Зорих газрын маркетингийг энэ чиглэлийн мэргэжлийн байгууллага эрхлэн гүйцэтгэдэг олон улсын практиктэй бөгөөд ийм байгууллагыг Баянхонгор аймгийн Аялал Жуулчлалын хөгжлийн зөвлөл (ТББ) хэлбэрээр байгуулан ажиллуулах боломжтой юм.

Төрийн ба хувийн хэвшлийн төлөөлөл заавал оролцсон байх Удирдах Зөвлөл нь уг ТББ-ын стратегийн ба санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэн, улмаар удирдлага, хяналтын асуудлыг шийдвэрлэж байх үүрэгтэй. Удирдах Зөвлөл нь зөвлөх бус, харин уг ТББ-ын менежментийн асуудлыг бие даан шийдвэрлэх эрх мэдэлтэй байх нь нэг гол онцлог байна. Удирдах Зөвлөлийн эрх мэдэл, хүлээх хариуцлагыг үүсгэн байгуулагчид нь нарийвчлан тогтооно.

Аймагт аялагч, жуулчин байршуулах төрлүүдийг хөгжүүлэх

Судалгаанаас үзэхэд, Баянхонгор аймгийн зочид буудал, байршуулах хэрэгслийн төрлүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах нь нэн тулгамдсан асуудлуудын нэг юм. Энэ чиглэлээр дараах зөвлөмжүүдийг гаргаж байна. Аймгийн төвд дээд зэрэглэлийн цомхон зочид буудлыг шинээр барих. Эхний ээлжинд 25-30 өрөө бүхий, хурлын заалтай 5 давхар жишиг буудлыг барихыг санал болгож байна. Ийм зочид буудал нь инженерийн холболт, дотоод тавилга, төхөөрөмжийн зардлууд орохгүйгээр ойролцоогоор 1,4 тэрбум орчим төгрөгийн санхүүжилтээр баригдах боломжтой юм (Хавсралт 16).

Зураг 12. Аймгийн төвд шинээр барих зочид буудлын загвар



Цаашид жуулчны төвлөрөх газруудад барьж байгуулахад загвар болгож, эхний ээлжинд Бөөнцагаан нуурын дэргэд жуулчны гэр баазыг байгуулах нь зүйтэй гэж үзэж байна (Хавсралт 17).

Зураг 13. Бөөнцагаан нуурын орчим байгуулах жуулчны баазын загвар



Сумын төвүүдэд шинээр жижгэвтэр (тус бүр 2 ортой, 5-10 өрөө бүхий) шинэ буудлуудыг орчин үеийн загвар, дизайнаар барьж үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай.

Аялагч, жуулчид түр байрлах отог.

Баянхонгор аймгийн говийн бүсийн Шинэжинст, Баян-Өндөр сумдын нутаг дахь байгалийн үзэсгэлэнт газрууд болох Ногоон цав, Эхийн гол, Цагаан бургас зэрэг газруудад аялагч жуулчдад зориулсан түр байрлах отогийг зохион байгуулах,

Дээрх нэр бүхий газар нь төв суурин газраас алслагдсан говь цөлийн хэв шинжийг хадгалсан өвөрмөц тогтоц бүхий газар бөгөөд цөөн тооны жуулчид зорьж очдог тул тухайн газар орны онцлогт тохирсон түр байршуулах байрыг байгуулах

Аялагч жуулчдын түр байрлуулах газар нь жилийн дөрвөн улирлын аль ч үед хүмүүс орж амрах, хоноглох боломжтой байх

Байрны үндсэн хийцийг байгалийн чулуу болон мод зэргийг оролцуулан хийх, энэ

нь орон нутгийн онцлог ялангуяа Баянхонгор аймгийн говийн бүсийн малчид чулуун хороо хашааг барьж мал сүргээ хашиж хамгаалж ирсэн уламжлалт хэв маягийг илэрхийлсэн байхын сацуу монгол гэрийн загвараар баригдсан байх

Орон байрны дотор талд хүмүүсийн унтаж амрах наар болон ширээ сандал, гал түлж болох чулуун пийшин зэргийг байрлуулах

4-5 хүний багтаамжтай 2-3 сууцыг нэг дор байрлуулах

Байр сууцанд тодорхой харуул хамгаалалт шаардлагагүй бөгөөд ямар ч үед хүмүүс орох боломжтойгоор онгорхой байлгах,

Сууцны дотор талд аялагч жуулчдад зориулсан зөвлөмж, сануулгыг англи монгол хэлээр бичиж байрлуулах,

Уг сууц нь байгаль экологийн аялал өвөрмөц имижийг илэрхийлэх болно. Уг түр байрлах сууц нь аймгийн аялал жуулчлалын имиж болохын зэрэгцээ тухайн бүс нутгийг зорих аялагч жуулчдад үзүүлж буй содон үйлчилгээ болох юм.

Зураг 14. Жуулчны түр отоглох байрны загвар



5.3 Судалгаа ба сургалт

Баянхонгор аймагт шинээр байгуулах аялал жуулчлалын хөгжлийн зөвлөл нь жуулчны мэдээллийн төв ба сумдаар дамжуулан аймгийн холбогдох төр, хувийн байгууллагууд дэмжлэг, мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор маркетингийн судалгааг дараах чиглэлүүдээр явуулах шаардлагатай байна.

Баянхонгорыг зорьж болон дамжин өнгөрөх жуулчдын тоо /жил бүр/

Аяллаар ирсэн олон улсын жуулчдын судалгаа /хоёр жилд нэг удаа/

Аяллаар ирсэн дотоодын жуулчдын судалгаа /гурван жилд нэг удаа/

Их Говийн ДЦГ, Их Богдын ТХГН-уудад аялсан гадаад, дотоодын жуулчдын тоо /жил бүр/

Баянлиг, Шинэжинст зэрэг сумд болон Их Шаргалжуут зэрэг шаардлагатай газруудад жуулчдаас авах хэсэгчилсэн судалгаа /жил бүр/

Зочид буудлууд, жуулчны баазууд, рашаан амралтын газруудад байрлуулж үйлчлүүлсэн зочдын тухай статистикийн дэлгэрэнгүй судалгаа /жил бүр/

Нийтийн хоол, бэлэг дурсгалын болон бусад үйлчилгээний талаар гадаад,

дотоодын жуулчдаас авах хэсэгчилсэн судалгаа /хоёр жилд нэг удаа / зэрэг болно.

Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөө, маркетингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтот бүлгүүдэд тодорхой сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай юм. Үүнд:

- Аймаг, сумдын ИТХ-ийн гишүүд, нутгийн зөвлөлийн төлөөлөл
- Аймаг сумдын стратеги төлөвлөлт, байгаль орчин, аялал жуулчлал, нийтийн үйлчилгээ, мэргэжлийн хяналт зэрэг чиглэлийн төрийн ажилтнууд
- Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, рашаан сувиллын газруудын удирдлагууд
- Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, рашаан сувиллын газруудын үйлчилгээний ажилтнууд
- Жуулчдад зориулсан үйлчилгээ, бэлэг дурсгалын бизнес эрхлэгчид
- Орон нутгийн бусад иргэд, малчид зэрэг болно.

Хүснэгт 24. Санал болгох сургалтын төрлүүд

| Сургалтын чиглэл, сэдэв | АЖХЗ болон орон нутгийн мэргэжилтнүүд | | Орон нутгийнхан, бизнес эрхлэгчид | | | |
|---|---------------------------------------|--------------------------|-----------------------------------|--------|-----------------|-------|
| | АЖХЗ-ийн гишүүд | АЖ-ын газрын мэргэжилтэн | Жуулчны бааз | Малчид | Хөтөч, газарчин | Бусад |
| Ерөнхий | | | | | | |
| Аялал жуулчлалын менежмент | √ | √ | | | | |
| Байгаль хамгаалал | | | √ | √ | √ | √ |
| Аймгийн байршлын онцлог, газар зүй, ургамал, амьтны аймаг | | | √ | √ | √ | √ |
| Орон нутгийн аялал жуулчлалын асуудлууд | √ | √ | √ | √ | √ | √ |
| Жуулчны биеэ авч явах соёл, ёс зүй | √ | √ | √ | √ | √ | √ |
| Олон улсын ба дотоодын жуулчдын онцлог, тэдэнтэй харилцах | √ | √ | √ | √ | √ | √ |
| Харилцааны соёл | √ | √ | √ | √ | √ | √ |
| Тусгай, нарийн мэргэжлийн | | | | | | |
| Ногоон гэрчилгээжүүлэлт | √ | √ | √ | √ | √ | √ |
| Ариун цэвэр, эрүүл ахуй | √ | √ | √ | √ | √ | √ |
| Анхан шатны тусламж үзүүлэх | √ | √ | √ | √ | √ | √ |

Мөн Баянхонгор аймгийн аялал жуулчлалын гол хариуцагч, сонирхогч талуудын төлөөлөл оролцсон сургалтын танилцах аяллуудыг бусад аймаг, газруудад (Улаанбаатар орчим, Өвөрхангай, Өмнөговь зэрэг) болон гадаадад (БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд, Тайланд, Гонконг, БНСУ зэрэг) зохион байгуулах шаардлагатай.

Маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх

Баянхонгор аймаг нь дотоодын аялал жуулчлал, нэн ялангуяа Баруун ба Говийн аймгуудаар явуулах тойрон аялалд өөрийн байр сууриа олсон хэдий ч түүнийг үндэсний болон олон улсын хэмжээнд сурталчлах ажиллагаа хязгаарлагдмал байна. Иймээс "ХОНГОР НУТАГ" нэгдмэл сэдэвтэй брэндийн бүтээгдэхүүн болгож баталгаажуулан сурталчлах нь маркетингийн шинэ стратегийн үндэс болно гэж үзэж байна.

Энэхүү мастер төлөвлөгөөний үр дүн болон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд одоо

бололцоотой байгаа санхүү, хүний нөөцийн эх үүсвэрүүдийг нарийвчлан үнэлж тогтоосны үндсэн дээр маркетингийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж болно.

Маркетингийн стратегийн зорилтууд

Зуны улиралд (бүр тодорхой хэлбэл 6-9 саруудад) Баянхонгор аймагт тодорхой тооны жуулчид зочилдог билээ. Гэхдээ энэ үед зам тээвэр, зочид буудлуудын бололцооноос болж, аялал жуулчлалын компаниуд аяллаар ирэх захиалга өгч байгаа жуулчдыг хязгаарладаг байна. Иймд:

Аялал жуулчлалын үр ашгийн оновчтой менежментийн нарийн системийг бий болгож, нэвтрүүлэх,

Аймгийн нутаг дэвсгэр өргөн уудам бөгөөд жуулчдын үзэх зүйлүүд хоорондоо харьцангуй хол зайтай байдаг ба жуулчны таатай улирал богино зэргийг харгалзан богино зайн тойрон аялал, маршрутаар жуулчид дахин ирж аялах (Хонгор нутгаар) хүслийг төрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх,

Жуулчны улирлыг 6 сарын дундаас 10 сар хүртэл сунгах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Тусгайлсан зорих газрын хувьд /Их Богд, Орог нуур, Шаргалжуут зэрэг/ өөрийн онцлогтой тусгай бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг (нэг болон хэдэн өдрөөр) улам олноор санал болгох нь зүйтэй байна.

Хэрэгжүүлэлтийн сонгосон стратегиуд

Баянхонгор сум, бусад сумдад байрладаг зочид буудлуудын үйлчилгээ үнэ ба жуулчны баазынасуудал.

Үйл ажиллагааны, соёлын зэрэг арга хэмжээ, урлагийн наадмын урамшууллын зэрэг тусгай бүтээгдэхүүнүүдийн төрөлжилт.

Өөрийн гэсэн онцлог үзүүлэлтүүд, хэлбэртэй арга хэмжээнүүд, орчны үе шатлал. Маркетингийн хэмжүүрүүдийн үечлэл ба үндсэн зах зээлүүдэд төлөвлөрсөн байдал. Янз бүрийн зах зээлд зориулсан мэдээллийн кампанит арга хэмжээнүүд (дотоодын зах зээлд аяллын бүтээгдэхүүний нарийн мэдээллүүд чухал бол олон улсын зах зээлд Баянхонгор аймгийн тухай ерөнхий мэдээллүүд илүү чухал байх жишээтэй).

Улаанбаатарт байгаа гол тур операторууд, хэвлэл мэдээллийнхэнд зориулсан жил бүрийн сурталчилгааны аялалтай арга хэмжээнүүд.

Аялал жуулчлалын салбарын хоёр талын гэрээ, хэлэлцээрүүд бүхий хөрш орнууд болон зарим аймгуудтай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулах зэрэг олон улсын ба бүс нутгын хамтын ажиллагаанд үндэслэсэн маркетингийн үйл ажиллагаанд анхаарах.

Гадаадад салбарууд бүхий Европын Холбоо, Япон, БНСУ, БНХАУ-ын тур операторуудтай хамтран ажиллах.

Баянхонгорт урьд өмнө нь аялсан жуулчид, зочлогчдыг голлон анхаарч, тэднийг дахин дахин буцаж ирэхүйц сайхан сэтгэгдлээр үдэх.

Бүтээгдэхүүний бодлого


Баянхонгор аймгийн Соёл, Спорт, Аялал жуулчлалын Газар болон Баянхонгор аймагт аялал жуулчлалаар төрөлжин ажиллах нэгж нь аялал жуулчлалын өөрчлөгдөн байгаа зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг соргогоор мэдэрч, бизнесийн байгууллагын нэгэн адил маркетингийг аймгийн хувьд хийх ёстой. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхдээ хямдавар үнэтэй, чанартай аяллын бүтээгдэхүүнийг хэрэглэгчид сонгох болсон хандлагыг онцгой анхаарах шаардлагатай.

Зорих газрын хувьд Баянхонгор аймаг нь тусгай сонирхлын болон рашаан сувиллын жуулчдын сонирхлыг татах чадвар өндөр бөгөөд энэ нь цаашдаа ч улам

нэмэгдэх хандлагатай байна. Гол анхаарах асуудал бол цаашид шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоосоо өмнө мэдээллийн хангамж бий болгож, одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулан хөгжүүлэх явдал болно.

“Өнөөдрийн үйлчлүүлэгч нь авсаархан аяллыг илүүд үзнэ”

Зураг 15. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд анхаарах асуудал



Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулан, шинийг санал болгохын тулд менежментийн төлөвлөлтийг хийхдээ аялал жуулчлалын иж бүрэн үйлчилгээг орон нутагт боломжийн төлбөртэйгээр бий болгох, энэ талаар аяллын зохион байгуулагч нар, тур операторуудтай хамтрах үйл ажиллагааг анхаарах ёстой болно.

Жуулчдын сэтгэлийг татах, аяллын хэв шинжэд гарч буй өөрчлөлтүүдийн дагуу зорилтот бүлгүүдэд чиглэсэн дараахь стратегиудыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Одоогийн санал болгож байгаа бүтээгдэхүүний төрөлжилт (тусгай сонирхлын аялал, нэмэгдэл үйл ажиллагаанууд бүхий эко-аялал, тоглох болон сургалтын аяллууд)
- Шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, Үзмэр бүхий аялал, Танин мэдэхүйн ба дотоодын аялал жуулчлалыг дэмжих.
- Стандартжуулалт. Үр өгөөж, тооцоолох байдал, харьцуулах бололцоо, урьдчилан төсөөлөлт ба хяналтуудыг үйлчлүүлэгчид бий болгох зэрэг давуу талуудтай.
- Мэргэшүүлэлт. Тусгай сонирхлын аяллын тусгай зохицуулалт, үзмэрүүд, онцгой хэмжүүрүүд зэрэг болно.

Бүтээгдэхүүний иж бүрдэлт. Өнөөгийн сонирхол, хүслийн багц ба үйл ажиллагаанд нийцэхүйцээр амралтын үйл ажиллагааг олон талт болгох.

Үе шатлал. Нэмэлт орчин ба сэтгэл хөдлөлүүд үүсгэсэн ердийн бус аяллууд нь үе шатлал бүхий бүтээлч бүтээгдэхүүнүүд байна.

Чанарыг сайжруулах ба үзмэрийн баяжилт. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулан, баяжуулах нь хамтарсан аяллын багцад багтах Их Богд, Орог нуур, Цагаан Агуй, Бичигт Хад зэрэг жуулчдын гол аялдаг газруудад заавал чухал болно.

Баянхонгор аймгийн нутгаар зохиох аяллыг бий болгож, зах зээлд хүргэх нь ТУР ОПЕРАТОР компанийн үндсэн ажил юм. Гэхдээ зах зээлд одоог хүртэл танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдалд үндэслэн “Буурал түүхийн жимээр”, “Хонгор нутгийн гайхамшиг”, “Хангайн нутгаар” гэсэн сэдэвчилсэн аяллуудыг идэвхтэйгээр хөгжүүлэх шаардлагатай байна (Хавсралт 8-10). Мөн Баянхонгор аймгийн төвд ирсэн зочин гийчин, жуулчид болон хүүхэд, залуучуудад “Аймгийн төвөөр аялах” жишиг аяллын хөтөлбөрийг 11–р хавсралтанд үзүүлэв.

Идэвхжүүлэлтийн бодлого

Идэвхжүүлэлтийн бодлого нь аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги болон аймгийн хөгжлийн бусад төлөвлөгөөнүүдтэй уялдаж, улмаар аймгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тухайн газар нутгийн үнэ цэнийг олон нийтэд таниулах, байгалиа хайрлах, хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлэхэд оршино. Идэвхжүүлэлтийг

Орон нутгийн иргэд болон дотоодын аялагчид

Гадаадын жуулчид гэсэн хоёр бүлгийн хувьд ялгаатай бодлого баримтлан явуулах болно.

Гадаадын жуулчдын хувьд:

- Тухайн газар нутгийн үнэ цэнэ, онцлогийн талаарх мэдээлэл сурталчилгаа
- Түүх, соёлын өв, уламжлалт зан заншлын талаарх мэдээлэл сурталчилгаа
- Бусад аймгуудаас ялгагдах онцлог, давуу талын талаарх мэдээлэл сурталчилгааг түлхүү өгөхөд анхаарах бол


Дотоодын аялагчид, орон нутгийн иргэдийн хувьд:

- АЖ-ын боловсрол олгох
- НИТАЖ-ын талаар мэдлэг олгох
- Эко аялал жуулчлалын талаар мэдлэг олгох
- Тухайн газар нутгийн үнэ, цэнэ, онцлогийн талаарх мэдээлэл сурталчилгааг өгөхөд анхааран ажиллах шаардлагатай.

Дээрх мэдээлэл, сурталчилгааг хамгийн хямд зардлаар шийдэх арга хэрэгсэл болон дараах аргуудыг санал болгож байна. Сургалтын хувьд үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан болно.

Social media ашиглах боломж

Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлэх маркетингийн идэвхжүүлэлтэд залуучуудын нийтлэг ашигладаг болсон хамгийн зардал багатай мэдээлэл дамжуулах хэрэгсэл болох social media – г ашиглах боломжтой юм.



Түүнчлэн жуулчдад хүргэх мэдээллийг түргэн шуурхай болгох, ОУ – ын жишигт нийцүүлэн аялал жуулчлалын үйлчилгээг хүргэх зорилгоор тухайн орон нутаг нь өөрийн website – тай байх ёстой хэмээн үзэж, урьдчилсан байдлаар web – ийн дизайныг дараах байдлаар тодорхойлж байна.

Зураг 16. Аймгийн аялал жуулчлалын веб хуудсын бүтэц



Говь нэгдэл
Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт байдаг Бурханд хад гэдэг газарт эцт том хаднуудад сийлсэн Бурханы олон зургууд байдаг. Эдгээр Бурханы зургуудыг 1890 оны орчим бүтээсэн гэж үздэг.

ҮНДСЭН ЦЭС

- Эрхлэл
- Сайбаран мэдээлэл
- Хэлний бичлэг

НҮҮР ХУУДСАНД ТАВТАЙ НОРИЛНО УУ

МОНГОЛ ДАХЬ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өнөөдөр аялал жуулчлалын салбар нь дэлхийн үндэсний нийт бүтээгдээгүй 10 хувь, худалдаа үйлчилгээний 30 хувь, хөрөнгө оруулалтын 7 хувь, хэрэгцээний зардлын 11 хувь, татварын орлогын 5 хувь, экспортын 10 хувийг эзэлж, хөгжлийн хурдчдаараа нэгдтэ, автомашины үйлдвэрлэлийн дараа гуравдугаарт орж байна. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл дэлхийн эдийн засаг, мөнгөний эргэлтийг хяналттай нийгмийн хөдөлгөөр нь аялал жуулчлал болж байна. Нөгөөтэйгүүр аялал жуулчлал нь "утгагүй үйлдвэрлэл", "үл үзэгдэгч экспорт" гэдэг сонгодог утгаараа дэлхий даямд эрчимтэй хөгжиж байгаа юм.

САНАЛ АСУУЛАА

Zoom!-г та юунд авчигаж байна?

- Олон нийтийн вэбсайт
- Төмийлүүлэгч вэбсайт
- Цэцэн худалдаа
- Багш
- Интернет
- Эрхэгч, хөгжлийн вэбсайт
- Дэрэгч бугда!

ҮНДСЭН ЦЭС

- Эрхлэл
- Сайбаран мэдээлэл
- Хэлний бичлэг
- Аялал жуулчлалын шалбарал
- Төрийн байгууллага
- Эвний арга хэлбэр
- Аялал жуулчлалын байгууллага
- Аялалчид
- Хөтөч, таялбарлагч

НҮҮР ХУУДСАНД ТАВТАЙ НОРИЛНО УУ

МОНГОЛ ДАХЬ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өнөөдөр аялал жуулчлалын салбар нь дэлхийн үндэсний нийт бүтээгдээгүй 10 хувь, худалдаа үйлчилгээний 30 хувь, хөрөнгө оруулалтын 7 хувь, хэрэгцээний зардлын 11 хувь, татварын орлогын 5 хувь, экспортын 10 хувийг эзэлж, хөгжлийн хурдчдаараа нэгдтэ, автомашины үйлдвэрлэлийн дараа гуравдугаарт орж байна. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл дэлхийн эдийн засаг, мөнгөний эргэлтийг хяналттай нийгмийн хөдөлгөөр нь аялал жуулчлал болж байна. Нөгөөтэйгүүр аялал жуулчлал нь "утгагүй үйлдвэрлэл", "үл үзэгдэгч экспорт" гэдэг сонгодог утгаараа дэлхий даямд эрчимтэй хөгжиж байгаа юм.

САНАЛ АСУУЛАА

Zoom!-г та юунд авчигаж байна?

- Олон нийтийн вэбсайт
- Төмийлүүлэгч вэбсайт
- Цэцэн худалдаа
- Багш
- Интернет
- Эрхэгч, хөгжлийн вэбсайт
- Дэрэгч бугда!

НЭВТРЭХ ХЭСГ

Харгалачийн нэр

Нууцгүй

Нэмэлт саяма

Японы аялал жуулчлалын зах зээл дээр Монголын эзэлж буй **Японы улс үндэсний аялал жуулчлалын байр** сүлжээ

2007 оны 7-р сарын 07, Банба гариг, 09:54

Монголын Японос жуулчлал хувьд авах чиглэлээр зах зээлийг хөгжүүлэх ихээхэн давуу тал бий

- Газар зүйн байршлын хувьд ойрхон, түүнчлэн өвөрмөц цаг уур, байгаль орчин, хүү

Аяллын үйлгэрчлэсэн загвар **Бичигч Administratev**

2007 оны 7-р сарын 07, Банба гариг, 09:54

Японы улс үндэсний 8 өдрийн үйлгэрчлэсэн программ нь...

- Улаанбаатарг 3 хоног (хэрэгцэн ирэх, бүсэд чиглэгчд шилжих, буцаж явах)
- Улаанбаатарын орчин дахь жуулчлалын гэр баазад 2 хоног

ХЭН ОНЛАЙН БАЙНА

Манайд 1 зочин онлайн

СУРГАЛЧИЛАА

Хэрэгчтэй холбоосууд:

Zoom!-г та юунд авчигаж байна?

Анхаарвал зохих маркетингийн гол үйл ажиллагаанууд:

Цаашид, үйлчлүүлэгчдэд зориулсан маркетингийг янз бүрийн зорилтот бүлгүүдийн (Амралтын, бизнесийн, дотоодын аялагчдын, багш, оюутнуудын, үүргэвчтэй аялагчдын, үрлэгэн хүмүүст гэх мэтээр) сонирхолд нийцсэн үзүүлэн таниулах материалуудаар гүйцэтгэх хэрэгтэй.

“Хонгор нутгийн гайхамшиг” зэрэг сэдэвчилсэн ажлын төлөвлөлтийг урьд жилүүдээс бэлтгэж, нэгдсэн байдлаар хөгжүүлж, хэрэгжүүлэх шаардлагатай. Дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох ажлыг жилийн эхнээс төлөвлөж, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх хэрэгтэй.

Маш чухал асуудал бол Баянхонгор аймгийн тухай материалуудыг гол сонгосон сэтгүүл, сонингуудад хэвлэх байдлаар янз бүрийн үйлчлүүлэгчдэд хүрч чадах олон нийттэй харилцах үйл ажиллагааг бий болгох явдал юм. Үүнд:

- Ялгагдах брэнд тэмдгийг бий болгох
- Хэвлэл, мэдээллийн стратегийн төлөвлөлтийг хийхдээ зардал багатай төсөв

бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах

- Хэвлэлийн тойм бий болгох
- Хэвлэмэл, электрон болон өргөн нэвтрүүлгийн газруудтай хамтрах
- Үндэсний ба олон улсын хэвлэлийн харилцааг бэхжүүлэх
- Хэвлэл, мэдээллийн бааз бүрдүүлэх,
- Үндэсний ба олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчид оролцсон аяллууд
- Имидж сайжруулах
- Онцгой байдлын менежментийн төлөвлөгөөтэй байх
- Арга хэмжээний менежмент ба хэвлэлийн бага хурлууд зохион байгуулах
- Хэвлэл, мэдээллийн сургалт явуулах
- Сурталчилгааны материалыг бий болгох
- Сурталчилгааны хамтрагчид ба Маркетингийн сүлжээг бий болгох
- Түүнчлэн аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, маркетингийн шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлохын тулд цаашид аялал жуулчлалын даацыг тодорхойлсны үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай хэмээн үзэж, даацыг тодорхойлох арга зүй болон жишээг төлөвлөгөөнд тусгасан болно.

Аялал жуулчлалын хүчин чадлын даацыг тодорхойлох

Аялал жуулчлалын даац гэдэг нь өргөн хүрээтэй, маргаантай ойлголт бөгөөд ерөнхийдөө “Нэгж нутаг дэвсгэрээр нэгж хугацаанд аялаж, зочилж болох жуулчдын дундаж стандарт хэмжээ” юм. Энэхүү дундаж стандарт хэмжээ нь тухайн газар орны экосистемийн онцлог, дэд бүтэц, үйлчилгээний байгууллагын хүчин чадал зэргээс хамаараад газар орон бүрт адилгүй байна. Аялал жуулчлалын даацыг тодорхойлохын тулд аялал жуулчлалын хүчин чадал гэсэн ойлголтыг авч үзнэ. Бүс нутаг, газар орны аялал жуулчлалын хүчин чадал нь жуулчдын сэтгэл ханамжтай байгаа эсэхээр хэмжигддэг болно.

Аялал жуулчлалын хүчин чадал гэдэг нь “Тухайн газар нутагт айлчлан ирж буй жуулчид хүрээлэн буй орчинд хамгийн бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж, дээд зэргээр сэтгэл ханамж авч чадах хамгийн зохимжтой түвшний хэмжээг хэлнэ”[11]. Өөрөөр хэлбэл тодорхой газар нутгаар байгалийн иж бүрдэлд төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр өндөр сэтгэгдэлтэй аялаж, зугаалах жуулчдын зохистой тоо юм. Монгол орны нөхцөлд аялал жуулчлалын хүчин чадлыг хүн амын, дэд бүтцийн, уламжлалт ахуйн соёл, байгалийн иж бүрдлийн онцлогоор тодорхойлох нь зүйтэй. Аялал жуулчлалын хүчин чадлыг (АЖХЧ) тооны хэлээр илэрхийлбэл:

АЖХЧ = Жуулчин хүлээн авч буй газар нутгийн хэмжээ / Дундаж стандарт хэмжээ

Харин хүчин чадлын эрэлтийн коэффициенттэй харьцуулан үржүүлсэн үржвэр нь өдрийн аяллын нийлбэр юм. Энэ нь:

Нэг өдөрт аялах хүлээн авах жуулчдын тоо = Хүчин чадал * Эрэлтийн коэффициент
Эрэлтийн коэффициент = Нэг өдөрт жуулчдыг хүлээн авах хугацаа / жуулчдын байрлах дундаж хугацаа

Олон улсын төвшинд түгээмэл хэрэглэж буй энэхүү аргазүйд тулгуурлан Баянхонгор аймгийн аялал жуулчлалын голлох зорин очих газруудад даац тодорхойлох шаардлагатай бөгөөд рашаан сувиллын жишээг доор үзүүлээ.

Хүснэгт 25. Зорин очих газрын даацын үнэлгээ

| Газрын нэр | Талбай | Ойр орчмын байрлуулах хэрэгсэлийн тоо, орны тоо | Дотоодын жуулчин/зуны саруудад | Гадаадын жуулчин/ зуны саруудад | Өдөрт хүлээн авах жуулчдын тоо | Нэгж хугацаан дахь амрагчдын нягт (Хүн/га/цаг) | Рекреацийн ачаалал (Хүн/га/цаг) | Рекреацийн хоногийн дундаж ачаалал (Хүн/га) | Жилийн рекреацийн ачаалал (хүн/жил/га) |
|------------|--------|---|--------------------------------|---------------------------------|--------------------------------|--|---------------------------------|---|--|
| Шаргалжуут | 2 га | | 3950 | 150 | 120 | 7,5 | 26,3 | 540 | 21600 |

ЖИШЭЭ. Улаан цутгалан орчмын даацын үнэлгээ. Хамрагдах газар нутгийн хэмжээ 2 га газар Ойр хавьд байрлах жуулчны баазууд: Guest house – 12 жуулчин байрлах зочны гэр, нэг зочны гэр дунджаар 4 гэр, гэр тус бүр 3-4 ортой
Жуулчны бааз- 3 жуулчны бааз, нэг жуулчны бааз 12 гэр, гэр тус бүр 2 ортой
2011 оны байдлаар Улаан цутгалан орчмын 2 га талбайд ирсэн дотоод болон гадаадын аялагч жуулчдын тоо

| Сар | Гадаад | | Дотоод | |
|----------|--------|------|--------|------|
| | Өдөрт | Сард | Өдөрт | Сард |
| VI | 80 | 2400 | 150 | 4500 |
| VII-VIII | 100 | 3100 | 250 | 7750 |
| IX | 150 | 4500 | 60-70 | 1950 |

Улаан цутгаланг үзэн сонирхож байгаа жуулчдын дийлэнх хувь нь энэ газар 1 хонодог байна.

Нэг өдөрт хүлээн авах жуулчдын тоо

$$AJXЧ = 20000m^2 / 100m^2 = 200$$

$$\text{Эрэлтийн коэффициент} = 11 \text{ цаг} / 3\text{цаг} = 3,7$$

$$\text{Нэг өдөрт хүлээн авах жуулчдын тоо} = 200 * 3,7 = 740 \text{ хүн}$$

Нэгж хугацаан дахь амрагчдын нягтыг олох дунджаар

$$D_n = \text{Ирж буй жуулчдын тоог/судалгаа хийгдэх газарын хэмжээ/ажиглах хугцаа}$$

$$D_n = \text{нэг цагийн хугацаан дахь амрагчдын нягт, хүн/га}$$

$$D_n = 350/2\text{га}/24 \text{ цаг} = 7,5 \text{ хүн/ га хцаг}$$

Нэг цагт үзүүлэх рекреацийн ачаалал

$$N_n = D_n * t$$

$$N_n = \text{нэг цаг дахь рекреацийн ачаалал, хүн/ га хцаг}$$

$$D_n = \text{нэг цагийн хугацаан дахь амрагчдын нягт, хүн/га}$$

$$T = \text{амрагчдын байх хугацаа}$$

$$N_n = 7,5 * 3\text{цаг} = 22,5 \text{ хүн/ га хцаг}$$

Рекреацийн хоногийн дундаж ачаалал

$$N_{ад} = \sum_{i=1}^n N_{адi} * n$$

$$N_{ад} = \text{рекреацийн хоногийн дундаж ачаалал, хүн/цаг/га}$$

$$N_{ад} = i \text{ хоногийн ажиглалтын рекреацийн ачаалал, хүн-цаг/га}$$

$$n = \text{ажиглалтын хоног}$$

$$N_{ад} = 22,5 * 24 = 540 \text{ хүн/цаг/га}$$

Жилийн рекреацийн ачаалал

$$N_n = N_{ад} * t$$

$$N_n = \text{рекреацийн жилийн ачаалал, хүн/жил/га}$$

$$N_{ад} = \text{рекреацийн хоногийн дундаж ачаалал, хүн/цаг/га}$$

$$T = \text{амралтын хоног}$$

$$N_n = 540 * 12 = 65880 \text{ хүн/жил/га}$$

Аялал жуулчлалын бүс нутаг дахь зам, аяллын гол үзмэрүүдийг тэмдэгжүүлэх

Орон нутагт аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх хамгийн гол хүчин зүйлийн нэг нь дэд бүтцийн хөгжлийн асуудал бөгөөд ялангуяа төв суурин газраас алслагдсан газар нутаг дахь байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газар, рашаан усыг зорих аялагч жуулчдын аюулгүй байдал, тав тухыг хангах үүднээс автозамын тэмдэг тэдэглэгээг зохих шаардлагын дагуу хийж байрлуулах нь нэн чухал юм.

Ялангуяа орон нутгийн шинж чанартай зам олноор сүлжилдсэн газар нутгуудад энэ төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аялал жуулчлалын тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг хангахад ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ юм.

Баянхонгор аймаг нь Өвөрхангай, Өмнөговь, Архангай гэсэн аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа аймаг бүс нутгуудтай хил залган оршихийн зэрэгцээ тухайн аймгуудын нутаг дахь жуулчид олноор очдог газар нутаг нь Баянхонгор аймгийн хилтэй ойр залгаа байгаа нь давуу талыг бий болгох боломж нөхцөлийг бүрдүүлж байна.

Замын тэмдэг тэмдэглэгээг зохих газруудад байрлуулах нь:

Анх удаа аялаж байгаа хүмүүсийн хувьд төөрөх, буруу зөрүү явахаас урьдчилан сэргийлэх

Амрагч жуулчид өөрсдийн зорьж буй түүх соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар, рашаан ус хүртэл хэдэн км замыг туулах тухай урьдчилан мэдэх боломжтой болох

Түүх соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэн газар, рашаан усыг зорих замыг бусад төрлийн замаас ялгах

Орон нутгийн аялал жуулчлалын хариуцлага тогтвортой байдлыг дэмжих ач холбогдолтой юм.

Аймгийн нутаг дэвсгэрт байгаа байгаль, түүх соёлын өвүүдийн дотроос аялал жуулчлалын салбарт ач холбогдолтой гадаад болон дотоодын аялагч жуулчдын сонирхлыг татахуйц гол гол дурсгалуудыг тусгайлан авч үзэж тэдгээрт дурсгалыг зорих автозамын дагуу тэмдэг тэмдэглэгээг нэн тэргүүнд хийж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

- Түүхэн ач холбогдол /он цаг/
- Дахин давтагдашгүй өвөрмөц шинж чанар
- Түүхэн дурсгалын өнөөгийн байдал
- Дэд бүтцийн хөгжил /зам харилцаа/
- Бусад төрлийн үзмэрүүдтэй /байгалийн үзэсгэлэнт газар, рашаан ус/ нэг бүс нутагт ойролцоо орших
- Аялал жуулчлалын үндсэн маршрутын дагуу байрлах
- Үйлчилгээний газартай ойр /сумын төв болон жуулчны бааз, хоол ундааны газар/
- Ирээдүйд бүс нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг тодорхойлохуйц үзмэр байж чадах /бусад бүс нутаг дахь ижил төрлийн үзмэрүүдээс давуу талыг өөртөө агуулсан/

зэрэг үндсэн шалгуурын дагуу дээрх үзмэрүүдийг тус аймгийн нутаг дахь жуулчдын зорин очих түүх соёлын дурсгалд тооцож эхний ээлжинд тухайн дурсгалыг зорих замын тэмдэг тэмдэглэгээг хийхийг зөвлөж байна.

Хүснэгт 26. Гол үзмэрүүдийн тэмдэг, тэмдэглэгээний байршил

| № | Түүх соёлын дурсгал | Маршрутын чиглэл |
|---|----------------------------|--|
| 1 | Цагаан агуй | Баянхонгор аймгийн Богд сумаас - Цагаан агуй чиглэлийн зам |
| | | Өвөрхангай аймгийн Богд сумаас – Цагаан агуйн чиглэлийн зам |
| | | Баянхонгор аймгийн Баянлиг сумаас – Цагаан агуйн чиглэлийн зам |
| 2 | Бичигтийн хадны зураг | Баянлиг сумаас – Бичигтийн хадны чиглэлийн зам |
| | | Баянговь сумаас – Бичигтийн хадны чиглэлийн зам |
| | | Хонгорийн элснээс – Бичигт хадны чиглэлийн зам |
| | | Бүгийн цаваас – Бичигт хадны чиглэлийн зам |
| 3 | Цагаан булгийн хадны зураг | Баянговь сумаас – Цагаан булгийн чиглэлийн зам |
| | | Бичигт хаднаас – Цагаан булгийн чиглэлийн зам |
| 4 | Шатар чулууны дурсгал | Баянхонгор аймгийн төвөөс – Шатар чулууны чиглэлийн зам |
| | | Эрдэнэцогт сумаас – Шатар чулууны дурсгалын чиглэлийн зам |

Тайлбар: Дээрх 4 гол дурсгал нь төв суурин газар бус хөдөө хээр байдаг тул тухайн дурсгалыг зорих замын тэмдэг тэмдэглэгээг замын уулзвар бүрт хийх, харин Хачин ламын сүм нь Эрдэнэцогт сумын төвд байдаг тул тухайн чиглэлийг заах тэмдгийг хийх шаардлагагүй юм.

Замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулах автозамын чиглэлийг тодорхойлохдоо аялал жуулчлалын үндсэн маршрут чиглэлийг харгалзан үзсэн болно.

Түүх соёлын дурсгалыг заах замын тэмдэг тэмдэглэгээ нь нэгдсэн стандарт загвартай байх,

Замын тэмдэг тэмдэглэгээг 2014 онд багтаан хийж гүйцэтгэх.

Хамтын ажиллагаа

Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг сумдаас дэмжин хэрэгжүүлэх

Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид орон нутгийн онцлогт тохирсон тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлж энэ салбарт нутгийн иргэд, төр, төрийн бус байгууллага, бүлэглэл, хоршоо зэргийг оролцуулах шаардлагатай байгааг харгалзан үзэж сумдад аялал жуулчлалыг хөгжүүлэх дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төлөөлөгчид, бүх шатны Засаг дарга нар:

Сумын аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлтийг орон нутгийн онцлог болон улс, аймаг орон нутгаас баримтлаж буй хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан боловсронгуй болгох;

Орон нутагтаа дотоодын болон гадаадын аялал жуулчлал хөгжих боломжтой бүс нутаг, аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнээ тодорхойлж хувийн болон бизнес эрхлэгчдийн оролцоо хамтын үйл ажиллагаагаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, сайжруулахад хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлэх;

Дотоод, болон гадаадын жуулчдын сонирхол татахуйц арга хэмжээ, үйлчилгээ үйл ажиллагааны төлбөрийн зөрүүтэй байдлыг арилгах.

Сумын орон нутаг судлах музейг шинэчилж, үзмэрүүдийг сайжруулж сумын

түүхэн замнал, байгалийн болон түүх соёлын дурсгал, ан аьтан, газар шороо, уул, ус, ургамлууд болоод хөгжил дэвшил, ололт амжилт гэх мэт зүйлүүдийн дээж болон мэдээллүүдээр мэдээллийн сан бүрдүүлж ажиллах.

Аялал жуулчлалын нөөц бүтээгдэхүүн болох байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын үл хөдлөх дурсгал ховор ан амьтан, эмийн ургамал бүхий газрыг улс, аймаг, сум орон нутгийн тусгай хамгаалалтад авах, харуул хамгаалалтыг сайжруулж, малчдад гэрээгээр хамгаалуулах.

Орон нутгийн аяллын маршрутуудыг гарган, хүүхэд, залуучуудыг аялуулж, төрсөн нутаг орноороо бахархах үзлээр төлөвшүүлэх.

Иргэд бүлэг, нөхөрлөл, хоршоо байгуулан, орон нутагтаа байгаа байгалийн үзэсгэлэнт газар, аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ сэргээн тохижуулан, хамгаалж жуулчид хүлээн авч үйлчлэх бизнес хийх боломжийг бүрдүүлэх.

Сумын зорчигч тээвэр үйлчилгээг нэгдсэн бүртгэлтэй болгож тодорхой хуваарь, графикт оруулах.

Хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдийн амжиргааг дэмжсэн үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих.

Аялал жуулчлалын мэдээллийн сангийн мэдээллийн баазыг өргөжүүлэх, тогтмол шинэчлэх, гадаад дотоодын жуулчдад салбарын мэдээ мэдээллийг шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх.

Тухайн орон нутаг үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газруудын чанарыг сайжруулж, холбогдох дүрэм, журам, стандарт, норм нормативыг хангаж ажиллах.

Жуулчны аюулгүй байдлыг хангах, алив эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

Биет болон биет бус соёлын өвийг хамгаалахад анхааран, тогтвортой аялал жуулчлалыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэх.

Жил тутам соёлын арга хэмжээнүүдийг төлөвлөн жилийн өмнөөс зарлах

Монгол ёс, зан заншлын наадам, үзүүлбэр, шашин номын зан үйл, орон нутгийн онцлогтой уламжлалт арга хэмжээнүүд /тухайлбал, тэмээний баяр, сарлагын уралдаан гм./-ийг сайтар бэлтгэж, тогтсон цаг хугацаанд уламжлал болгон зохион байгуулж хэвших.

Онгон байгаль, байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг аялал жуулчлалын түшиц газруудыг бохирдуулахгүй цэвэр дагшин байлгах асуудал нэн чухал юм. Энэ чиглэлээр дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- Дээрх бус нутгуудад хог хаясан тохиолдолд торгууль төлдөг тогтолцоог бүрдүүлэх
- Тусгай хамгаалалттай газар нутаг болон Аялал жуулчлалын бүтээгдэхүүн бүхий газар нутагруу нэвтрэх хаалган дээр хог хаяхыг хориглох талаар болон торгуулийн хэмжээ бусад мэдээллийг өгөх
- Газар дээр нь танилцуулга хийх (ухуулах хуудас, сурталчилгааны самбар, байгаль хамгаалагч нар жуулчин тус бүрт заавар өгөх), зориулалтын саванд хог хаях болон цуглуулах, тээвэрлэх системийг бүрдүүлэх
- Төр болон Төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан дотоодын хогны эсрэг компани /байгаль орчныг үнэлж ойлгох талаар үндэсний ойлголт бий болгох/ ажил зохион байгуулах
- Сургуулийн хичээлийн хөтөлбөр болон экскурсээр дамжуулан байгаль орчныг хамгаалах нь яагаад чухал болох талаар ерөнхий ойлголтыг бий болгох

АЖ-ЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД БОЛОН БУСАД САЛБАРУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд олон талуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэгч гол байгууллага

нь аймгийн аялал жуулчлалын газар бөгөөд аялал жуулчлалын харилцаанд оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зураг 17. Аймгийн аялал жуулчлалын харилцаанд оролцогч талууд



Дээрх байгууллага болон орон нутгийн иргэд нь энэхүү аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах үүрэгтэйгээр оролцоно.

Хүснэгт 27. Аялал жуулчлалын харилцаанд оролцогч талуудын хамтын үйл ажиллагаа

| АЖ – ын харилцаанд оролцогч талууд | АЖ – ын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо |
|--|--|
| Төрийн байгууллага | |
| БОНХЯ, ССАЖЯ | Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь аймгийн АЖ – ын газар байна. БОНХЯ болон ССАЖЯ, аймаг сумдын ЗДТГ нь хэрэгжилтийг дэмжин ажиллахаас гадна хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. Рашаан, сувиллын аялал жуулчлалын хөгжүүлэх тал дээр мэргэжлийн хяналтын байгууллагуудын туслалцааг авч, рашаан усыг шинжлүүлэх, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлуулах тал дээр хамтарч ажиллана. Эрүүл мэндийн байгууллагуудтай мөн рашаан, сувиллын аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр хамтарч, тэдний туслалцааг авч ажиллах нь чухал. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, байгалийн үнэ цэнийг мэдрүүлэх тал дээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай байх шаардлагатай. ЕБС болон цэцэрлэгийн хүүхдээс эхлээд байгаль орчны боловсрол олгох тал дээр боловсролын байгууллагуудтай хамтарч ажиллах нь чухал. |
| Баянхонгор аймгийн АЖ – ын газар | |
| Аймгийн ЗДТГ болон сумдын ЗДТГ, засаг дарга нар | |
| Мэргэжлийн хяналтын байгууллагууд | |
| Эрүүл мэндийн салбарын байгууллагууд | |
| Хэвлэл мэдээллийн байгууллагууд | |
| Боловсролын салбарын байгууллагууд | |
| Төрийн бус байгууллага | |
| Аялал жуулчлалын зөвлөл | Төлөвлөгөөнд аялал жуулчлалын зөвлөлийг байгуулахаар тусгасан байгаа бөгөөд энэхүү зөвлөл нь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр оруулах болно. Түүнчлэн байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх, байгаль хамгаалал, НИТАЖ – д орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой. |
| Бусад байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагууд | |

| | |
|---|--|
| Хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд | |
| Тур операторууд | Төлөвлөгөөнд санал болгож буй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг жуулчдад хүргэхэд зуучлах, АЖ – ын бүсчлэл болон бусад маркетингийн арга хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд эдгээр байгууллагуудтай хамтран ажиллана. Аймгийн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, аяллын үзмэрүүдэд үнэлгээ хийх ажлыг тур операторуудын тусламжтайгаар зохион байгуулна. Аяллын шинэ маршрут гаргах тал дээр тур операторуудын саналыг сонсож, үнэлгээ хийх замаар аяллын шинэ бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлно. |
| Жуулчны баазууд | |
| Үйлчилгээний байгууллагууд | |
| Донор байгууллагууд | |
| НҮБ | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийг чадваржуулахад анхаарал тавина. |
| Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг | |
| Дэлхийн байгаль хамгаалах сан | |
| Орон нутгийн иргэд | |
| Малчид болон орон нутгийн иргэд | Төлөвлөгөөнд тусгагдсан АЖ – ын тогтвортой хөгжлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, НИТАЖ – ийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх. |

Баянхонгор аймагт аялал жуулчлалын хөгжлийн суурийг тавьж байгаа ойрын жилүүдэд маркетинг ба сурталчилгааны үйл ажиллагааг төрийн ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар зохицуулж дэмжих явдал туйлын чухал. Энэ чиглэлээр дараах зөвлөмжийг санал болгож байна.

- Аялал жуулчлал дахь орон нутгийн оролцоог дээшлүүлэх, тэдэнд ухуулан таниулах зорилгоор аялал жуулчлалын уулзалт ярилцлагуудыг зохион байгуулах
- Бүтээгдэхүүний төрөлжилт чанарыг сайжруулснаар дахин иргэж ирэх жуулчдыг хөхүүлэн дэмжих
- Дотоод, гадаадын аялал жуулчлалын бизнес эрхлэгчид, тур операторууд сэтгүүлчид, кино үйлдвэрлэгчдийн багийг тухайн орон нутагтай танилцах аялал хийлгэх ажлыг аймгийн Аялал жуулчлал хариуцсан бүтэц хариуцан зохион байгуулж байх
- Аялал жуулчлалын хэвлэл мэдээллээр дамжуулан ерөнхий сурталчилгааг хийх
- Аялал жуулчлалын сэтгүүлүүдэд хэвлэлийн мэдээ өгөх
- Сэтгүүлчдэд зориулсан сургалтын аялал зохион байгуулах
- Аяллын лавлах ном зохиогчдод тусламж үзүүлэх
- Сумын талаар бичлэг хийхэд нь ТВ болон кино зураглаачдад туслах
- Онцлог зорилт бүхий группуудтэй шууд холбоо тогтоох
- Сонгож авсан холбоодруу шуудангаар болон электрон мэдээлэл явуулах (онцлог зорилт бүхий групп гэдэгт: соёл, загасчид, морь унагчид, шувуу ажиглагч нарын холбоод г.м.)
- Зочид буудал, зоогийн газруудыг дадлага туршлага бүхий ажилтнаар хангах зорилгоор курс дамжаанд хамруулах.
- Аймгийн аялал жуулчлал хариуцсан бүтэц нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран дараах ажлуудыг зохион байгуулж байх:
 - Жил тутам соёлын арга хэмжээнүүдийг төлөвлөн жилийн өмнөөс зарлах
 - Соёлын хөтөлбөрүүдийг сурталчилах /ялангуяа хэсэгчилсэн тоглолтууд/, жуулчдыг эдгээр хөтөлбөрийг үзэх боломжоор хангах /хөтөлбөрт бэсрэг наадам, циркийн үзүүлбэр, монгол зан үйлийн үзүүлбэрүүд гэх мэт зүйлс орсон байх/
 - Монгол ёс, зан заншлын наадам, үзүүлбэр, шашин номын зан үйл, орон нутгийн онцлогтой уламжлалт арга хэмжээнүүд /тухайлбал, тэмээний баяр, сарлагын уралдаан гм./-ийг сайтар бэлтгэж, тогтсон цаг хугацаанд уламжлал болгон зохион

байгуулж хэвших

- Үндэсний уламжлалт урлагийг сурталчлах

Дээрх зөвлөмжүүдийг сумын хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусган холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг нь тооцож байх нь энэхүү мастер төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно.

Хяналт, үнэлгээ

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр хийх бөгөөд стратегийн эхний шатны биелэлтийг 2016 онд, хоёрдахь шатны биелэлтийг төлөвлөгөөт оны эцэст нэгтгэн дүгнэж, дараагийн шатны зорилтуудыг дэвшүүлнэ. Төлөвлөгөөний биелэлтийг гол зорилго, зорилт тус бүрээр үнэлэх бөгөөд зорилгын биелэлтийг шалгуур үзүүлэлт болгон тодорхойлно.

| Стратегийн зорилго | Хугацаа | Хүрсэн байх үр дүн |
|---|-----------|---|
| Аялал жуулчлалын үйлчилгээний баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах | 2013-2016 | Зочид буудлын цогцолбор баригдаж, Бөөнцагаан нуурын хөвөөнд жуулчны баазыг байгуулж ашиглалтад оруулснаар АЖ-ын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт дэмжигдсэн байна. Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлсний үр дүнд аймгийг зорин ирэх жуулчдын тоо нэмэгдэж, өсөлтийн хувилбарын өндөр өсөлтөнд хүрсэн байна. Аяллын үзмэр болон рашаан, сувиллын үйлчилгээний даацын судалгаа хийгдэж, дэд бүтцийн асуудлууд шийдэгдсэн байна. Аяллын гол зорин очих газруудын тэмдэгжүүлэлт бүрэн хийгдэж дууссан байна. Аялал жуулчлалын өсөлтийг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагуудын орлого нэмэгдэн, үйлчилгээний чанар, стандартын түвшин дээшилсэн байна. АЖ-ын харилцаанд оролцогч талуудын АЖ-ын болон байгаль орчны талаарх мэдлэг нэмэгдэж, НИТАЖ хөгжсөн байна. |
| МУ-ын аялал жуулчлалын топ 5 аймагт багтах | 2017-2020 | АЖ-ын гол зорин очих газруудыг түшиглэн жуулчны урсгал хөдөлгөөн нэмэгдэхтэй холбоотойгоор үйлчилгээний шинэ хэлбэрүүд бий болж, үүнийг дагаад ажлын байр нэмэгдсэн байна. Гадаадын жуулчдын жилийн дундаж өсөлт болон дотоодын аялагчдын өсөлт 10% - д хүрсэн байна. АЖ-ын өсөлтийг даган нутгийн иргэдийн жижиг дунд үйлдвэрлэл эрчимжин, сүү цагаан идээний борлуулалт нэмэгдсэн байна. НИТАЖ хөгжиж орон нутгийн иргэдийн орлого нэмэгдсэн байна. Түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудын аялал жуулчлалын үнэ цэнэ ач холбогдол нэмэгдсэнээр тухайн орчны хамгаалалт болон үйлчилгээний шинэ менежментүүд нэвтэрсэн байна. Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа тогтмолжиж, идэвхитэй маркетинг хийгддэг болсон байна. |

Ашигласан материал

- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аялал жуулчлалын форум. Улаанбаатар хот, 2013 он
- Баасан.Т. Баянхонгор аймгийн газар усны нэрийн бага нэвтэрхий толь. Улаанбаатар, 2006 он
- Баянхонгор аймгийн 2012 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
- Баянхонгор аймгийн 15 жилийн хөгжлийн хөтөлбөр
- Баянхонгор аймгийн статистик. 2013 он
- Д.Гансүх. Хөдөөгийн аялал жуулчлал
- Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгааны тайлан. Улаанбаатар хот, 2013 он.

Хангайн бүсийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын материал. Улаанбаатар хот. 2013 он.

Нйктор Ceballos-Lascurbin (1996). “*Tourism, ecotourism, and protected areas: the state of nature-based tourism*” IUCN Protected Areas Programme
UNWTO, Tourism 2020 Vision. 2001

WEF, Travel & Tourism Competitiveness Report. 2013

Цахим мэдээллийн эх үүсвэрүүд:

www.mongoliatourism.gov.mn

www.bayankhongor.gov.mn

www.bayankhongor.com

www.legendtour.ru/mongolia/regions/bayan-khongor/

www.facebook.com/Bayankhongor

www.bayankhongor.blog.banjig.net

bayankhongor.net

galuut.bayankhongor.mn

khongornutag.mn

Хавсралт 1. Аялал жуулчлалын гол үзэмэр, нөөцүүд

| № | Үзэмэрүүд | Тайлбар |
|---|-----------------------------|--|
| 1 | Бичигт хад | Баянлиг сумын нутаг Баянгийн нурууны Их Бичигтийн амны хадны сүг зураг бүхий эртний бичиг соёлын үнэт өв юм. Бичигт хадны сүг зургуудыг ажиглаж байхад түүхийн хоёр өөр цаг үед бүтээгдсэн байх гэж хэлж болохоор хоёр өөр өнгөөр дүрслэгдсэн зургууд байдаг. |
| 2 | Бөөнцагаан нуур | Баянхонгор аймаг дахь Нууруудын хөндийн хамгийн том, давст нуур юм. Хангайн нурууны өмнөд хажуугаас эх авч урсах Байдраг гол цутгах боловч гадагш гарах урсгалгүй. Энэ нуурын эрэг намхан элсэрхэг хөрстэй бөгөөд нутгийн өвс ургамал бүхий намгаар баялаг. Бөөн цагаан нуурт Хангайн нурууны өмнөд хажуугаас эх авч урсах Байдраг гол цутгадаг. |
| 3 | Бүгийн цав | Бүгийн цавийн хоолойд 70-80 сая жилийн өмнөх үлэг гүрвэлийн чулуужсан яс их олддог. Энд эртний хэвэл хөлтөн, дун хясаа, том бага яст мэлхий, загасны үлдэгдэл зэрэг эрт галавын далай тэнгисийн дулаан усанд амьдарч байсан амьтдын яс, зөөлөн нэхдэст намгийн дүрсийн ургамлын үлдэц элбэг олддог. |
| 4 | Галуутын Бурхант хад | Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт байдаг Бурхант хад гэдэг газарт эгц том хаднуудад сийлсэн Бурханы олон зургууд байдаг. Эдгээр бурханы зургуудыг 1890 оны орчим бүтээсэн гэж үздэг. |
| 5 | Галуутын хавцал | Галуутын хавцал нь дунджаар 200-400 метр гүн, 50-200 метр өргөн, эрс цавчим хажуу ханатай, хамгийн нарийн газраа дөнгөж 2-3 метр өргөн хадан боом болж ирсэн тэр хэсэгт ялангуяа гол ус үертэй үед хүчтэй сүрлэг хүрхрээ боргио үүснэ. |
| 6 | Говийн үзэсгэлэнт байгаль | Баянхонгор аймгийн говийн үзэсгэлэнт байгаль нь аймгийн төвөөсөө 150 км-т орших их говийн элсэн манхан, заган шугуйд шургалан тогтсон Бөөнцагаан болон Орог нуур, Монголын хоолойгоос эхлэн эх орны баруун хязгаар буюу Монгол улсын торгон хил хүртэл сунан тогтсон өргөн уудам нутгийг хамарна. |
| 7 | Гүр дууны нот “Ян-И” | Чин сузэгт Номун хан 10доогийн Баянхонгор аймгийн Галуут сумын Мандалын хийд Лувсанноровширавын удаа дараагийн дүр хувилгаанд зохиосон “Гүр дууны бичиг” хөгжмийн бүтээл нь 18-р зууны томоохон туурвилын нэг юм. |
| 8 | Заг-Байдрагийн Хүрэн бэлчир | 800 зууны тэртээ Их эзэн Чингэс хаан Их Монгол улсыг байгуулах их үйлсын төлөө Ван хаантай байлдаж байсан түүхийн дурсгалт газар юм. Хожим түүхийн энэ дурсгалт газар Их Монгол улсын хаад, ноёд, төрийн зүтгэлтнүүд цугларч Улсын Их Хуралдайг хуралдуулан Монгол улсын хувь заяатай холбоотой амин чухал асуудлуудыг хэлэлцэж байсан түүхтэй. |
| 9 | Их Богд уул | Монголын их говьд орших атлаа хангайн байгалийг санагдуулам номин ногоон хөвд ургамал, өнгө алаглах цэцэгсийн хүрээлэн, хүрхрэн шуугих өндөр уулын түргэн урсгалт гол горхи, газар хөдлөлтөөс тогтсон байгалийн өвөрмөц сонин тогтоц, нуур, дэлхийд ховордож дархлагдсан аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтад, вансэмбэрүү, алтангануур, лидэр зэрэг эмийн ургамлуудыг үзэж болох юм. Их Богд уулын оргилд зуны дунд сард цас будран орж байхад уулын дунд хэсэгт бороо орж, бэл хоолойд нь 20-30 хэмийн халуун байдаг олон бичил уур амьсгалтай нутаг юм. |

| | | |
|----|-----------------|--|
| 10 | Луу яст | Баянхонгор аймагт хамгийн ойр орших эртний далайн амьтан ургамлын үлдэгдэл болон аварга биет үлэг гүрвэлийн чулуужсан яс олддог газар юм. |
| 11 | Үүдийн шавар | Баянхонгор хотоос Баруун хойд зүгт 40 орчим км-т байрлах Үүдийн шавар нь Баянхонгор аймгийн шавар эмчилгээний хамгийн том орд газар юм. |
| 12 | Хачин ламын сүм | Баянхонгор хотоос зүүн хойд зүгт 28 км, Шатар чулуунаас 15 км, Шаргалжуутаас 45 орчим км-т Эрдэнэцогт сумын төвд байрладаг. Сүм нь хоёр давхар, урд талын хаалгаар нь ордог. Сүмийн ханануудад үлгэр, домгийн сэдэвтэй төвд зураачдын өнгө ялган зурсан зурагнууд голлох бөгөөд нэг монгол зураачийн энэ хэлбэрээр зурсан “Дугар Зайсан” гэдэг зураг байдаг. |
| 13 | Хиргэс үүр | Баянхонгор аймгийн Богд сумын 3-р бригадын нутагт Их Богдын зүүн этгээдэд Жаран хэмээх унтарсан галт уулын ар хормой дахь хиргэс үүр юм. Хоёр чулуун загасан хөшөө бүхий тэр хиргэсүүр хос загасны сүүл толгойг зөрүүлж босгосон ажээ. |
| 14 | Холбоолж нуур | Баянхонгор хотоос зүүн өмнө зүгт 100 км зайд орших Холбоолжийн ягаан давс хэмээн алдарсан Холбоолж нуур нь хүнсний давсны томоохон орд газрын нэг бөгөөд эрт дээр үеэс хүмүүс давсанд орж, шавар эмчилгээ хийдэг ард эмчилгээний томоохон түшиц газрын нэг юм. |
| 15 | Цагаан агуй | Баянхонгор аймгийн нутаг Бага Богд уулын өмнөд хэсэгт Баянлиг сумаас зүүн хойд зүгт байдаг. Уг агуй цул шохойн чулуун уулын бэлд, тухайн уулыг хөндлөн отголсон гүн хавцалд оршино. Агуйн нийт урт 44.1 метр, 4.5 метр дундаж өндөртэй, 4.4 метр дундаж өргөнтэй. |
| 16 | Цагаан булаг | “Цагаан булаг”-ын хадны дүрс зургууд нь хүүхдийн сэдвээс бүрдсэн зургуудын цогцолбор дурсгал мөн. Энд хүүхэд гулгасаар байгаад хадыг хонхойлгон мөлгөр гадаргуутай болгосон болов уу гэмээр гулсуур хад, 3-4 настай хүүхэд хадыг хонхойлгон /хэв гарган/ гишгээд явсан гутлын мөр, хадан дээр хэв гарган бүтээсэн хэвтэж байгаа хүүхдийн дүрс зэрэг олон зургууд байдаг. |
| 17 | Чандмана овоо | Хүрэн бэлчирийн Чандмана овоо нь эрт дээр үеэс дахиж шүтэж ирсэн орон нутгийн тахилгатай уул юм. |
| 18 | Шаргалжуут | Шаргалжуутын халуун рашаан нь далайн түвшнээс дээш 1990 метр өндөрт Шаргалжуут голын дэргэд байрладаг. Энэ гайхамшигт рашаан нь 108 төрлийг өвчнийг анагаах чадвартай, 108 төрлийн халуун, хүйтэн рашаануудаас бүрддэг. Шаргалжуутын халуун рашаан нь байгалийн өвөрмөц сонин тогтоц, анагаах эмчлэх чадвараараа дэлхийд хосгүй рашааны нэгэнд тооцогддог. |
| 19 | Шатар чулуу | Баянхонгор хотоос зүүн хойд чиглэлд 15 км-т Эрдэнэцогт сумын нутагт байдаг “Шатар чулуу”-ны хөшөө дурсгал нь манай эриний өмнөх 3000 жилийн тэртээх эртний хүмүүсийн оюуны соёлын гайхамшигт өв юм. Шатар чулууны хөшөө дурсгалын цогцолбор нь буган чулуун хөшөө, гадуураа дөрвөлжин хүрээтэй хиргисүүрүүд, янз бүрийн амьтны дүрс хэлбэртэй чулуун сийлбэрүүд, сүг зурагтай дөрвөлжин чулуун хашлага зэргээс бүрдэнэ. |
| 20 | Ээж хад | 1862 оны Хар барс жил Галдан бошгот Түй, Шаргалжуутын голыг уруудан буцаж явахдаа их цэрэгтэйгээ буудаллан хоноглох шөнө ээжийгээ зүүдэлжээ. Галдан бошгот энэ газар 3000 түмэн цэргээр хүрээлүүлэн Хараа ихт хар туг залан Төр тогтохын бэлэг буйзаа гэж бэлэгдээд 8 шилдэг харваачаар сонгон харвуулахад харвасан сум нь цөм нэг тусгалд тусч байсан гэнэ. Тэгээд тэр газрыг хүндэтгэн эмэгтэй хүний төрх хэлбэрийн хөшөө босгосон ажээ. Үүнээс хойш нутгийн ардууд энэ хөшөөг “Ээж” хэмээн хүндэтгэж шүтэн биширч ирсэн домогтой. |

Хавсралт 2. Баянхонгор аймгийн төвийн зочид буудлууд

| № | Зочид буудлын оноосон нэр | Байгуулагдсан он | Хаяг | | Хүчин чадал | | Дундаж үнэ | Ажилчдын тоо | Нэмэлт үйлчилгээ |
|---|---------------------------|------------------|---|---------------------------------------|--|----------|----------------|--------------|------------------------------------|
| | | | Байршил | Утас | Өрөөний тоо /саун, халуун ус газрын хүчин чадал/ | Орны тоо | | | |
| 1 | "Уран дөш" зочид буудал | 2004 | Баянхонгор сум 4-1-1 а | 99447311, 99444365 70443627 | 6 өрөө , нийтийн халуун устай | 10 | 12.000-30.000 | 5 | Авто зогсоол, граж, хоолны газар |
| 2 | " Нэгдэлчин" зочид буудал | 2005 | Баянхонгор сум 1-р баг | 70442278 99442266 99036800 | 30 бүх өрөө халуун устай /нийтийн халуун устай/ | 90 | 8, 000-50.000 | 22 | Хурлын заалтай, авто зогсоол, граж |
| 3 | " Хонгор" зочид буудал | 2002 | Баянхонгор сум 1-р баг Титэм дэлгүүр урд талд 2 давхар байшин | 99447738 88447808 70443300 | 4 өрөөтэй бүх өрөө халуун устай | 11 | 20,000-35.000 | 13 | Зоогийн газартай, авто зогсоол, |
| 4 | "Жаргалант" зочид буудал | 2010 | Баянхонгор сум 1-р баг Жаргалант төв | 98302196 99442898 | 11 өрөө бүх өрөө халуун устай, саунтай | 18 | 10, 000-40.000 | 5 | Зоогийн газар, саун, массаж |
| 5 | "Энх-Номун" зочид буудал | 2002 | Баянхонгор сум 3-р хороо | 99042113 70442255 | 18 бүх өрөө халуун устай | 35 | 10,000-45,000 | 8 | Зоогийн газар |
| 6 | "Сөүл" зочид буудал | 2003 | Баянхонгор сум 1-р баг Ахуй үйлчилгээний хажууд | 99445656 70442754 | 5 бүх өрөө халуун устай | 8 | 25,000-55.000 | 11 | Караоке, Vip room, граж, |
| 7 | "Тэргэл" зочид буудал | 2010 | Баянхонгор сум 1-р баг | 99045335 | бүх өрөө халуун устай | 20 | 15000-40000 | 7 | ресторан, авто зогсоол |
| 8 | "Баянхонгор" зочид буудал | 2010 | Баянхонгор сум 1-р баг | 91992320, 9985246, 96021441, 96071441 | бүх өрөө халуун устай | 36 | 35000-58000 | 18 | Караоке, Vip room, граж, |
| 9 | "New stars" зочид буудал | 2010 | Баянхонгор сум 9-р баг | 99447177, 70444471 | бүх өрөө халуун устай | 24 | 30000-40000 | 16 | Караоке, Vip room, |

| | | | | | | | | | |
|----|-----------|------|------------------------|--------------------|-----------------------------------|-----|-------------|-----|------------------------|
| 10 | Баянбулаг | 2012 | Баянхонгор сум 1-р баг | 99449593, 50442055 | 16 өрөөтэй, бүх өрөө халуун устай | 32 | 35000-55000 | 11 | ресторан, авто зогсоол |
| | Нийт | | | | | 284 | | 116 | |

Хавсралт 3. Жуулчны бааз, амралтын газрууд

| Д/д | Байгуул-лагын нэр | Баазын нэр | Байгуулагдсан он | Захирал | Байршил | Үйл ажиллагааны чиглэл | Ажилчдын тоо | Хүчин чадал | Дундаж үнэ | Нэмэлт үйлчилгээ | Өрөөний үнэ |
|-----|--------------------------------------|----------------------------|------------------|------------------|--------------------------------------|---------------------------------|--------------|-------------|-----------------------------------|---|--|
| 1 | "Монгол хан" | "Говийн тэмээ" | 2006 он | Ж.Өлзийбодьжав | Баянговь сумын Байшинт хийдийн туурь | Жуулчны бааз | 4 | 50-60 | Хоол 1800-2200 | Билiard, дарц, гар бөмбөг | |
| 2 | "Есөн эрдэнэ" ХХК | "Мандухай" | 2008 | Д.Ирина | Баянхонгор аймаг Баянхонгор сум | Жуулчны бааз | 4 | 40-50 | | | |
| 3 | "Шаргал-жуут рашаан сувилалын газар" | Шаргал-жуут рашаан сувилал | 1946 | Д.Түмэн-дэмбэрэл | | Амралт рашаан сувилал / халуун | 15-90 | 120 | Хоол, байр, эмчилгээ | караоке, бүжиг, эмчилгээ, бариа засал | зуны байр-28500, энгийн өрөө 33500, хагас люкс-45500, Бүтэн люкс-55500 |
| 4 | "Өхэг" | "Өхэг" рашаан сувилал | 2009 | Цэцэгмаа | Галуут сумын Өхэг халуун рашаан | Амралт рашаан сувилал/халуун/ | 4 | 50 | Хонгогийн хоолтой, ортойгоо-18000 | Билiard, караоке | Хоол байр -15000-18000 |
| 5 | | Баян-Ундрага зэндмэнэ | 2013 | Г.Норжин | Эрдэнэцогт сум Бага Шаргалжуут | Амралт, рашаан сувилал халуун / | 8 | 50-60 | Хоол, байр, эмчилгээ | Теннис, Волейбол, Сагсан бөмбөг, Дэлүүр | 25000-30000 |

Хавсралт 4. Аймгийн төвийн томоохон зоогийн газрууд

| № | Үйлчилгээний нэр | Захирал | Холбоо барих утас | Хүчин чадал | Нэмэлт |
|----|------------------------|------------|--------------------|-------------|-----------|
| 1 | "Номин" зоогийн газар | Н.Энхээ | 99448174 | 50-60 хүн | |
| 2 | "Маммон" зоогийн газар | Г.Хүрэлсүх | 96057054 | 80-120 хүн | |
| 3 | "Хишиг" зоогийн газар | Энхчимэг | 88489848 | 40-50 хүн | |
| 4 | Кореа ресторан | Гал-Эрдэнэ | 99105089 | 50-60 хүн | |
| 5 | Соёмбо ресторан | Цэрмаа | 93076096 | 70-80 хүн | Буудалтай |
| 6 | Уранхайрхан ресторан | И.Цэнд | 99448999, 99447271 | 100-150 хүн | |
| 7 | "Санчир" ресторан | Бат-Орших | 88446606 | 60-90 хүн | |
| 8 | "Оргил" ресторан | Батзаяа | 88205599 | 70-90 хүн | |
| 9 | "Ундрам" зоогийн газар | Баярдалай | 91270330 | 30-40 хүн | |
| 10 | Ажнай pub | Аздэлгэр | 98132597 | 30-50 хүн | |

Хавсралт 5. Аймгийн музейнүүд

| № | Байгууллагын нэр | Байгуулагдсан он | Захирал | Байршил | Үнэ | Утас | Өмч |
|---|--------------------------|------------------|------------|--|--|--------------------|--------|
| 1 | Түүх угсаатны зүй музей | 1949 | Д.Маахүү | Баянхонгор аймаг, Баянхонгор сум 1-р баг | Хүүхэд -300, Том хүн-2000, Оюутан-1000 | 70443449, 70442393 | Төрийн |
| 2 | Байгалийн музей | 1980 | Д.Маахүү | Баянхонгор аймаг, Баянхонгор сум 1-р баг | Хүүхэд -300, Том хүн-2000, Оюутан-1000 | 70443449, 70442393 | Төрийн |
| 3 | Байгалийн, түүхийн музей | 1985 | Д.Дашчирэв | Баянхонгор аймаг, Шинэжинст сумын Ус цаг уурын өртөө | | 88601444 | Хувийн |

Хавсралт 6. Баянхонгор аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын тур оператор компаниуд

| № | Аялал жуулчлалын компани | Хаяг | Харилцах утас | Судалгаа өгсөн ажилтан |
|----|-------------------------------|---|---------------|------------------------|
| 1 | Active Adventure tours | СБД 11 хороолол MACRO center 4 давхарт | 354662 | Д. Алтанбагана |
| 2 | Ar Mongoltravel | СБД Чойжин ламын сум музейн ард | 325152 | Батзориг |
| 3 | Banzai Discover | ЧД бага тойруу Зоос гоёлын ард Дреам зочид буудлын байр | 312769 | Ариунжаргал |
| 4 | Black ibex Expedition | СБД Метро бизнес төвийн 11 давхарт | 70120011 | Оюунгэрэл |
| 5 | Borjin Travel | СБД Сүхбаатарын талбайн баруун тал МҮЭТЗ-ын байр | 99007173 | |
| 6 | Genco tour Bureau | СБД Баянгол зочид буудлын оффисе | 328960 | Б. Хашболд |
| 7 | Govi tours | СБД Төв шуудангийн эсрэг тал 61-р байр | 322339 | Батчулуун |
| 8 | Great Chingis tour Expedition | СБД Метромалл төвийн хажууд Hobby төв | 99197918 | Уранцэцэг |
| 9 | Жуулчин компани | СБД Амарын гудамж Таван богд Плазагийн байр | 328898 | Б. Номин |
| 10 | Халиун travel | СБД бага тойруу 6-р байр | 314889 | |
| 11 | МАТ | СБД 6-р хороо 2-40 | 320785 | Ж. Сарнай |
| 12 | Mongolia Altai tour | СБД Баянгол зочид буудлын хойно 1 байр | 323930 | Нармандах |

| | | | | |
|----|-----------------------------|---|----------|----------------|
| 13 | Mongol Khan Expedition | БЗД Офицерийн ордны зүүн хойно ЭМЯ ажилчдын байр | 99113348 | Өлзийбодьжав |
| 14 | New Juulchin Tour | СБД Чойжин ламын сүм музейн баруун талд | | Оюунчимэг |
| 15 | Nomadic Expedition Mongolia | ЧД Энхтайвны өргөн чөлөө Их дэлгүүрийн зүүн талд | 313396 | Б. Цэнгэлмаа |
| 16 | Nomadic Journeys | СБД Байгалийн түүхийн музейн зүүн талд | 99096512 | Н. Энхбаатар |
| 17 | Mongolia Expedition | СБД Чойжин ламын сүм музейн баруун талд | 329279 | Батбаяр |
| 18 | Tsolmon travel | СБД Төв шуудангийн урд 61-р байр | 99114910 | Б. Цолмон |
| 19 | Tseren tours | СБД Энхтайвны өргөн чөлөө Их дэлгүүрийн зүүн талд | 99164601 | Г. Ооёо |
| 20 | Explorer Mongolia | СБД Хуримын ордны зүүн хаалга | | Дөлгүн |
| 21 | Idres tour | БГД хуучнаар тээврийн товчооны баруун талд | | С. Цэцэгдэлгэр |
| 22 | Travel Buddies tour | БГД 10 хороолол Техник технологийн дээд сургууль | 94009950 | Э. Золжаргал |
| 23 | Shuren travel | СБД Олимпийн гудамж Мика зочид буудлын хажууд | 310869 | Г. Нармандах |
| 24 | Selena Travel | БГД 10-р хороолол | 70183499 | Өнөрдэлгэр |
| 25 | White horse tour | СБД Автотээврийн газар | 330778 | Баярсайхан |

Монголд аялал жуулчлалын салбарт хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас судалгаа авсан болно.

Хавсралт 7. Баянхонгор аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай тур операторуудын дунд явуулсан судалгааны ерөнхий дүгнэлт

Танай байгууллага Баянхонгор аймгаар ямар нэгэн аялал зохион байгуулдаг уу ?

Нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын 28% нь тус аймгийн нутгаар дайран өнгөрөх аяллыг зохион байгуулдаг гэж хариулсан бол үлдсэн 72 % огт зохион байгуулдаггүй гэсэн байна.

Аялал зохион байгуулдаггүй нь шалтгаан:

- 1-рт Дэд бүтцийн хөгжил сул
- 2-рт Жуулчдад үзүүлэх үзмэрийн талаархи мэдээлэл бага / танигдаагүй /
- 3-рт Үйлчилгээний байгууллага байдаггүй
- 4-рт Үйлчилгээний чанар муу
- 5-рт Хамтран ажиллах байгууллага байхгүй

Баянхонгор аймгийн гол үзмэр, гайхарудын ач холбогдол үнэлнэ үү.

Гадаадын жуулчдын хувьд:

- 1-рт Их богд уул
- 2-рт Орог нуур
- 3-рт Цагаан агуй
- 4-рт Бичигт хэдыг гадаадын жуулчдад үзүүлэхэд илүү тохиромжтой хэмээн ач холбогдлыг нь өндрөөр үнэлсэн байна.

Дотоодын аялагч жуулчдын хувьд Шаргалжуутын рашаан нь илүү ач холбогдолтой хэмээн хариулсан байна.

Баянхонгор аймгийн хувьд жуулчдад хамгийн их таалагддаг дурсамж юу вэ ?

Жуулчдын хувьд Баянхонгор аймаг нь байгалийн онгон төрхөө хадгалсан байдал хэмээн хариулсан байна. Ялангуяа Их богд Уулын орчмын байгалийн тогтоц, Бичигт хэдын дурсгалыг онцолсон байна.

Баянхонгор аймгаар аялахад таньд болон танай жуулчдад хамгийн муу дурсамж юу вэ ?

Голлох үзмэрийн орчмын хог хаягдал их
Дэд бүтцийн хөгжил муу
Үйлчилгээний байгууллага байхгүй чанар муу

Баянхонгор аймагт хөгжсөн аяллын төрлүүдийг нэрлэнэ үү ?

Байгалийн болон адал явдалт аяллыг сайн хөгжсөн хэмээн хариулсан бол ирээдүйд дээрх төрлийн аяллыг илүү хөгжих боломжтой хэмээн хариулсан байна.

Мөн эрүүл мэнд эмчилгээ сувиллын аялал хөгжих бүрэн боломжтой гэж хариулсан байна.

Аялал жуулчлалын зах зээл

Тус аймгийн нутгаар аялагчдыг бүс нутгаар нь авч үзвэл баруун европын улсууд ялангуяа Франц, Герман, Голланд зэрэг улсаас илүү ирдэг бол Америк, Австрали, Японы жуулчид бага хувийг эзэлдэг байна.

Жуулчдыг насны байдлаар нь авч үзвэл 50-аас дээш насны жуулчид зонхилох хувийг эзэлдэг байна.

Орон нутгаас авдаг төлбөртэй үйлчилгээ

Тус аймгийн нутгаар аялал зохион байгуулдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд:
Шатахуун
Мах хүнсний зүйл
Жуулчны бааз
Орон нутгийн музейн үйлчилгээг авдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Үйлчилгээний чанарын хувьд:

Шатахуун болон мах хүнсний бүтээгдэхүүний чанарын сайн хэмээн хариулсан бол Жуулчны бааз бусад үйлчилгээний чанарыг дунд болон муу хэмээн хариулсан байна.

Аялал жуулчлал хөгжлийн саад бэрхшээлүүд:

Хамтран ажиллах орон нутгийн байгууллага байхгүй
Дэд бүтэц муу
Нэгдсэн бодлого байхгүй / 2000 онд баталсан аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө огт хэрэгжээгүй /
Нэгдсэн маркетинг сурталчилгаа байхгүй
Үзмэрийг зорин очих замын тэмдэглэгээ байхгүй
Үйлчилгээний чанар муу

Саад бэрхшээлийг шийдвэрлэх санал

Өмнөговь аймагт жилд 40,000 жуулчид ирдэгийн 25,000 нь Хонгорын элсийг зорин очдог. Иймээс Хонгорын элсээс тус аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Бичигт хадны дурсгал нь 100 гаруйхан км байдаг тул уг дурсгалыг чиглэсэн албан ёсны маршрутыг бий болгох

Бөөн цагаан, Орог нуурын орчимд хавар, намрын улиралд шувуу ажиглах аяллыг бий болгох

Их богд уул Орог нуурыг түшиглэсэн байгалийн аяллын төлөвлөгөөг боловсруулах жуулчны үйлчилгээний байгууллагуудыг бий болгох

Батлагдсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас тодорхой хөрөнгө төсөвлөж нэгдсэн сурталчилгааг

тогтмол зохион байгуулах

Баянлиг сум нь 13000 тэмээтэй тул тэмээн аяллыг байгалийн аялалтай хослуулан хөгжүүлэх

Говийн их дархан газрын орчим мазаалай ажиглах аяллыг зохион байгуулах уг ажилд байгаль орчныг хамгаалах сан болон ТББ татан оролцуулах

Шаргалжуутын рашаан сувилалын орчмыг нэгдсэн бодлоготойгоор дахин төлөвлөх, орчны бохирдол, байгалийг тогтоцыг алдагдуулж байгаа байдалтай хатуу хариуцлага тооцох

Үйлчилгээний байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар өрсөлдөөнийг бий болгох

Хавсралт 8. Аяллын хөтөлбөр №1 “БУУРАЛ ТҮҮХИЙН ЖИМЭЭР” /5 өдөр, 4 шөнө/

БАЯНХОНГОР



Бор балгас




Уу булан




Орог нуур



Бөөнцагаан нуур



Их Богд уул



Цагаан агуй

**ГОВИЙН ТЭМЭЭ ЖУУЛЧНЫ БААЗ
БАЯНЛИГ СУМ**



Цагаан булгийн дурсгал



Бичигт хад

Аяллын хөтөлбөр № 1

| Аяллын хоног | Маршрут чиглэл | Үзэмэр | Тайлбар |
|--------------|--|---|--|
| 1 дэхь өдөр | Аймгийн төв – Бор балгас, Уу булан | Бор балгас Уу булан | - 18-19 зууны үеийн манжийн цэргийн бэхлэлт хотын туурь - Түйн голын хөвөөн дэх байгалийн үзэсгэлэнт газар |
| 2 дахь өдөр | Уу булан – Орог нуур, Их богд уул, | Орог нуур Их богд уул Загын ой | - Их богд уулын хойд талд орших давст нуур - Говь-Алтайн нурууны ноён оргил БЦГ - Орог нуурын зүүн урд захаар орших заган ой |
| 3 дахь өдөр | Их богд – Цагаан агуй, Бичигт хад, Цагаан булгийн дурсгал, Говийн тэмээ жуулчны бааз | Цагаан агуй Бичигт хад Цагаан булгийн дурсгал | - 800000 жилийн өмнө эртний хүн амьдарч байсан агуй бууц суурин - Төв Азийн нутаг дахь хамгийн том хадны сүг зургийн дурсгал - Хадны сүг зургийн өвөрмөц дурсгал |
| 4 дэхь өдөр | Говийн тэмээ жуулчны бааз – Бөөнцагаан нуур | Бөөнцагаан нуур | - Баянхонгор аймгийн нутаг дахь хамгийн том давст нуур, хавар намрын улиралд нүүдлийн шувууд олноор цугладаг. |
| 5 дахь өдөр | Бөөнцагаан нуур – Аймгийн төв | | Аяллын сүүлчийн өдөр |

Тайлбар: Энхүү маршрут нь 6, 7, 8 сард албан байгууллага, хамт олноор аялахад тохиромжтой хэлбэрээр төлөвлөгдсөн болно.

Аяллын эхний өдрийн явалтыг харьцангуй ойрхоноор төлөвлөсөн бөгөөд энэ нь аялагчдыг аяллын горимд дасан зохицоход чиглэсэн болно.

Аяллын 2 дахь өдөр Их богд уулын арын үзэсгэлэнт амуудыг үзэх, Орог нуурын хөвөөнд амрах боломжийг олгохоор тооцсон болно.

Аяллын 3 дахь өдөр нь харьцангуй урт явалттай бөгөөд энэ нь аялагчдын хоноглох газрын ая тухыг харгалзан жуулчны баазад хоноглохоор төлөвлөсөн болно.

Аяллын 4 дэх өдөр Бөөнцагаан нуурын хөвөөнд бүтэн өдөр амрах, малчин айл өрхөөр зочлох хэлбэрээр зохион байгуулагдсан болно.

Аяллын 5 дахь өдөр Бөөнцагаан нуураас аймгийн төв рүү явснаар энэ удаагийн аялал өндөрлөх болно.

БАЯНХОНГОР




Орог нуур




Бөөнцагаан нуур



Чихэн агуй



Цагаан агуй



Бичигт хад



Ногоон цав



Бүгийн цав



Эхийн гол

Аяллын хөтөлбөр № 2

| Аяллын хоног | Маршрут чиглэл | Үзмэр | Тайлбар |
|--------------|---|--------------------------------------|--|
| 1 дахь өдөр | Аймгийн төв – Орог нуур, Их богд уул | Орог нуур Их богд уул Загын ой | - Их богд уулын хойд талд орших давст нуур - Говь-Алтайн нурууны ноён оргил БЦГ - Орог нуур зүүн урд захаар орших заган ой |
| 2 дахь өдөр | Их богд уул – Цагаан агуй, Бичигт хад, | Цагаан агуй Бичигт хад | - 800000 жилийн өмнө эртний хүн амьдарч байсан агуй бууц суурин - Төв Азийн нутаг дахь хамгийн том хадны сүг зургийн дурсгал |
| 3 дахь өдөр | Бичигт хад – Бүгийн цав, Ногоон цав | Бүгийн цав Ногоон цав | - Баянхонгор, Өмнөговь аймгийн заагт орших Говь гурван сайхны БЦГ - Говийн заган ой хэрмэн цав бүхий байгалийн үзэсгэлэнт газар |
| 4 дэхь өдөр | Ногоон цав – Эхийн гол | Эхийн гол | - Говийн Их Дархан газрын А бүсэд хамаарах байгалийн үзэсгэлэнт газар, баянбүрд |
| 5 дахь өдөр | Эхийн гол – Ногоон цав, Шинэжинст сум | Нүүдлийн соёл | Малчин айлын аж амьдралтай танилцах |
| 6 дахь өдөр | Шинэжинст сум – Чихэн агуй, Бөөнцагаан нуур | Чихэн агуй Бөөнцагаан нуур | - 150000 жилийн өмнө эртний хүн амьдарч байсан бууц чулуун зэвсгийн суурин - Баянхонгор аймгийн нутаг дахь хамгийн том давст нуур |
| 7 дахь өдөр | Бөөнцагаан нуур – Аймгийн төв | | Аяллын сүүлчийн өдөр |

Тайлбар: Энхүү маршрут нь 6, 7, 8 сард албан байгууллага, хамт олноор аялахад тохиромжтой хэлбэрээр төлөвлөгдсөн бөгөөд говийн үзэсгэлэнт байгальтай танилцахыг хүссэн хүмүүст зориулагдсан болно.

Аяллын эхний өдөр. Орог нуур, Их богд уулын арын үзэсгэлэнт амуудтай танилцаад нуурын хөвөөнд хоноглох

Аяллын 2 дахь өдөр. Орог нуураас хөдлөн Цагаан агуйг үзээд үдээс хойш Бичигт хадны дурсгалтай танилцан Их баян ууланд хоноглох.

Аяллын 3 дахь өдөр. Бүгийн цавийг үзэж тэндээ үдийн цай уугаад үдээс хойш Ногоон цав хүрч хоноглох

Аяллын 4 дэх өдөр. үдээс өмнө Ногоон цавыг үзээд үдээс хойш Эхийн гол хүрч хоноглох

Аяллын 5 дахь өдөр. Эхийн голоос Ногоон цаваар дайрч Шинэжинст сумын нутагт малчин айлын амьдарл ахуйтай танилцан тэндээ хоноглох

Аяллын 6 дахь өдөр. Малчин айлаас хөдлөн Чихэн агуйн дурсгалтай танилцаад тэндээсээ Бөөнцагаан нууранд хүрч хоноглох

Аяллын 7 дахь өдөр. Бөөнцагаан нуураас үдээс хойш хөдөлж оройн нь аймгийн төвд ирсэнээр аялал өндөрлөнө.

ГАЛУУТ СУМ



Өхэгийн рашаан



Галуутын хавцал



Хачин ламын сүм



Шатар чулууны дурсгал

| Аяллын хоног | Маршрут чиглэл | Үзмэр | Тайлбар |
|--------------|--|--|---|
| 1 дэхь өдөр | Аймгийн төв – Галуутын хавцал, Өхэгийн рашаан | Галуутын хавцал Өхэгийн рашаан | - Хадан хавцал дундуур урсах гол байгалийн өвөрмөц тогтоц бүхий газар - Байгалийн үзэсгэлэнт газар орших рашаан ус |
| 2 дахь өдөр | Өхэгийн рашаан – Хачин ламын сүм, Шатар чулууны дурсгал, аймгийн төв | Хачин ламын сүм Шатар чулууны дурсгал | - 1903 онд баригдсан монголын эртний уран барилгын дурсгал буддын шашны сүм - Хүрэл зэвсгийн үеийн буган хөшөө болон булш хиргисүүрийн дурсгал |

Тайлбар: ЕБС-ын ахлах ангийн сурагчид болон аймагт ажлаар ирсэн гадна дотны хүмүүс долоо хоногийн амралтын өдрүүдэд аялахаар төлөвлөсөн байгууллага хамт олонд зориулагдсан болно.

Хавсралт 11. Аяллын жишиг хөтөлбөр №4 “АЙМГИЙН ТӨВТЭЙ ТАНИЛЦАХ”

/хагас өдөр/

БАЯНХОНГОР



Бурхан толгой



Динозаврын парк



Аймгийн баганат талбай



Аюуш арслангийн хөшөө



Аймгийн түүхийн музей

Залуучуудын парк

Тайлбар: Аймгийн төв Баянхонгор хоттой танилцах аяллын үндсэн зорилго нь ЕБС-ын сурагчид болон аймгийн төвд анх ирж байгаа гадаад дотоодын аялагч жуулчдад зориулсан хэлбэрээр төлөвлөгдсөн болно .

Хавсралт 12. Замын тэмдэг, тэмдэглэгээний загвар



Хавсралт 13. Аяллын мэдээллийн самбарын загвар

Жишээ №1

- Цагаан агуйгаас түүний ойролцоох бусад түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрыг хүрэх замын чиглэл маршрутыг зааж өгсөн байх
- Дурсгалт газруудын хоорондын км зайг тэмдэглэсэн байх
- Тухайн зорих дурсгалын талаархи товч танилцуулга мэдээллийг оруулсан байх
- Англи Монгол бичиглэлтэй байх

Хавсралт 14. Танилцуулга мэдээллийн самбарын загвар

Жишээ №2

- Цагаан агуйн талаар хийсэн эрдэм шинжилгээ судлаагааны ажлын талаархи товч мэдээлэл
- Цагаан агуйн орчмоос олдсон түүхэн дурсгалын зураг тайлбар
- Цагаан агуйн түүхэн ач холбогдол
- Англи Монгол тайлбартай байх

Хавсралт 15. Анхааруулах мэдээллийн самбарын загвар

Жишээ №3

Баянхонгор аймгийн нутаг дахь дараах түүх соёлын үл хөдлөх дурсгалд дээрх мэдээллийн самбар болон зохион байгуулалтын арга хэмжээг авах шаардлагатай юм.

- Цагаан агуй
- Бичигт хад
- Шатар чулуу
- Чихэн агуй
- Уран уул

Хавсралт 16 Баянхонгор аймгийн Баянхонгор хотод барих зочид буудлын жишиг үнэлгээ, төсөв



Баянхонгор хотод баригдах зочид буудлын зориулалттай баригдах байгууламжийн хэмжээ /ойролцоогоор/ 12 x 20 хэмжээтэй 00 түвшнээс 13-15метр өндөр 5 давхар зочид буудал зоогийн газрын зориулалттай байгууламж байна. Уг байгууламжинд:

- 1-р давхарт Угтагчийн хэсэг, зоогийн газар, караоке, мини маркет зэрэг байрлана
- 2 давхарт Хурлын танхим, өндөр зэрэглэлийн ресторан, офисс гэх мэт
- 3-5 давхарт Зэрэглэл бүхий 25-30 өрөө бүхий зочид буудал байрлана.

Барилгын хийцийг тоосгон дүүргэгчтэй цутгамал төмөр бетон карказ, цутгамал төмөр бетон хучилттай хуйлмал дээвэр бүхий 5 давхар байгууламжаар тооцоолон нэгж хүчин чадлын төсвийн үнэлгээгээр үнэлж тооцоог доор үзүүлсэн хүснэгтэнд гаргасан болно.

| | Ажилбарын нэр | Хэмжих нэгж | Нийт хэмжээ | Нэгж хүчин чадлын төсвийн үнэлгээ /мян төг/ | Нийт үнэ / мян төг / | Тайлбар |
|-------|---------------|-------------|-------------|---|----------------------|---|
| Гадна | Байгууламж | м2 | 1,200.0 | 375.6 | 450,720.0 | Төмөр бетон карказтай, төмөр бетон хучилттай тоосгон дүүргэгч бүхий 5 давхар байгууламж |
| | Цэвэр ус | м | 300.0 | 502.0 | 150,600.0 | 150мм голчтой ган хоолой |
| | Бохир ус | м | 300.0 | 534.0 | 160,200.0 | 150мм голчтой ширэмэн хоолой |
| | Дулаан | м | 300.0 | 576.0 | 172,800.0 | 1800x1000 хэмжээтэй тоосгон тэвштэй 600мм голчтой хоолой |
| | Цахилгаан | м | 300.0 | 147.0 | 44,100.0 | 10кВ хүчин чадалтай агаарын шугам |
| | Нийт | | | | 978,420.0 | |

Зочид буудлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо

| | мян төг |
|---|-------------|
| Шууд зардал | 978,420.0 |
| Байгалийн зарим хүчин зүйлсийн нөлөөллийн итгэлцүүр | 1.18 |
| Тээврийн зардлын итгэлцүүр | 1.13 |
| Үнийн өсөлтийн итгэлцүүр | 1.05 |
| Нийт дүн | 1,369,856.5 |

Хавсралт 17 Гэр буудлын жишиг үнэлгээ



Гэр буудал нь цутгамал бетон шалтай, 00 душтэй орчин үеийн шийдэл бүхий гэр байна.

| | |
|---|-------------|
| Дан эсгий бүрээстэй 5 ханатай гэр | 1,300,000.0 |
| Давхар эсгий бүрээстэй 5 ханатай гэр | 1,730,000.0 |
| Сийлбэртэй давхар эсгий бүрээстэй 5 ханатай гэр | 5,200,000.0 |
| Сийлбэртэй давхар эсгийнцэр бүрээстэй 5 ханатай гэр | 5,000,000.0 |

Гэр буудлын хамгийн асуудалтай хэсэг нь 00, душ юм. Энэхүү асуудлыг шийдэх олон хувилбар байж болно. Үүнээс дараах хувилбаруудын үнийг судлаж санал болгож байна.

| | Бүтээгдэхүүний нэр | Үнэ мян.төг | Тайлбар |
|---|-------------------------|----------------|---|
| 1 | Агшин зуурын ус халаагч | 550,000.0 | 10-20 минутанд хүйтэн усыг халуун болгоно. |
| 2 | Био жорлон | 2,080,000.0 | Цэвэр бохир ус цахилгааны холболт хэрэглэхгүй -40 өөс +40 градуст ашиглах боломжтой ашиглалтын хугацаа 35 жилээс дээш |
| 3 | Халаалтын зуух | 1,306,000.0 | 9 KW – 36 KW-ын хүчин чадал бүхий цахилгаан халаалтын зуухаар 90 - 400м2 талбайг халаах боломжтой. Энэхүү зуухыг шалны халаагуурт холбож болох ба хэрэглээний халуун усны системд холбон ашиглаж болно. |

Хөрөнгө оруулалтыг татах арга зам

Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг шууд тодорхойлох боломжгүй бөгөөд тодорхой бүтээн байгуулалтын жишиг үнэлгээг объект тус бүрээр гаргасан болно.

Мастер төлөвлөгөөнд тусгагдсан бүтээн байгуулалтанд шаардагдах хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээс бүрдүүлэх:

Гадаадын хөрөнгө оруулалтын чуулган, уулзалтууд танилцуулах замаар

Орон нутгийн хөрөнгө оруулалтын чуулган, уулзалт арга хэмжээг зохион байгуулах замаар

Аймаг болон сумдын хөгжлийн сангаас

ЖДҮ-ыг дэмжих сангаас

Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжээс

Хөрөнгө оруулалтын хэмжээ болон зориулалтаас хамааруулан дээрх эх үүсвэрүүдийн аль зохистой хэлбэрийг сонгох нь зүйтэй.

Баянхонгор аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд орон нутгийн аялал жуулчлалын байгууллагаас ирсэн саналын дагуу дараах нэмэлт өөрчлөлт оруулсан болно

| № | Орон нутгийн санал | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Судалгааны аялал 500 биш 1500 км үргэлжилсэн | Зохих засварыг хийсэн. |
| 2 | Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагын талаар мэдээлэл оруулах | Дэлхийн аялал жуулчлалын өсөлт, чиг хандлагын талаар хуудас 11-д нэмэлт оруулсан. Ялангуяа дэлхийн аялал жуулчлалын гол зорин очих газрын эхний байруудад төв болон зүүн хойд Азийн орнууд орж байгааг онцолсон болно. |
| 3 | Зарим зорилт мэдээллүүд өмнөх мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудтай давхцаж байна | Өмнөх мастер төлөвлөгөөнд тусгагдсан боловч бүрэн хэрэгжээгүй зарим зорилтууд нь АЖ-ын хөгжилд чухал үүрэгтэй учир цаг хугацааны шаардлагад нийцүүлэн засварлан оруулсан болно. |
| 4 | Монгол улсын аялал жуулчлалын чиг хандлагын талаар мэдээлэл бага байна. | Хуудас 12 – 14 – д Монголыг зорин ирж буй жуулчдын аяллын зорилго, зорин очиж буй газруудын талаарх шаардлагатай мэдээллүүдийг нэмж оруулсан болно. |
| 5 | Зарим мэдээллийн үсгийн фонд танигдахгүй байна. | Зохих засваруудыг хийсэн. |
| 6 | Баянхонгор аймгийн аялал жуулчлалын онцлог бүтээгдэхүүн үзмэрийн газруудын жагсаалт дахь газруудыг нэмэх | Төлөвлөгөөнд тусгагдсанаас гадна аялал жуулчлалын онцлог бүтээгдэхүүн, үзмэр болж чадах газруудыг тур операторуудтай хамтран судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд энэ талаар төлөвлөгөөнд бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийн хэсэгт дурдсан болно. |
| 7 | Мастер төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүн үзмэрүүдийн зургийг өөрчлөх Өмнөх төлөвлөгөөнд байсан зурагтай давхцаж байна. | Тухайн үзмэрийн дүр төрх өөрчлөгдөөгүй байгаа нөхцөлд зургийг дахин ашиглахад асуудал байхгүй гэж үзсэн болно. |

| | | |
|----|---|--|
| 8 | Рашаан сувиллын талаарх мэдээлэл оруулах, мөн энэ талаар хийж хэрэгжүүлэх ажлыг тодорхой болгох | Рашаан сувиллыг түшиглэн АЖ-ыг хөгжүүлэх нь нэг гол арга зам гэдгийг АЖ-ын бүсчлэлийн хэсэгт зааж өгсөн бөгөөд рашаан, сувиллын даацыг тодорхойлсоны үндсэн дээр дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг төлөвлөгөөнд тусгасан. Түүнчлэн голлох рашаан сувиллаас бусад газруудын тухайд мэргэжлийн хяналтын байгууллага болон ЭМ-ийн салбарынхантай хамтран рашааны чанарын үнэлгээг хийсний дараа ашиглалтын асуудлыг хөндөх ёстойг төлөвлөгөөний 5.7 – д тусгасан болно. |
| 9 | Үг үсгийн зарим алдаа байна | Зохих засваруудыг хийсэн. |
| 10 | Зарим бүсүүдэд тусгай сонирхол, байгаль экологийн аяллын төрөл хөгжүүлэх талаар зурагт тусгаж оруулах | Байгаль, экологийн аялал жуулчлалын бүсийг тодорхойлж өгсөн бөгөөд шинэ бүтээгдэхүүн, аяллын замналын хувьд тур операторуудын саналыг үндэслэн шийдэх ёстой болохыг төлөвлөгөөний 5.7 – д тодорхой тусгасан. |
| 11 | Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт шаардагдах зардлын хэмжээ, эх үүсвэр, боломжын талаар тодорхой | Хөрөнгө оруулалтын хэмжээг тооцохдоо техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах шаардлагатай тул жишиг зардлуудын тооцоог зохих газарт нь оруулж өгсөн болно. |
| 12 | Шаргалжуутын асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ ? | Шаргалжуутын рашаан сувилалд нэн түрүүнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж өгсөн бөгөөд менежментийн асуудлыг хариуцаж буй байгууллага нь төлөвлөж хийх шаардлагатай гэж үзэж байна. |
| 13 | Мастер төлөвлөгөөнд аялал жуулчлалын цогцолборын асуудал төдийлөн сайн тусгагдаагүй байна. | Аялал жуулчлалын цогцолборыг барьж байгуулах нь маш их хэмжээний хөрөнгө зардал шаарддаг бөгөөд эдийн засгийн үр өгөөж нь удаан хугацааны дараа гардаг. Иймээс аймгийн төвд энэ төрлийн бүтээн байгуулалт хийх нь төдийлөн үр ашигтай арга зам биш учраас тодорхой саналыг оруулаагүй болно. |
| 14 | Дотоод гадаадын жуулчдыг татахын тулд нэн түрүүнд хийж хэрэгжүүлэх ажил | Х-52,53 дотоодын жуулчдыг татахын тулд нэн түрүүнд хийж хэрэгжүүлэх ажлыг жагсаан тайлбарын хамт орууллаа. |
| 15 | Бусад салбаруудтай хэрхэн хамтран ажиллах талаар | АЖ-ын харилцаанд оролцогч талууд болон бусад салбаруудтай хамтран ажиллах боломж, чиглэлийн талаар 5.7 – д дэлгэрэнгүй тусгасан бөгөөд нэмэлт тайлбаруудыг хийсэн болно. |
| 16 | Хөрөнгө оруулалтыг татах арга зам | Хөрөнгө оруулалтыг татах арга зам, санхүүжилтийн эх үүсвэрийн талаар хуудас 105 – д дурдсан болно. |
| 17 | Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнгийн талаар | Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт болон төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнгийн талаар 5.8 – д нэмэлт оруулсан болно. |



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 32

Номгон

Тайлангийн тухай

“Баянхонгор -Эрчим хүч” Цахилгаан түгээх ХХК-ний төлөөлөн удирдах зөвлөл, компанийн 2013 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК-ний 2013 оны ажлыг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Компанийн 2014 оны үйл ажиллагааг төлөвлөсөн хэмжээнд барьж, алдагдлыг багасган техник эдийн засгийн үндэслэлийг сайжруулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Т.Бат-Очир/, компанийн гүйцэтгэх захирал /М. Батбаяр / нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 33

Номгон

**Малчдын бүлэг ажиллуулах
журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Мал Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Баянхонгор аймгийн сумдын нутаг дэвсгэрт Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх “Малчдын бүлэг” ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Сум орон нутагтаа Малчдын бүлгийг ажиллуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, үйл ажиллагааны тайланг сонсох, тэдэнд санхүүгийн болон хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хагас бүтэн жилээр ажлыг дүгнэх ажлуудыг зохион байгуулж тайлан, мэдээг хагас жил тутам аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд үүрэг болгосугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, /Д.Юндэнбазар/, аймгийн Цагдаагийн газар /Цагдаагийн дэд хурандаа Б.Оюутболд/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 33 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ “МАЛЧДЫН БҮЛЭГ” АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд олон нийтийн үүсэл санаачилгыг дэмжих, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, малчдаас эргүүл, шалгалт зохион байгуулах тэдний хүлээх эрх үүрэг, шагнал урамшууллын асуудлыг шийдвэрлэхэд оршино.

1. Малчдын бүлэг нь 5-10 гишүүнтэй, бүлгийн ахлагчтай байна.
2. Малчдын бүлэг нь сум, багийн хэмжээнд нутаг дэвсгэр, айл саахалт, ах дүү, төрөл садангаараа хоршин байгуулагдаж болно.
3. Малчдын бүлэг нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа талаар улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор хуралдаж дүгнэн хурлын тэмдэглэлийг бүлгийн ахлагч нь аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлж дүгнүүлнэ.
4. Малчдын бүлэг байгуулах хүсэлтээ сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд гаргасны дагуу Цагдаагийн байгууллага судалж гишүүдийг элсүүлнэ.
5. Малчдын бүлэг нь журмын дагуу бүртгүүлж, гишүүд үнэмлэхтэй байж болно.
6. Малчдын бүлэг нь улирал тутам хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулж үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Малчдын бүлгийн гишүүд, ахлагчыг сонгон ажиллуулах

1. Бүлгийн гишүүнээр ажиллах санал хүсэлтээ өөрийн биеэр гаргасан 18 насанд хүрсэн тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг, ял шийтгэл эдэлж байгаагүй олон нийтийн дунд нэр хүндтэй Монгол улсын иргэнийг авч ажиллуулна.
2. Бүлгийн гишүүдэд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс үнэмлэх олгож баталгаажуулна.
3. Бүлгийн ахлагч нь энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.
4. Бүлгийн ахлагчийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл хариуцсан цагдаагийн ажилтан болон хэсгийн төлөөлөгчийн саналыг үндэслэн сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар томилж ажиллуулна.
5. Бүлгийн ахлагч нь орон нутагтаа байнга оршин суудаг, гишүүдийг тогтмол мэдээллээр хангаж, удирдан ажиллах чадвартай байна.

Гурав. Бүлгийн гишүүдийн хийж гүйцэтгэх ажлын чиглэл

1. Гишүүд нь мал хулгайлагдсан, алдагдсан, олдож ирсэн тухай иргэдийн мэдээллийг цаг алдалгүй бүлгийн ахлагчид болон цагдаагийн байгууллага, алба хаагчид мэдэгдэн хамтарч ажиллана.
2. Шаардлагатай тохиолдолд гэмт хэргийн ул мөрийг хамгаалах, хохирогч нарын нэр хаягийг авах, сэжигтэй этгээдийн талаарх холбогдох мэдээллийг олж нэн даруй мэдээлэх
3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар иргэд, малчдад сурталчилах
4. Мал бүхий иргэдийн эзэмшилд байгаа малын тамга, тэмдэг зүсмийг бүртгэлд оруулах ажилд идэвхитэй оролцох
5. Ажлын чиглэл, удирдамжаа батлуулан цагдаагийн алба хаагчдаас чиглэл авч ажиллах
6. Хэсэг бүлгээрээ нийлж малыг өдрийн хариулга, шөнийн манаатай болгох ажлыг зохион байгуулна.
7. Хариуцсан нутаг дэвсгэртээ өдөр, шөнийн эргүүлийг машинт болон морин эргүүл хэлбэрээр зохион байгуулна.
8. Олдож ирсэн малыг өөрсдийн сүргийн хамт маллаж эзэн нь тогтоогдсон тохиолдолд Цагдаагийн байгууллагын зөвшөөрлөөр хүлээлгэн өгч урамшуулал авна.
9. Мал хулгайлах гэмт хэргийн талаар мэдээлэл олох, мал хулгайлах гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээдүүдийн ирсэн, явсан хөдөлгөөн зэрэгт хяналт тавьж цагдаагийн байгууллагад мэдээлнэ.
10. Малаа хулгайд алдсан тохиолдолд түргэн шуурхай орон нутгийн удирдлага болон цагдаагийн байгууллага, алба хаагчид нэн даруй мэдэгдэж эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх ажлыг хамтран зохион байгуулна.
11. Тухайн хариуцсан нутагт отроор ирсэн мал, мал туувар, иргэдийн хөдөлгөөн, мал мах бэлтгэлийн талаарх мэдээллийг орон нутгийн удирдлага болон цагдаагийн алба хаагчид мэдээлэх, хөдөлгөөнд нь хяналт тавих
12. Тухайн бүлгийн гишүүд нь өөрсдийн бололцоонд тулгуурлан мөнгөн хуримтлал бий болгож захиран зарцуулах журам гаргаж мөрдөнө.

Дөрөв. Бүлгийн гишүүн, бүлгийн ахлагчийн эрх үүрэг

1. Бүлгийн ахлагч нь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, таслан зогсоох, хууль тогтоомжид заасан бусад арга хэмжээ авахуулах эрх эдэлнэ.
2. Бүлгийн гишүүн нь бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, нийгмийн хэв журам зөрчихгүй байх

орон нутагтаа гэмт хэрэгтэй тэмцэх зохион байгуулалтын арга хэмжээнд оролцох, гэмт хэргийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг хүлээх, гэмт халдлагаас эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндийг хамгаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага албан тушаалтнаас шаардах эрхтэй.

3. Бүлгийн ахлагч, гишүүд нь хууль тогтоомжийг иргэдэд тайлбарлан ойлгуулах, хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж байгаа ажилд туслалцаа үзүүлэх, хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, эргүүл зохион байгуулах, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг хууль эрхийн хүрээнд шийдвэрлэх, холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.
4. Гишүүдээс ирүүлсэн мэдээллийг нэн даруй Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

Тав. Бүлгийн ажлыг дүгнэх

1. Малчдын бүлэг нь ажлаа улирлаар төлөвлөн, гишүүд улиралд нэг удаа хуралдан ажлаа дүгнэх ба хагас бүтэн жилээр нэгтгэж дүгнэнэ.
2. Бүлгийн ажлыг дүгнэн сайн ажилласан гишүүд, ахлагч нарыг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангаас урамшуулах, шагнал олгуулах саналыг Цагдаагийн байгууллагаар дамжуулан аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд уламжилна.
3. Эргүүл шалгалт хийх, гэмт хэргийн талаар авагдсан мэдээлэл, алдагдсан болон олдож ирсэн малыг мэдээлэх, гэмт этгээдийн хөдөлгөөн, бүлэг бөөгнөрөл, сэжигтэй байдлын талаар холбогдох газар мэдээлэхдээ морь, унаа, гар утас, автомашин ашигласан тохиолдолд Цагдаагийн байгууллага, алба хаагчид аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд уламжлан гарсан зардлыг нөхөн олгуулна.
4. Гишүүдээс өгсөн мэдээлэл батлагдсан тохиолдолд холбогдох хууль журмын дагуу мэдээллийн төлбөр урамшууллыг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл олгоно.
5. Бүлгийн ажлыг тухайн сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл жилийн эцсээр дүгнэж сум тус бүр эхний 3 байрыг шалгаруулах ба аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь сумдаас шалгарсан бүлгийг аймгийн хэмжээнд өрсөлдүүлэн “Шилдэг бүлэг”-ийг шалгаруулж урамшуулал олгоно.

-----o0o-----



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.02.22

№ 36

Номгон

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж” дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс 2014 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөнд туссан ажлуудыг цаг хугацаанд нь боловсруулж бэлтгэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/ болон холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосуг ай.

Гурав. Төлөвлөгөөний биелэлтэнд байнга хяналт тавьж, явц үр дүнг Тэргүүлэгчдэд мэдээлж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 36 дугаар тогтоолын хавсралт

**АЙМГИЙН ИТХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС 2014 ОНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрхэм зорилго: Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөвшүүлэн аймаг орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлэн, ард иргэдийнхээ төлөөлөх эрхийг хангана.

| № | Төлөвлөгөөний үндсэн чиглэл | Боловсруулах бодлого, гарах шийдвэр, хийх ажлын үндсэн чиглэл | Шууд хариуцах эзэн | Хэрэгжүүлэх хугацаа | Гарах үр дүн |
|---|---|--|--|--|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлууд | 1. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай 2. Аймгийн 2014 оны төсөвт тодотгол хийх тухай 3. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах тухай 4. Концессийн зүйлийн жагсаалт батлах тухай | Д.Жаргалсайхан Д.Жаргалсайхан Б.Гантулга Б.Гантулга | 3-р сард 3-р сард 3-р сард 3 сард | Үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж үр дүнг тооцоноор Аймгийн төсөвт тодотгол хийж, хэрэгжүүлснээр Журмыг батлан хэрэгжүүлснээр Жагсаалтыг батласнаар |
| 2 | Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлууд | 1. Монголын бурханы шашны гурван зулын нэг, Хамба Номун хан Эрдэнэбандид хутагт, их зурхайч, Лувсанданзанжамцаны түмэн өлзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний наймдугаар дүр Данзанжамбалчойжишинэнд бат оршил өргөх, говийн бүсийн их хурд наадмын бэлтгэл ажлын тухай | Д.Ширмэн | 6-р сард | Ойн бэлтгэл ажлын явц, үр дүнг тооцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөснөөр |

| | | | |
|---|--------------------------------------|------------------------|---|
| <p>4. Аймаг дахь Аудитын байгууллагуудтай хамтарсан болон захиалгат шалгалт хийлгэх санал хүргүүлэх тухай</p> | <p>Д. Ширмэн</p> | <p>3-р сард</p> | <p>Хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулснаар</p> |
| <p>5. МУЗН-ийн салбар зөвлөлийн Тэргүүлэгчдийг шинэчлэн батлах, ажлын тайланг хэлэлцэх</p> | <p>Д. Ширмэн Д. Батдамба</p> | <p>4-р сард</p> | <p>Тайланг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор</p> |
| <p>6. Аймгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх</p> | <p>Д. Ширмэн Д. Юндэнбазар</p> | <p>Хагас жил тугам</p> | <p>Байгууллагуудын тайланг сонсож, үнэлэлт, зөвлөмж өгсөнөөр</p> |
| <p>7. Орхон аймагт зохион байгуулагдах “Ухаалаг төр рүү шилжих санаачлагын хүрээнд НӨУБ-ын үйл ажиллагааг сайжруулах нь” сэдэвт онол практикийн бага хуралд оролцох, түүнээс гарсан зөвлөмж шийдвэрийг хэрэгжүүлэх</p> | <p>Д. Ширмэн Д. Юндэнбазар</p> | <p>2-р сард</p> | <p>Онол практикийн бага хуралд оролцож, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсноор</p> |
| <p>8. Аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэлэлцэн батлах</p> | <p>Б. Гантулга С. Батсүрэн</p> | <p>3-р сард</p> | <p>Төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг хангаж ажилласнаар</p> |
| <p>9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих Иргэний зөвлөлийг байгуулах</p> | <p>С. Баярмаа Ц. Мөнхзул</p> | <p>3-р сард</p> | <p>Зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлснээр</p> |
| <p>10. Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа орон нутгийн өмчийн барилгуудын ашиглалтыг сайжруулах, үргүй зардлыг багасгах, засаж тохижуулах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгуудыг актлах, зайлшгүй шаардлагаар шинээр барих барилгуудын талаарх нэгдсэн судалгаа тооллого хийх ажлын хэсгийг байгуулан ажилуулж цаашид авах арга хэмжээг тодорхойлох тухай</p> | <p>Д. Юндэнбазар Л. Доржханд</p> | <p>3-р сард</p> | <p>Ажлын хэсгийн санал дүгнэлтийг хуралдаанаар оруулж эцсийн шийдвэр гаргуулснаар</p> |

| | | | | | |
|--|-----------------------------------|------------------|-----------------------------------|------------------|---|
| | | | | | Саналын хуудсыг зааврын дагуу архивт шилжүүлснээр |
| | | | | | Журмыг боловсруулан батлуулж мөрдсөнөөр |
| | | | | | Сонгуулийн товиг гаргаж, зохион байгуулснаар |
| | | | | | Хороог байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлснээр |
| | | | | | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |
| | | | | | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |
| | | | | | Цэргийн дүйцүүлэх алба хаах нэрсийн жагсаалтыг батлан, хийх ажлыг тодорхой болгосноор |
| | | | | | Өөрчлөлтийг оруулан батлан мөрдөж эхэлснээр |
| | | | | | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |
| 11. Хурлын архив дахь сонгуулийн саналын хуудсыг аймгийн архивт шилжүүлэх | Ц.Мөнхжаргал Ц.Байгальмаа | Хагас жилд | Ц.Мөнхжаргал Ц.Байгальмаа | Хагас жилд | Саналын хуудсыг зааврын дагуу архивт шилжүүлснээр |
| 12. Сумдын ИТХ-ын ажлыг дүгнэх журам батлах | Д.Юндэнбаазар Ажлын алба | 1-р улиралд | Д.Юндэнбаазар Ажлын алба | 1-р улиралд | Журмыг боловсруулан батлуулж мөрдсөнөөр |
| 13. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг Баянбулаг сумд зарлаж, зохион байгуулах | Д.Юндэнбаазар Сонгуулийн хороо | 3-4 сард | Д.Юндэнбаазар Сонгуулийн хороо | 3-4 сард | Сонгуулийн товиг гаргаж, зохион байгуулснаар |
| 14. Сумын нөхөн сонгуулийн салбар хороог байгуулах | Д.Юндэнбаазар | 3-р сард | Д.Юндэнбаазар | 3-р сард | Хороог байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлснээр |
| 15. “Чандмань-Баянхонгор” ХК-ний ТУЗ-ийн тайланг хэлэлцэх | ТУЗ-ийн дарга Ж.Дулмаа | 2 –р сард | ТУЗ-ийн дарга Ж.Дулмаа | 2 –р сард | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |
| 16. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТОНӨ ХХК-ний ТУЗ-ийн тайланг хэлэлцэх | ТУЗ-ын дарга Т.Бат-Очир | 3-р сард | ТУЗ-ын дарга Т.Бат-Очир | 3-р сард | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |
| 17. Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн нэрийн жагсаалтыг батлах | Д.Жаргалсайхан /АЦШТаб/ | 4-р сард | Д.Жаргалсайхан /АЦШТаб/ | 4-р сард | Цэргийн дүйцүүлэх алба хаах нэрсийн жагсаалтыг батлан, хийх ажлыг тодорхой болгосноор |
| 18. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны журманд өөрчлөлт оруулах тухай | Д.Юндэнбаазар Ц.Байгальмаа | 3 –р сард | Д.Юндэнбаазар Ц.Байгальмаа | 3 –р сард | Өөрчлөлтийг оруулан батлан мөрдөж эхэлснээр |
| 19. Хилийн анги, застваар явж ажилласан ажлын тайлан, “Дархан хилийн төлөө хамтдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцүүлэх | Д.Жаргалсайхан /АЦШТаб/ | Эхний хагас жилд | Д.Жаргалсайхан /АЦШТаб/ | Эхний хагас жилд | Үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлсноор |

| | | | | |
|---|---|---------------------------------|---------------|---|
| | 20. Аймгийн 2015 оны төсвийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, түүнээс боловсруулсан төсвийн төслийг хэлэлцэн, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй болгох | Д. Ширмэн Д.Жаргалсайхан | 6-р сард | 2015 оны төсвийн төслийг хэлэлцэж, Сангийн яаманд өргөн барьснаар |
| | 1. Бодлогын хороодын ажиллах журманд өөрчлөлт оруулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Ажлын алба | Хагас жилд | Асуудал хэлэлцүүлж, Үйл ажиллагааг зохион байгуулснаар |
| НӨУБ-ын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж ажиллах талаар зохион байгуулах ажлууд | 2. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг зохион байгуулах | Д.Юндэнбаазар Д.Жаргалсайхан | 1-р сарын 13 | Үйл ажиллагааг олныг хамруулан тусгай хөтөлбөрөөр амжилттай зохион байгуулснаар |
| 4 | 3. ИТХ-ын төлөөлөгчдөд ахисан шатны сургалт зохион байгуулах | Д.Юндэнбаазар С.Гэрэлмаа | 2-3-р улиралд | Чадавхжуулах сургалт зохион байгуулснаар |
| | 4. Сумдын ИТХ, Засаг дарга нарт сургалт зохион байгуулах | Д.Юндэнбаазар О.Тойвгоо | 2-р улиралд | Чадавхжуулах сургалт зохион байгуулснаар |
| | 5. Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулах | Д.Юндэнбаазар С.Гэрэлмаа | 3-р улиралд | Чадавхжуулах сургалт зохион байгуулснаар |
| | 6. "Сургуулийн цагдаа" эргүүлийн журам батлах | С.Баярмаа Ц.Мөнхзул | 2-р улиралд | Журам боловсруулж, батлуулан мөрдөж эхэлснээр |
| | 7. ГХУСАЗ33-ийн жилийн ажлын төлөвлөгөө батлах | Д.Юндэнбаазар Ц.Мөнхзул | 2-р сард | Төлөвлөгөөг гаргаж, ГХУСАЗ33-ийн хурлаар батлуулснаар |

| | | | | |
|---|-------------------------|-----------------------------------|--|--|
| <p>Тусгай удирдамж боловсруулан Төлөөлөгчид, ТАА-ны ажилтнуудыг сум, багуудын ИНХ-д оролцуулж, иргэд олон нийтэд хууль тогтоомж болон нутгийн удирдлагын байгууллагуудаас зохиож байгаа ажлын талаар сургалт, сурталчилгаа хийлгэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгүүлж, БИНХ-ын чадавхийг дээшлүүлснээр</p> | <p>Жилдээ</p> | <p>Төлөөлөгчид, Ажлын алба</p> | <p>8. “Төлөөлөгчийн нэг өдөр”-ийг сум, баг бүрт тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах, Төлөөлөгчдийг багийн ИНХ-дуудад оролцуулах</p> | |
| <p>Төлөөллийн байгууллагууд болон иргэд, сонгогчдын эргэх холбоо сайжирч, НӨУБ-ын шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийн санал тусгалаа олсноор</p> | <p>Улирал тугам</p> | <p>ИТХ-ын ТАА</p> | <p>9. НӨУБ-ын үйл ажиллагаанд үнэлэлт өгүүлэх болон Тэргүүлэгчид, хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар иргэдээс санал асуулга, судалгаа авах</p> | |
| <p>Тэргүүний ажиллагаатай хурлын байгууллагын туршлагаас суралцан, НӨУБ-ын чадавхийг дээшлүүлэх талаар зөвлөгөө авч ажил хэрэг болгосноор</p> | <p>3 дугаар улиралд</p> | <p>Д.Ширмэн Д.Юндэнбаазар</p> | <p>10. Аймгийн ИТХын төлөөлөгчдийг оролцуулан, сумдын ИТХ-уудын бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулж, туршлага солилцох</p> | |

| | | | | |
|--|--|---|-----------------------------------|--|
| | <p>11. Хөрш аймгуудтай хамтран, НӨУБ-уудын туршлага солилцох уулзалтуудыг зохион байгуулах</p> <p>12. Чингис хааны мэлхий гийсэн өдөр, Улс тунхагласны ойг тэмдэглэх төлөвлөгөө гарган ажиллаж, "Монголооро гоёцгооё" хөдөлгөөн өрнүүлэх</p> | <p>Д.Ширмэн Д.Юндэнбаазар Ц.Байгальмаа</p> <p>О.Тойвгоо Д.Юндэнбаазар</p> | <p>10 сард</p> <p>4-р улиралд</p> | <p>ИТХ-ын ТАА-ны ажилтнууд, Төлөөлөгчдийг чадавхжуулснаар</p> <p>Иргэдэд үндэсний бахархлыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулснаар</p> <p>Тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хурлын байгууллагын үйл ажиллагааг сурталчилснаар</p> <p>Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийг website болон тогтоол шийдвэрийн хүргэлтээр цаг үеийн мэдээллээр хангаж ажиллах, товхимол хэвлэн хүргүүлснээр</p> <p>Цагаатгах ажлын салбар комиссын төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсоноор</p> |
| | <p>13. "Аймгийн ИТХ-ын нэг өдөр"-ийг зохион байгуулах</p> | <p>Д.Юндэнбаазар Тэргүүлэгчдийн ажлын алба</p> | <p>Жилдээ</p> | <p>Тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хурлын байгууллагын үйл ажиллагааг сурталчилснаар</p> <p>Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийг website болон тогтоол шийдвэрийн хүргэлтээр цаг үеийн мэдээллээр хангаж ажиллах, товхимол хэвлэн хүргүүлснээр</p> <p>Цагаатгах ажлын салбар комиссын төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсоноор</p> |
| | <p>14. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн үйл ажиллагаа, хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар Төлөөлөгчид, Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн удирдлагууд, сум, байгууллагуудад мэдээлэл хүргэх</p> | <p>Тэргүүлэгчдийн ажлын алба</p> | <p>Жилдээ</p> | <p>Тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хурлын байгууллагын үйл ажиллагааг сурталчилснаар</p> <p>Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийг website болон тогтоол шийдвэрийн хүргэлтээр цаг үеийн мэдээллээр хангаж ажиллах, товхимол хэвлэн хүргүүлснээр</p> <p>Цагаатгах ажлын салбар комиссын төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсоноор</p> |
| | <p>15. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх</p> | <p>Д.Юндэнбаазар</p> | <p>Жилдээ</p> | <p>Тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хурлын байгууллагын үйл ажиллагааг сурталчилснаар</p> <p>Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийг website болон тогтоол шийдвэрийн хүргэлтээр цаг үеийн мэдээллээр хангаж ажиллах, товхимол хэвлэн хүргүүлснээр</p> <p>Цагаатгах ажлын салбар комиссын төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсоноор</p> |

| | | | | |
|--|--------------------|---|---|---|
| <p>Аймгийн website болон ХМХ-ээр ИТХ-ын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл хүргэснээр</p> | <p>Жилдээ</p> | <p>Д. Юндэнбаазар Ц. Байгалмаа Ж. Тамиржаргал</p> | <p>1. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны талаар гарын авлага, танилцуулга бэлтгэж, тугээх, website-ыг шинэчилж, нэгдсэн сүлжээнд холбох</p> | <p>Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны дотоод зохион байгуулалтын хүрээнд хийх ажлын талаар</p> |
| <p>Самбар бэлэн болсноор</p> | <p>2-р улиралд</p> | <p>Ц. Мөнхзул Ц. Байгальмаа</p> | <p>2. Аймгийн ИТХ-ын самбарыг шинэчилэх, аймгийн Хүндэт иргэдийн самбар шинээр хийх</p> | |
| <p>Журам боловсруулж, батлуулан мөрдөж эхэлснээр</p> | <p>2-р улиралд</p> | <p>Д. Юндэнбаазар Ж. Тамиржаргал</p> | <p>3. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн ажлыг дүгнэх журам боловсруулж, ажил дүгнэх самбар хийх</p> | |
| <p>Ажиллах орчныг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангаснаар</p> | <p>Жилдээ</p> | <p>Д. Ширмэн Д. Юндэнбаазар</p> | <p>4. Ажлын албаны ажилтнуудын ажиллах орчныг сайжруулах, техник хэрэгслээр хангах ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх</p> | |
| <p>Уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж үр дүнг тооцсоноор</p> | <p>5-р сард</p> | <p>Д. Ширмэн</p> | <p>5. "Хангайн бүсийн аймгуудын хамтын ажиллагааны хүрээнд НӨУБ-ын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах боломж" уулзалтыг зохион байгуулах</p> | |

-----000-----



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.03.19

№ 37

Номгон

**Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх
ажлын жагсаалт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Авто замын сан төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3 дахь хэсгийн 8 дахь заалтыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Замын сангийн хөрөнгөөр 2014 онд гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах хөрөнгийн хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

**ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН
ЖАГСААЛТ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ**

| | |
|---|-------------|
| 1. Орон нутгийн хөгжлийн санд замын сангаас төвлүүлэх хөрөнгө | 20,000,000 |
| 2. Тээвэр, авто замын газарт ОНЗАтөлбөр хураамж бүрдүүлэх үйл ажиллагааны зардал | 6,000,000 |
| 3. Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын уулзваруудад гэрэл дохио тавих. | 233,062,263 |
| 4. Сургууль орчмын бүсийн зам тээврийн ослыг бууруулах, аюулгүй орчинг бүрдүүлэх тэмдэглэгээ хийх | 70,070,000 |
| 5. Авто замын тухай хуулийн 18.5 заалтын дагуу мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх зардал | 10,296,353 |
| 6. Нөөц | 135,083,384 |



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.03.19

№ 43

Номгон

**Эрүүл мэндийн зөвлөлийн бүрэлдэхүүн,
зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 7.2, 7.3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 425 дугаар тогтоолыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас тогтоох нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохицуулах чиг үүрэг бүхий “Эрүүл мэндийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эрүүл мэндийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, жил бүрийн зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга : - Аймгийн Засаг дарга;
Орлогч дарга: - Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга;
Гишүүд: - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
- Хууль зүйн хэлтсийн дарга;
- Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга;
- Цэргийн штабын дарга;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга;
- Байгаль орчны газрын дарга;
- Боловсролын газрын дарга;
- Хөдөлмөрийн хэлтсийн дарга;
- Тээвэр, авто замын газрын дарга;
- Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга;
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга;
- Баянхонгор сумын Засаг дарга;
- Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах нийгэмлэгийн
нарийн бичгийн дарга;
- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын
төлөөлөл.
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн эрүүл мэндийн асуудал
хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга:
- Эрүүл мэндийн газрын дарга;

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
43 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бусад хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөр, стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдийг удирдлага болгоно.

1.4. Зөвлөл нь аймгийн Засаг даргын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

Хоёр. Үндэсний зөвлөлийн ажиллах журам

2.1. Удирдлага, зохион байгуулалт

2.1.1. Зөвлөл нь аймгийн Засаг даргын дэргэд ажиллана.

2.1.2. Зөвлөлийн орлогч дарга нь аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн дарга, нарийн бичгийн дарга нь Эрүүл мэндийн газрын дарга байна.

2.1.3. Зөвлөл нь ажлын албатай байх бөгөөд ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

2.1.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох хэлтэс, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна. Зөвлөлөөр хэлэлцэх асуудалтай уялдуулан холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл хуралдаанд оролцоно.

2.1.5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал байна. Зөвлөл хэлэлцсэн асуудлаараа хурлын тэмдэглэлээр шийдвэр гаргах бөгөөд тэмдэглэлд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.1.6. Хурлын дэгийг Зөвлөлийн гишүүд батална. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн дарга ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

2.1.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.1.8. Зөвлөл нь эрүүл мэндийн асуудлаар бусад салбарын зайлшгүй оролцоо шаардлага бүхий бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, санал зөвлөмжийг хэлэлцэн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

2.1.9. Зөвлөл нь ЭМГ-ын түвшинд бусад салбарын оролцоог хангасан дэд зөвлөлтэй байна. Үүнд:

- Хүний нөөцийн дэд зөвлөл
- Нийгмийн эрүүл мэндийн дэд зөвлөл
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний дэд зөвлөл.

2.1.10. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Эрүүл мэндийн газрын дарга батална.

2.1.11. Дэд зөвлөл нь өөрийн холбогдох асуудлаараа санал, бодлогын баримт бичиг боловсруулж шийдвэрлүүлэх, мөн үйл ажиллагаагаа аймгийн зөвлөлд тайлагнана.

2.2. Зөвлөлийн дарга

2.2.1. Хуралдааны төлөвлөгөө, хэлэлцэх асуудал болон хуралдаанаас гарсан шийдвэрийг баталж, шаардлагатай зарим асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулж хэлэлцүүлнэ.

2.2.2. Зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж, хуралдааныг удирдана.

2.2.3. Зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавина.

2.2.4. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан санал зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж, бусад салбарын оролцоог хангуулна.

2.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга

2.3.1. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан зөвлөлийн даргаар батлуулна.

2.3.2. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын бэлтгэл ажлыг хангана.

2.3.3 Хуралдааны тэмдэглэл хөтөлж гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.4. Зөвлөлийн ажлын алба

2.4.1. Зөвлөлөөс гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, холбогдох байгууллагаас гаргуулан авч, мэдээлэл солилцоно.

2.4.2. Зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгтгэж, аймгийн зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

----oO----



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.03.17

№ 8/1

Номгон

**Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2013
оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай**

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай аймгийн Засаг дарга Д.Жаргалсайханы илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд төлөвлөсөн 188 ажлаас 120 заалт нь бүрэн биелэгдэж 32 заалт 90- ээс дээш хувь хэрэгжсэн, 10 заалт 70 хувь, 9 заалт нь 50 хувь, 11 асуудал 30 хүртэл хувь хэрэгжсэн буюу эхлэл төдий биелэгдсэн дүн гарч хэрэгжилтийн хувь 85,9 хувьтай байна.

Энэхүү эхлэл төдий хэрэгжсэн ажлууд нь орон нутгаас шууд хамааралтай биш улсын төсвийн хөрөнгө оруулалтаас шалтгаалсныг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а” дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Үндсэн чиглэлд тусгагдан дутуу хийгдсэн арга хэмжээнүүдийг дуусгаж цаашид хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг тухайн онд нь багтааж ашиглалтанд өгөх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.03.17

№ 8/2

Номгон

Төсөвт тодотгол хийх тухай

Төсвийн тухай хуулийн 64.1.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2013 оны орон нутгийн төсвийн давсан орлого 168 057,4 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын дансны хэмнэгдсэн үлдэгдэл 298244.8 мянган төгрөг, ноосны урамшууллын орлогын зөрүү 99 826,5 мянган төгрөг, нийт 566 128,7 мянган төгрөгийг дараах зардалд хуваарилан баталсугай.

- | | |
|--|------------------------|
| 1. Аймгийн танилцуулга ном | 28 000,0 мянган төгрөг |
| 2. Цахим архивт оруулах үйл ажиллагааны зардал | 20 000,0 мянган төгрөг |
| 3. Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн хуучин барилгын буулгалтын ажлын хөлсний зөрүү | 12 310,0 мянган төгрөг |
| 4. Гудамж хариуцсан сайн дурын ажилтнуудад олгох урамшууллын зөрүү | 31 248,0 мянган төгрөг |
| 5. Дотоод аудитын албаны үйл ажиллагааны зардал, цалин | 17 000,0 мянган төгрөг |
| 6. Соёл, спорт аялал жуулчлалын газрын 2 мэргэжилтний цалин, үйл ажиллагааны зардал | 7 617,8 мянган төгрөг |
| 7. Аймгийн ИТХ-аас хийсэн театрын өмнөх талбайн хашаа, хайсны засварын үнэ | 850,0 мянган төгрөг |
| 8. Авто машины засвар | 8 514,2 мянган төгрөг |

| | |
|--|-------------------------|
| 9. ЗДТГ-ын дотоод сүлжээний төв сервер, сүлжээний утас солих, ЗДТГ-ыг камержуулах, компьютер, принтер тоног төхөөрөмж авах | 9 985,8 мянган төгрөг |
| 10. Иргэний танхимын гэрэлт самбар хийлгэх зардал | 3 500,0 мянган төгрөг |
| 11. Жишиг аймаг 2014 ном хэвлүүлэхэд | 12 000,0 мянган төгрөг |
| 12. Татварын буцаан олголт | 323 352,9 мянган төгрөг |
| 13. Халамжийн сангийн цахим мэдээллийн судалгаа, архивлах | 52 000,0 мянган төгрөг |
| 14.Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зардал | 18 550,0 мянган төгрөг |
| 15.Өрхийн эмнэлгүүдийн эмч, сувилагчийн цалингийн зардал | 21 200.0 мянган төгрөг |

Хоёр. 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэмнэлт 55 226.6 мянган төгрөг, хог боловсруулах үйлдвэрийн 115 000.0 мянган төгрөг, Жижиг дунд үйлвэрлэлийн зээлийн эргэн төлөлт 98845.3 мянган төгрөг, Сумдаас төвлөрсөн өвс тэжээлийн үнэ 17777.7 мянган төгрөг нийт 286 849.6 мянган төгрөгийг тодотгон дараах байдлаар хуваарилсугай.

| | |
|--|-------------------------|
| 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас дутуу санхүүжигдсэн | 195 360,8 мянган төгрөг |
| 2. Хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийн зардал | 51 488,8 мянган төгрөг |
| 3. Эрүүл өрх аяны урьдчилан сэргийлэх үзлэг | 40 000,0 мянган төгрөг |

Гурав. Аймгийн 2014 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Төв суурин газрын ногоон байгууламжийг цэцэрлэгжүүлэх 100 000.0 мянган төгрөгийн ажлыг Хот тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт цэцэг, модны үрсэлгээ бэлтгэх, суулгах ажиллагааны зардалд 40 000.0 мянган төгрөг, ногоон байгууламжийг арчлах тоног төхөөрөмж, үйл ажилллагааны зардал 60 000.0 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсугай.

Дөрөв. Тээвэр авто замын газрын Орон нутгийн замын санд оруулах орлогын төлөвлөгөөг 60 000.0 мянган төгрөгөөр тогтоож аймгийн төсвийн нийт орлогыг 65 238 176.3 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Орон нутгийн зам ашиглалтын хураамжийн орлогыг төлөвлөгөөний дагуу оруулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан /-д үүрэг болгосугай.

Зургаа. Аймгийн 2014 оны замын санг орон нутгийн зам ашиглалтын хураамж 60 000,0 мянган төгрөг, 2013 оны давсан орлого 74 512,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 474 512.0 төгрөгөөр баталсугай.

Долоо. Аймгийн ахмадын хорооны нэр дээр 2014 онд батлагдсан төсвийн тогтмол зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг Аймгийн Ахмадын хороо, Монголын ахмадын чөлөөт холбооны Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлд тэнцүү хуваан санхүүжүүлсүгэй.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.03.17

№ 8/3

Номгон

**Концессын зүйлийн жагсаалт
батлах тухай**

Монгол Улсын Концессын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн концессын зүйлийн жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Концессын зүйлийн төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг хууль, журмын дагуу явуулж, үр дүнг аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнахыг Засаг дарга /Д..Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын ээлжит бүс VIII хуралдааны
8/3 дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН КОНЦЕСССЫН ЖАГСААЛТ

| № | Концессын зүйлийн нэр | Тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил | Үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, эсвэл шууд гэрээ байгуулах |
|---|---|---|-----------------|--|--|--|---|
| 1 | Аймгийн төвд хатуу хучилттай авто зам барих | Аймгийн төвд орон нутгийн чанартай 14.6 км хатуу хучилттай авто зам ашигтлагдаж байна. Үүнээс хот дотор 12.6 км гэр хорооллуудад 2.1 км зам байна. Гэр хорооллуудын дундуур авто зам тавих зорилгоор 1.7.2.3.6.5.4 -р багийн нутаг дэвсгэрийг хамруулан 10 км замын транссын сонгон зураг төсвийн хийллэсэн. 1.6.7-р багт барих авто замын төсөвт өртөг 2968.1 сая төгрөг, 3.2.4.3.6-р багт барих авто замын төсөвт өртөг 3090.0 сая төгрөг байна | Барих-шилжүүлэх | 10 км авто зам барина | Тээврийн хэрэгсэлэр ая тухтай зорчих нөхцөл бүрдэнэ | үгүй | Сонгон шалгаруулалт явуулах |
| 2 | Батийн хөгжлийн төв барих | Баянхонгор сумын 2.5 дугаар багт багийн төв барих шаардлагатай байна. Тус багууд нь 654-1130 өрх 3182-3782 хүн амтай. Багийн төв байхгүй. Багийн Засаг дарга нар 1-р багийн төвд конторлодог. Гэнд 2.5 дугаар багийн иргэд ирж үйлчлүүлэхэд дунджаар 2.5-3.0 км явж үйлчилгээ авдаг. Үүнээс хархад төрийн үйлчилгээг иргэд өдөр тутам авах боломжгүй алслагдсан байгаа тул баг тус бүрт нь иргэдэд ойр багийн төв барих шаардлагатай байна | Барих-шилжүүлэх | ТЗҮ, зураг төсөв боловсруулж багийн хөгжлийн төв барих | Иргэд төрийн үйлчилгээ үзүүлэх | үгүй | Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр сонгон шалгаруулалт явуулах |
| 3 | Баянхонгор сумын ногооно байгуулмжийн үзлалтийн системийг барих | Одоогоор усалгааны систем байхгүй. Иймд Гуравнбүс цогцолбор, ахмадын, гавшгайчдын цэцэрлэг, Гандангийн урдах цэцэрлэг, төв замын тусгаарлах зурвас, хажуугийн ногооно байгууламж, Нэгдсэн эмнэлгийн арын уулзвараас Есөн -Эрдэнэ зах хүртэлх замын ногооно байгууламж, Аюулгүйн тойргоос нэгдсэн эмнэлгийн арын уулзвар хүртэлх замын ногооно байгууламж, МХГ-ын урд талаас зүүн тийш чиглэлийн авто замын ногооно байгууламж, Байгалийн музейн хойд уулзвараас дөрвөн замын уулзвар хүртэлх замын ногооно байгууламжийг услах 14 км үзлалтийн системийг барина | Барих-шилжүүлэх | Усгалтын систем барих | Баянхонгор сумын цэцэрлэгт хүрээлэнгүүдийн ногооно байгууламжийг услах | үгүй | Сонгон шалгаруулалт явуулах |

.....000.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.03.17

№ 8/4

Номгон

Журам батлах тухай

Баянхонгор аймагт 2000-2003 оныг дамнасан ган, зудын аюул нүүрлэж 2.5 сая малтай байсан аймаг 0.7 сая малтай болон хорогдож, олон арван малчид маллах малгүй болж, амьжиргааны түвшин эрс доройтсоноос аргагүйн эрхэнд байгалийн баялаг болох алт хайж гар аргаар алт олборлох болсон. Мөн тухайн үед Монгол Улсын Засгийн газраас баталсан Алт үндэсний хөтөлбөр эрчимжиж эхэлснээр уул уурхайн салбар олборлолтод түлхүү анхаарч байгаль орчны нөхөн сэргээлтийг орхисноор ихээхэн хэмжээний газар эвдэгдэн холбогдох эзэнгүй болжээ.

Эдгээр газруудыг улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө гарган нөхөн сэргээх боломж хомс байгаагийн дээр хаягдал нөөцийг авалгүй нөхөн сэргээсэн тохиолдолд гар аргаар алт олборлогч иргэд тухайн газрыг дахин ухах асуудал гарч байна. Өнөөгийн байдлаар хаягдал нөөцийг ашиглах замаар нөхөн сэргээлт хийх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаатай холбоотойгоор аймгийн хэмжээнд эвдэрсэн газрууд нэмэгдэх хандлагатай байна.

2009 онд эвдэрсэн газрын тооллогоор 12 сумын 208 цэгт гар аргаар болон уул уурхайн нөлөөгөөр 708 га газар эвдэгдсэн байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтөд өртөж, эмзэг байгаа цөлийн болон цөлөрхөг хээрийн ургамлан бүрхэвч, малын бэлчээр, биологийн төрөл зүйлийг устгаж, мал амьтан унаж осолдох олон тооны нүх үлдээж байна.

Иймд эдгээр асуудлуудыг зохицуулах эрх зүйн баримт бичиг гаргах шаардлагатай байгааг тэмдэглэн Монгол улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Газрын хэвлийн тухай хуулийн 7.1.1, Байгаль Орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан Баянхонгор аймгийн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэн холбогдогч нь

тогтоогдох боломжгүй болж орхигдсон болон иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрч сүйтгэгдсэн талбайд нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, хяналт тавих журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайханд/-д даалгах нь:

Эвдэрсэн болон одоо ашиглаж байгаа талбайдаа нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн компаниудын байгаль орчинд учруулсан хохирлыг тооцож хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлсүгэй.

Журмыг хэрэгжүүлэх бодлого зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласугай.

Гурав. Цаашид орон нутагтаа аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй аж ахуй нэгж, иргэний ашигт малтмал эрж хайх, олборлох үйл ажиллагааг тухай бүр нь шуурхай ажиллан таслан зогсоож, буруутай этгээдээр учруулсан хохирлыг арилгуулж хяналт шалгалтыг өндөржүүлж ажиллахыг Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Дөрөв. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

Тав. Энэ журам батлагдсантай холбогдуулан 2012 оны 02 дугаар сарын 16-ны 16/1 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 18/5 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын ээлжит бус VIII хуралдааны
8/4 дүгээр тогтоолын хавсралт

ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд гар аргаар алт олборлогчид туршлагажиж, ашиглаж буй технологи нь сайжирч овор хэмжээ нь нэмэгдсээр газрыг их хэмжээгээр эвдэн сүйтгэж байгалийн унаган төрхийг эвдэн, ургамлан бүрхэвчийг сүйтгэж цөлжилт эрчимжих нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас баталсан Алт үндэсний хөтөлбөр эрчимжиж эхэлснээр уул уурхайн салбар олборлолтод түлхүү анхаарч байгаль орчны нөхөн сэргээлтийг орхисноор ихээхэн хэмжээний газар эвдэгдэн холбогдох эзэнгүй болсон.

2009 онд эвдэрсэн газрын тооллогоор 12 сумын 208 цэгт гар аргаар болон уул уурхайн нөлөөгөөр 708 га эвдэгдсэн байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтөд өртөж, эмзэг байгаа цөлийн болон цөлөрхөг хээрийн ургамлан бүрхэвч, малын бэлчээр, биологийн төрөл зүйлийг устгаж, мал амьтан унаж осолдох олон тооны нүх үлдэж байгалийн унаган төрх алдагдаж байгаль орчин экологид их хэмжээний хохирол учирч байна. Мөн Улсын хэмжээнд эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талаар ямар нэгэн арга хэмжээ авч дорвитой шийдэлд хүрээгүй байна. Иймд аймгийн газар нутагт байгаа эвдэрсэн газарт богино хугацаанд байгаль орчинд хохирол багатайгаар нөхөн сэргээлт хийх шаардлага урган гарч байна.

Хоёр. Журмын зорилго

2.1 Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн зохисгүй үйл ажиллагаанаас эвдэгдэн орхигдсон болон хувиараа ашигт малтмал олборлогчдын эвдсэн талбайд хаягдал металлын агууламжийг тогтоох, олборлох замаар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. Нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар

3.1 Энэхүү журмаар 2012 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө эвдэрсэн, хариуцах эзэн холбогдогч нь тогтоогдох боломжгүй болсон талбайг нөхөн сэргээнэ

3.2 Тухайн жилийн нөхөн сэргээлт хийх талбайн тоо, хэмжээ, цэг солбилцлыг аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсэг тогтоож, сумдын олон талт хамтын ажиллагааны зөвлөлийн саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна. Нэг компанийн нөхөн сэргээх талбайн хэмжээ нь

30 га-аас ихгүй байна.

Дөрөв. Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжид тавигдах шаардлага

4.1 Нөхөн сэргээлт хийх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

4.2 Мэргэжлийн геологи, экологийн мэргэжилтэнтэй байна. Экологийн мэргэжилтэн нь тухайн компаний үндсэн ажилтан байна.

4.3 Нөхөн сэргээлтийн ажилд туслан гүйцэтгэгч авахгүйгээр үйл ажиллагаа явуулах шаардлагатай ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх

4.4 Баянхонгор аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй татвар, нийгмийн даатгал, банкны хугацаа хэтэрсэн өргүй байна.

Тав. Сонгон шалгаруулалтын комисс томилох

5.1 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн захиалагч нь Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар байна

5.2 Аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах комиссыг есөөс доошгүй гишүүнтэйгээр тухай бүр нь аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр томилно.

5.3 Комиссын бүрэлдэхүүнд тухайн сумаас сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгч, сумын ИТХ-ын дарга, иргэдийн төлөөллийг оруулсан байна.

Зургаа. Зар мэдээ

6.1 Сонгон шалгаруулалтын зар мэдээг 20-оос доошгүй хоногийн өмнө орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр зарлана.

6.2 Зар мэдээнд эвдэрсэн газрын талбайн хэмжээ, уул-техникийн нөхцөл, тодорхойлолт, сонгон шалгаруулалтад оролцох аж ахуй нэгжид тавигдах ерөнхий болон тусгай шаардлага, бусад холбогдох мэдээллийг оруулна.

6.3 Зар мэдээнд мэдээллийг лавлах телефон, хаягийг тодорхой тусгана.

Долоо. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх материал

7.1 Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн албан ёсны хүсэлт;

7.2 Аж ахуйн нэгжийн танилцуулга; (бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, уул уурхайн нөхөн сэргээлт хийх ажлын туршлага, ажиллах хүчний бүтэц, бүрэлдэхүүн, байгууллагын хаяг, утасны дугаар зэргийг дэлгэрэнгүй тусгасан байна)

7.3 Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

7.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг төслөөр ирүүлнэ/. Төлөвлөгөөнд дараах зүйлүүд тусгагдсан байна. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн ажлыг эхлэх, дуусгах үе шатны календарчилсан төлөвлөгөө
- Нөхөн сэргээлтэд ашиглах техник хэрэгслийн жагсаалт /техникийн

улсын бүртгэлийн гэрчилгээ, түрээсийн гэрээ/

- Ажиллах хүчний мэдээлэл
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын хэмжээг тооцож гаргасан байна.

7.5 Сүүлийн 3 жилийн гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргаагүй тухай өмнөх захиалагчийн тодорхойлолт

7.6 Тухайн онд аймаг, суманд хийх хөрөнгө оруулалт, хандивын санал

7.7 сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан бусад шаардлагыг хангасан байх

Найм. Төсөл ирүүлэх, шалгаруулах

8.1 Оролцогч тодорхой нэгж талбайг сонгож нэг төсөл ирүүлнэ. Нэгээс дээш төсөл ирүүлсэн бол тухайн төслөөс татгалзана.

8.2 Сонгон шалгаруулалт нь төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 20 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

8.3 Захиалагч төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн аливаа төслийг “хугацаа хоцорсон” гэж үзэж буцаана.

8.4 Төслийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг тухайн төсөл шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй хүнд задруулахыг хориглоно.

8.5 Захиалагч нь сонгон шалгаруулалтын бичиг баримтын шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон төслөөс татгалзаж оролцогчид ажлын 10 хоногт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

8.6 Оролцогч журмын 8.7-д заасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ажлын 5 хоногт багтаан захиалагчид бичгээр гомдол гаргана.

8.7. Захиалагч “шаардлагад нийцсэн” хамгийн сайн төсөл ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

8.8 Захиалагч нь талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан гэрээний маягыг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан оролцогчид илгээнэ.

Ес. Гэрээ байгуулах

9.1 Шалгарсан аж ахуйн нэгж ажлын 14 хоногт багтаан аймгийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.2 Гэрээний нэг оролцогч тал нь Баянхонгор ньуу Майнинг ОНӨХХК байна.

9.3 Гэрээнд шалгарсан компани болон сум орон нутгийн эрх үүргийг зааж өгнө.

9.4 Нөхөн сэргээлт хийх аж ахуй нэгж нь нэг га тутамд 5 сая төгрөгийн барьцаа хөрөнгө санал болгосон хөрөнгө оруулалт, хандивыг гэрээнд заасан дансанд төвлөрүүлсэн байна.

9.5 Төвлөрүүлсэн хандивын 20 хувийг тухайн суманд шилжүүлнэ.

9.6 Гэрээг жил бүрийн 11-р сарын 10-ны дотор дүгнэж гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн тохиолдолд барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид буцаан олгоно.

9.7 Нөхөн сэргээлтийн ажлыг тухайн оны 4 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 01-ний хооронд хийнэ.

Арав. Хяналт шалгалт

10.1 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Тухайн сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумдын олон талт хамтын ажиллагааны зөвлөл, “Баянхонгор ньу майнинг” ОНӨХХК-ийн төлөөллийг оролцуулан аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

10.2 Энэ журмын 10.1-т заасан ажлын хэсэг нь хамтарсан хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдалд шуурхай арга хэмжээ авч ажиллана.

10.3 Нөхөн сэргээлт хийх газрын хил заагийг Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын даамал нар GPS багажаар хэмжиж хилийн шав тэмдэг тавьж өгснөөр тухайн аж ахуй нэгжийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах эрх нь нээгдэнэ.

10.4 Гүйцэтгэгч 10.3-т заасан талбайн гадна талд хөрс хуулсан тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

10.5 10.4-т заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд барьцаа мөнгийг буцаан олгохгүй.

Арван нэг. Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах

11.1 Нөхөн сэргээсэн талбайг хүлээн авахдаа “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008” стандартуудын дагуу аймгийн комисс хүлээн авч дүгнэлт гаргана.

11.2 Нөхөн сэргээлтийг дууссаны дараа тухайн компани үйл ажиллагааны тайлан бичиж захиалагч буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Арванхоёр. Бусад зүйл

12.1 Энэхүү журам нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.